

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Орхон аймаг

2023 оны 12 дугаар сарын 08

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Эрүүл мэндийн газрын 2023 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, удирдлага, мэргэжилтнүүдийг бодит мэдээлэл, санал зөвлөмжөөр хангахад оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”, “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 374 дүгэр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам, аймгийн Засаг даргын “Журам шинэчлэн батлах тухай” 2022 оны 750 дугаар захирамжийг тус тус үндэслэн Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Эрүүл мэндийн газрын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам батлах тухай” А/346 дугаар тушаалын дагуу дараах 5 үндсэн чиглэлийн хүрээнд гүйцэтгэсэн болно. Үүнд:

1. Тухайн байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
3. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт
5. Хэрэглэгчийн үнэлгээ.

ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Нэг. Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилт

Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу боловсруулан Засгийн газрын урт хугацааны бодлого Алсын хараа-2050, Орхон аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргын 2022 онд хамтран ажиллах гэрээ зэрэг бодлогын баримт бичиг болон аймгийн Засаг даргаас өгөгдсөн үүрэг чиглэл тусгагдсан бөгөөд Эрүүл мэндийн газрын Удирдлагын зөвлөлөөр 2 удаа хэлэлцүүлэн аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст

хүргүүлэн хянуулж, аймгийн Засаг дарга С.Батжаргалаар баталгаажуулан хэрэгжүүлж ажилласан.

2023 оны Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Эрүүл мэндийн газрын стратеги төлөвлөгөөний зорилтын дагуу 5 хэсэгт 32 зорилтын хүрээнд 96 үйл ажиллагаа тусгагдсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувийг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, 2023 он

№	Үндсэн чиг үүрэг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээ
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт	14	56	95,0
2	Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	8	13	88.8
3	Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	4	15	97,9
4	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ	4	12	100
	Нийт	30	96	95,4

Тус төлөвлөгөөнд аймгийн Засаг даргаас өгсөн 14 үүрэг даалгаврыг тусган хэрэгжүүлсэн ба хэрэгжилт 98,5%-тай байна.

Дүгнэлт: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгтгэн дүгнэв.

Тайланд хугацаанд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 96 үйл ажиллагааны хэрэгжилт дунджаар 95,4%-тай буюу (тодорхой үр дүн хүрсэн) гэж үнэлэгдсэн.

Хоёр. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийг хангах хөтөлбөрийн биелэлт

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийг хангах хөтөлбөрийн биелэлтийг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 346 дугаар тушаалын 3.6 дугаар хавсралтын дагуу 2 зорилтын хүрээнд 7 арга хэмжээний хэрэгжилтийг хянан үзэж, 93,6 хувиар үнэлэв.

Хүснэгт 2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, хувиар

Зорилт	Үйл ажиллагаа	Үнэлгээ %
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх	Засгийн газраас төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	100

	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	85
	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	85
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	70
	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	100
	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	100
	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	100
Дундаж үнэлгээ		91,4%

Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх, нийгмийн баталгааг хангах чиглэлээр бусад орон нутгаас давуу тал нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор “Эмч” хөтөлбөрийн 2021-2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг баталсан. Аймгийн Засаг даргын 2022 оны А/184 дүгээр тушаалаар Эмч хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөө, төсвийг /175,0 сая/ батлуулан хэрэгжүүлэн ажилласан. Эмч” хөтөлбөрийн нь 2 зорилтын 17 арга хэмжээ бүхий 2023 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан. Энэхүү 2023 оны төлөвлөгөөнд сурч хөгжих, судалгаа шинжилгээ хийх, судалгаа шинжилгээний ажлыг нийтийн хүртээл болгох, эрүүл мэндийн байгууллагын менежмент, манлайллыг хөгжүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтний гадаад хэлний боловсролд сайтар анхаарсан байна. “Эмч” хөтөлбөрийн хэрэгжилт 96,5%-тай тодорхой үр дүнд хүрсэн хэрэгжсэн. Тус хөтөлбөр хэрэгжсэнээр тодорхой үр дүнд хүрч ахиц гарсан байна. Үүнд:

- Тайлант хугацаанд төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 13,1 байгаа нь өмнөх оноос 0,6%-аар нэмэгдсэн.
- Нийгмийн дэмжлэгт хамрагдсан хувь 24.4% байна.
- 2022-2023 оны хичээлийн жилд “Яаралтай тусламжийн сувилахуй”-аар 8, “Эрчимт эмчилгээний сувилахуй”-аар 8 суралцагчийг төгсгөж, “Яаралтай тусламжийн сувилахуй”-аар 4, “Эрчимт эмчилгээний сувилахуй”-аар 1 сувилагч суралцаж байна.
- Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд докторын зэрэгтэй эмч 5, магистрын зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн 81, зөвлөх зэрэгтэй 10, тэргүүлэх зэрэгтэй 90, ахлах зэрэгтэй 123 эмч, эмнэлгийн мэргэжилтэн байгаа нь нийт эмнэлгийн мэргэжилтний 18,8%-ийг эзэлж байна.
- Эрүүл мэндийн салбарын ажилчдын 92% нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1%-аар өссөн байна.

Дүгнэлт: Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийг хангах хөтөлбөрийн биелэлт 91,4%-ийн гүйцэтгэлтэй байна.

Гурав. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт

Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 346 дугаар тушаалын 3.7 дугаар хавсралтын дагуу тайлагнасан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн 5 төрлийн 46 мэдээлэл тус бүрээр хянан үзэж, үнэлэхэд хэрэгжилт дунджаар 93,8%-тай байна. Үүнд:

1. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал-97%
2. Хүний нөөцийн мэдээллийн ил тод байдал-95%
3. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх ил тод байдал-97,8%
4. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдал - 85%
5. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал-94%

3 мэдээллийн хэрэгжилт эрүүл мэндийн салбарын хэмжээнд гарах боломжгүй байна. Үүнд:

- 5.9 Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт- Тайлант хугацаанд шинээр ашиглалтад орсон барилга байгууламж байхгүй.
- 5.10 Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ-Байхгүй
- 5.12 Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт-Тайлант хугацаанд байгууллагын зардлаар суралцсан суралцагч байхгүй.

Тайлант хугацаанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжилтийг хангах хүрээнд тус хуулийн дагуу 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллүүдийг шинэчлэн байршуулсан. Байгууллагын ил тод байдлын чиглэлээр 2 удаагийн хяналт хийгдэж зөвлөмжөөр хангагдсан байна. Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны “Журам батлах тухай” А/83 дугаар тушаалаар байгууллагын цахим хуудсыг хөтлөх журам, цахим хуудаст мэдээ мэдээллийг боловсруулж, бэлтгэх үүрэг бүхий албан хаагчдын нэрсийг батлуулсан зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн сайн талтай байна.

Дүгнэлт: Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт дунджаар 93,8%-тай тодорхой үр дүнд хүрсэн үнэлэгдэв.

Дөрөв. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 346 дугаар тушаалын 3.6 дугаар хавсралтын дагуу 43 шалгуур үзүүлэлтийг 2023 оны эхний 11 сарын байдлаар өмнөх онтой харьцуулан гаргасан. Нийт 43 шалгуур үзүүлэлтээс 30 буюу 69,8% нь зорилтот түвшинд хүрсэн, өмнөх оны мөн үеэс сайжирсан шалгуур үзүүлэлт байна. Үүнд:

1. Эхийн эндэгдэл бүртгэгдээгүй.
2. 2023 онд артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт 47765 /90.0%/ хүн хамрагдаж өмнөх оноос 47.8 хувиар өссөн байна.
3. Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт эхний 11 сарын байдлаар 27420 хүн хамрагдаж өмнөх оноос 57.5 хувиар өссөн.
4. Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт 16527 эмэгтэй хамрагдаж өмнөх оны мөн үеэс 50.6 хувиар өссөн.
5. Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт эхний 11 сарын байдлаар 2931 эмэгтэй хамрагдаж өмнөх оны мөн үеэс 79.2 хувиар өссөн.
6. Элэгний хорт хавдрын өвчлөлийн эрт илрүүлгийн үзлэгт 887 хүн буюу 54.8 хувь нь хамрагдаж өмнөх оны мөн үеэс 49.9 хувиар нэмэгдсэн байна.
7. Өрхийн, сумын эрүүл мэндийн төвийн нийт үзлэгт гэрийн эргэлтийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар өссөн.
8. Товлолт дархлаажуулалтад хамрагдаж 99.8 хувьтай өмнөх оны мөн үеэс 1%-аар нэмэгдсэн байна.
9. Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь 98,3% болж өмнөх оноос 1.8 хувиар өссөн
10. Эхийн эндэгдэл бүртгэгдээгүй.
11. Нийт 9 амьгүй төрөлтийн тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 0.5 промиллоор буурсан.
12. Төрсний дараах эхний 1 минутад Апгарын оноо 3 болон түүнээс доош байсан нярайн эзлэх хувь 0,7% болж, өмнөх оны мөн үеэс 0,2%-аар буурсан.
13. Төрсний дараах эхний 5 минутад Апгарын оноо 3 болон түүнээс доош байсан нярайн эзлэх хувь 0,4% болж өмнөх оны мөн үеэс 0,4%-аар буурсан.
14. Өсвөр насны 1 000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин 15.8 байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.4 промиллоор буурсан.
15. 15-49 насны 1000 эмэгтэйд ногдох үр хөндөлтийн түвшин 7.9 нь үр хөндүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 6.9 промиллоор буурсан.
16. 1000 жирэмсэнд ногдох үр хөндөлтийн түвшин 140.6 болж 106,5 промиллоор буурсан байна.
17. Өсвөр насны үр хөндөлтийн түвшин 1000 өсвөр насны охидод 3.3 байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.8-аар буурсан.
18. Ходоодны шархлаа өвчний шалтгаант нас баралтын түвшин 10 000 хүн амд 0.1 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.2 промиллоор буурсан байна.
19. Гуурсан хоолойн багтраа өвчний шалтгаант нас баралт бүртгэгдээгүй.
20. Мухар олгойн шалтгаант нас баралт бүртгэгдээгүй
21. Цэсний чулуу, цэсний үрэвслийн шалтгаант нас баралт бүртгэгдээгүй.

22. Зүрхний шигдээсийн нас баралтын түвшин 10 000 хүн амд 2.3 байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.3 промиллоор буурсан.
23. Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин 10 000 хүн амд 10.7 промилл өмнөх оны мөн үеэс 19 тохиолдлоор буюу 1.8 промиллоор буурсан.
24. Амиа хорлож нас барсан тохиолдол 5 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 14 тохиолдлоор буюу 1.3 промиллоор буурсан.
25. Өсвөр насны амиа хорлолтын 1 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 0.38 промиллоор буурсан.
26. Зам тээврийн ослын шалтгаант нас баралт 10 000 хүн амд 0.3 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.2 промиллоор буурсан.
27. Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралт өнгөрсөн оны мөн үеэс 2.2 промиллоор буурсан.
28. 10 000 хүн амд ногдох сувилагчийн тоо 43.1 байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.3 промиллоор нэмэгдсэн.
29. Тухайн жилд тасралтгүй сургалтын багц цагийн шаардлага хангасан хувь 81,9% болж өмнөх оны мөн үеэс 5%-аар нэмэгдсэн.
30. Мөн өмнөх оны мөн үеэс үзүүлэлт буурсан боловч Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргын 2023 онд хамтран ажиллах гэрээний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн зорилтот түвшинд хүрсэн 1 үзүүлэлт байна.

Хүснэгт 3. Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргын 2023 онд хамтран ажиллах гэрээнд зааснаар зорилтот түвшинд хүрсэн үзүүлэлт

№	Чанарын үзүүлэлт	2023.11 сарын байдлаар хүрсэн түвшин	Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргын 2023 онд хамтран ажиллах гэрээний Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний 2023 онд хүрэх чанарын үзүүлэлт
1	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин	17,5	19,0

31. Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв 8 өрхийн эрүүл мэндийн төвүүд өр төлбөргүй батлагдсан төсөвт багтаан ажилласан. Сумын эрүүл мэндийн төвийн хувьд 1.9 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байгаа нь даатгалын ерөнхий газрын гүйцэтгэлийн санхүүжилт орж ирээгүй хянагдаж байгаатай холбоотой үүссэн бөгөөд 2023 ондоо багтаан шийдвэрлэгдэнэ.

Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн, Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргын 2023 онд хамтран ажиллах гэрээний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний 2023 онд хүрэх чанарын үзүүлэлтэд хүрээгүй боловч улс, аймгуудын дунджаас доогуур, “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2025 онд хүрэх түвшинд хүрсэн үзүүлэлт бүхий шалгууруудаас дурдвал:

1. Нялхсын эндэгдлийн түвшин: Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдлийн 17 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 8,2 промилл, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8 тохиолдлоор буюу 3.9 промиллоор нэмэгдсэн үзүүлэлттэй боловч улсын дунджаас 4 промиллоор, аймгуудын дунджаас 2.5 промиллоор бага байна. /"Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны бодлогод 2025 онд нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 9 болж бууруулах зорилго тавьсан/
2. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин: 2023 оны эхний 11 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 20 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлт тутамд 9,6 промилл, өмнөх оны мөн үеэс 10 тохиолдлоор буюу 4.8 промиллоор нэмэгдсэн боловч улсын дунджаас 5,2 промиллоор, аймгуудын дунджаас 4,5 промиллоор бага үзүүлэлттэй байна.
3. Вируст гепатитын өвчлөлийн түвшин (10 000 хүн амд): Вируст гепатит 7 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 0.7 промилл байна. /"Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны бодлогод 2025 онд вируст гепатитын өвчлөлийг 2,5 промиллд хүргэх зорилт тавьсан/

Дүгнэлт: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт 78.3%-ийн гүйцэтгэлтэй байна.

Тав. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ

- Эрүүл мэндийн байгууллагуудын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд нийт 1962 хүн оролцсоноос үйлчлүүлэгч 1795 /91,5%/, эмч, эмнэлгийн ажилтан 167 буюу /8,5%/, хүн хамрагдсан байна. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 91,3%-тай байна. /Хэрэглэгчийн үнэлгээг хавсаргав/
- Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг sudalгаа.1313.mn цахим системээр Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд QR код үүсгэн, байршуулж, үйлчлүүлэгч иргэдийг сэтгэл ханамжийн судалгаанд хамруулсан. Тус судалгаагаар тайлант хугацаанд хэвтэн эмчлүүлсэн 82 иргэний эмнэлгийн тусламж үйлчилгээний сэтгэл ханамж маш сайн гэж 40,2%, сайн гэж 51,2% нь хариулсан байна. Амбулаториор үйлчлүүлсэн 1055 иргэний эмнэлгийн тусламж үйлчилгээний сэтгэл ханамж маш сайн гэж 52,79%, сайн гэж 28,37% нь үнэлсэн байна.

Дүгнэлт: Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 91,3%-тай байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Эрүүл мэндийн газрын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 95.4%,

байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт 93.7%, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт 76,3%, хэрэглэгчийн үнэлгээ 91,3 хувьтай, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт 91,4 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт 4. Эрүүл мэндийн газрын 2023 оны үйл ажиллагааны үнэлгээний дүн

№	Үзүүлэлт		Хэрэгжилтийн хувь
1	Байгууллагын үйл ажиллагаа	Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	95.4
2		Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	91,4
3		Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ	93.7
4		Хэрэглэгчийн үнэлгээ	91,3
5		Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт	78,3
Ерөнхий үнэлгээ			90,02

Эрүүл мэндийн газрын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн цаашид дор дурдсан асуудалд анхаарал хандуулж, удирдлага, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг ЗӨВЛӨМЖ болгож байна.

Нэг. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах талаар:

- Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын мөн оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтад заасан аргачлалын дагуу байгууллагын гүйцэтгэлийн 2024 оны төлөвлөгөөг боловсруулахдаа төлөвлөгөөний зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодитой, биелэгдэхүйц, шалгуур үзүүлэлт нь тодорхой, хэмжигдэхүйц байхаар төлөвлөхөд анхаарах;
- Байгууллагын өмнөх жилийн гүйцэтгэл, тулгамдаж байгаа асуудал зэргийг нарийвчлан судалж төлөвлөлтөд ашиглах;
- Төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, түүний эх үүсвэрийг үндэслэл, тооцоо, судалгаанд үндэслэн бодитой төлөвлөх;

Хоёр. Байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах, сайжруулах чиглэлээр:

- Иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах үйл ажиллагаанд 18-аас дээш насны хамрагдвал зохих иргэдийг бүрэн хамруулах, илэрсэн өвчлөлийг хяналтад авч эмчлэн эрүүлжүүлэхэд анхаарах;

- Нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр тандалт, судалгааг өргөжүүлж, нотолгоонд суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, орон нутгийн болон эрүүл мэндийг дэмжих сан, олон улсын төсөл хөтөлбөрийг татан санхүүжилтийг шийдвэрлүүлэх;
- Нийгмийн ноцтой байдал, шинээр болон дахин сэргэж буй халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний чиглэлээр эрүүл мэндийн ажилтнуудад тасралтгүй байдлаар “сэргээх” сургалтыг зохион байгуулах;
- Уламжлалт анагаах чиглэлээр шинээр байгуулагдсан Удирдлага-Нөлөөллийн багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, уламжлалт анагаах ухааны хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх, дэмжихэд чиглэсэн санал санаачилгыг өрнүүлэх;
- Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн 2023-2024 оны төлөвлөлт, хэрэгжилтийг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, “Хамтдаа Эрдэнэтэд хөгжье” хөтөлбөрийг хэрэгжүүлэн Улаанбаатар хотоос орон нутагт шилжин ирж буй эрүүл мэндийн ажилтныг дэмжих ажиллах;
- Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн бус байгууллагуудад зарим төсөлт ажлыг гэрээгээр гүйцэтгүүлж, үр дүнг тооцож ажиллах;
- Эрүүл мэндийн бодлого шийдвэр, улс, орон нутгаас хийж буй хөрөнгө оруулалт, түүний үр дүн, цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээг иргэдэд тогтмол сурталчлах;
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний доголдож буй үзүүлэлт дээр дүн шинжилгээ, тулгамдсан зарим асуудалд судалгаа хийж, сайжруулах төлөвлөлтийг хийж хэрэгжүүлэх;
- Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хяналт тавих, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудад хуваарь гарган сургалт хийх;

Гурав. Хэрэгжилтийн тайлагналыг сайжруулах талаар

- Арга хэмжээний биелэлтийг гаргахдаа зөв оновчтой томъёолж, 2000 тэмдэгтэд багтаан, үр дүнг үнэн зөв, хугацаандаа тайлагнах, тайлагнахдаа тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцөлийг тодорхой дурдах, шаардлагатай тохиолдолд файлаар хавсралтаар ирүүлж байх;
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг богино хугацааны үр дүн, дунд хугацааны үр нөлөөг илэрхийлэх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн, үнэн зөв тайлагнаж байх

- Санхүүжилтийн гүйцэтгэл, эх үүсвэрийг арга хэмжээ бүрээр бүрэн тайлагнаж, жилийн эцсийн байдлаарх өссөн дүнг хагас жилийн гүйцэтгэлтэй тулган хянаж байх

Дөрөв. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

- Шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн, үнэн зөв, бодитой, тодорхой тайлагнаж, шаардлагатай материалуудыг хавсралтаар тайлагнах
- Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөл, ажиллах таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүнг албан хаагчдад танилцуулан мэдээллээр хангаж санал асуулгын мөрөөр үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах

Тав. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын талаар:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний доголдож буй үзүүлэлт бүр дээр судалгаа хийж, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах төлөвлөлтийг хийж 2024 оны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх
- Аймгийн эрүүл мэндийн салбарын Эрдэм шинжилгээний зөвлөлтэй хамтран эмнэлгийн тусламж үйлчилгээний доголдож буй чанарын үзүүлэлт дээр тулгуурлан 2-3 судалгааг хийж, нотолгоонд үндэслэн бодлого төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх
- Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, чанар сайжруулах чиглэлээр сургалтыг тасралтгүй зохион байгуулах, тасралтгүй суралцах үйл ажиллагааг хэрэгжүүлэх,

Зургаа. Хэрэглэгчийн үнэлгээ:

- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллагууд дотооддоо өөрийн үзүүлж буй тусламж үйлчилгээний чиглэлээр хэрэглэгчийн үнэлгээг тогтмол зохион байгуулж, чанар сайжруулах арга хэрэгслээ болгон, үнэлгээний дүнгийн мөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг 2024 оны байгууллагын төлөвлөгөөндөө тусган ажиллах;
- Эрүүл мэндийн байгууллагууд үйлчилгээ авсан иргэдийг хэрэглэгчийн үнэлгээний цахим системд хэрэглэгчийн үнэлгээнд хамрагдах талаар санаачилгатай ажиллах;

Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах талаар:

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.9, 8.10, 8.11-т заасны дагуу хуулийн заасан хугацаанд байршуулж, шинэчлэлт хийж байх, тус хуулийн 8.14-т заасны дагуу мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулж, бүртгэл хөтлөх
- Тус хуулийг албан хаагчдад сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
- Байгууллагын цахим хуудсыг “Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 6285:2017 стандарт”-ын дагуу хөтөлж, хэвших

- Байгууллагын цахим хуудаст хандах, дагах иргэдийн тоог нэмэгдүүлэх, НЭМТ-ийн хэвлэлийн студийг бүрэн ашиглах, мэргэжилтэн бүр хийж буй ажлаа сурталчлах, эрүүл мэндийн салбарыг татан оролцуулах

Эрүүл мэндийн газар

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Орхон аймаг

2023 оны 12 дугаар сарын 12

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, иргэн бүрийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.							
Зорилт 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.							
1	1.1.1. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллах эрүүл мэндийн хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлж, чадавхыг бүрдүүлэх		Сургалтад хамрагдсан хүний тоо	14	20	Аймгийн Засаг даргын захирамжаар 2023 оны А/84 дүгээр захирамжаар Эрүүл мэндийн газрын бүтэц дэх Нийгмийн эрүүл мэндийн төв нь 10 эмч, эмнэлгийн мэргэжилтний орон тоотойгоор аймгийн хүн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг удирдлага арга зүйгээр ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд Нийгмийн эрүүл мэндийн төвд 1 мэргэжилтэн шинээр ажилд авч хангалтыг нэмэгдүүлсэн. Нийгмийн эрүүл мэндийн төвийн 2 мэргэжилтэн АШУҮИС-ийн мэргэжил дээшлүүлэх институтэд 6 сарын мэргэшүүлэх сургалтад хамрагдсан. Тайлант хугацаанд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр зайн болон танхимын сургалтад 97 эмч, эмнэлгийн мэргэжилтэн тус тус хамрагдлаа. Сум, өрхийн эрүүл мэндийн төв болон сургууль цэцэрлэгийн 140 эмч, сувилагчийг хамруулан уулзалт ярилцлага, сургалтыг 24 удаа зохион байгуулж шинэ мэдээлэл, арга зүйгээр хангасан.	100
2	1.1.2. Хүн амын дунд эрүүл мэндийн суурь судалгааг хийж, түүнд түшиглэсэн эрүүл мэндийг дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлэх ⁴		Суурь судалгааны дүн	1	1-2	Эрдэм шинжилгээний бага хурлыг жил тутам зохион байгуулж ирсэн бөгөөд 2021-2022 онд 66 илтгэл хэлэлцүүлснээс улсын хэмжээнд 2 илтгэл хэлэлцүүлэгдэж, 3 суурь судалгаа хийгдсэн. 2023 оны байдлаар эрдэм шинжилгээний бага хурлаар 36 илтгэл хэлэлцүүлэгдсэн. Тайлант хугацаанд 3 судалгаа хийгдсэнээс: - Эрүүл мэндийн салбарын 21 байгууллагын 405 эмч эмнэлгийн мэргэжилтний ажлаас халшрах хам шинжийг	100

						<p>илрүүлэх судалгаагаар үйлчлүүлэгчдийг сэтгэлээрээ мэдрэх чадвар буурах шинжийн хувьд 36.9% өндөр, 22.5% дунд, хувь хүний бүтээмж буурах байдал 31.2% өндөр, 17.6% нь дунд, бие хүний сэтгэл хөдлөлийн өөрчлөлтийн шинжээрээ 13.4% нь өндөр түвшинд, 25% нь дунд үүнээс 4% нь ажлаас халшрах хам шинжтэй, 3.7% ажлаас халшрах хам шинжид өртөх магадлал өндөр байна. Судалгааны дүнд дүгнэлт хийж, сэтгэл зүйн сургалт, ярилцлага зохион байгуулан 25 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Монгол улсын хүн амын хоол тэжээлийн байдал үндэсний 6-р судалгаанд 288 иргэний хоол тэжээлийн үнэлгээ хийгдсэн. - “Зөвийг дадал болгоё” төслийн хүрээнд сургууль, цэцэрлэгийн 200 хүүхэд, 600 эцэг эхийг хамруулсан амны хөндийн эрүүл ахуйн талаарх мэдлэг хандлага дадлыг үнэлэх судалгаагаар оо, сойзыг тогтмол хэрэглэдэг. Мөн туслах хэрэглэгдэхүүн шүдний утсыг 54,3% (n=100) нь хэрэглэдэг, асран хамгаалагчийн мэдлэг 87,2%, хандлага 75.9%, дадал 64.7%-тай байна. 	
3	1.1.3. Иргэдийг хөдөлгөөний хомсдол, сэтгэцийн эрүүл мэндийн сөрөг нөлөөлөл, төрөл бүрийн донтолт, хамаарлаас урьдчилан сэргийлэх төсөл хэрэгжүүлэх	ОНТ 4.0	Хэрэгжүүлсэн төсөл	2	2	<p>Тайлант хугацаанд 4 төслийг хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Сэтгэлийн анир III төслийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 100 эцэг эх, 8 -12 ангийн 726 хүүхдийг сэтгэл зүйн судалгаанд хамруулж, 12 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө, 150 иргэнд бүлгийн ярилцлага 78 иргэнд сургалт зохион байгуулж, 15 шторка 2 контент, 3 нэвтрүүлэг, 47 гаруй цахим зөвлөмжийг бэлтгэн нийт давхардсан тоогоор 5600 гаруй иргэнд цахимаар хүргэсэн. - “Сонсьё, мэдэрье, ойлгоё” аяны хүрээнд ерөнхий боловсролын 23 сургуулийн 16000 гаруй бүх насны сурагчид сэтгэл зүйн цогц тусламж үйлчилгээг үзүүлсэн. - “Сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг хүн бүрд” аяны хүрээнд СЭМҮТ-тэй хамтарсан 3 төрлийн сургалтад төрийн байгууллагын албан хаагч, 2 сургуулийн 2 болон 7-р ангийн сурагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хамгаалагч болон багш нийт 345 хүн хамрагдсан. Мөн 16 видео сурталчилгаа, 34 цахим зөвлөмжийг цахимаар байршуулан давхардсан тоогоор 600415 иргэнд хүргэж, сургалтад 1539 хүнийг хамруулж, 1000 гаруй гарын авлага ттүгээж ажилласан байна. 	100

						<ul style="list-style-type: none"> - “Энэ жилдээ эрүүл жиндээ” аяны хүрээнд жин бууруулах 1 сарын уралдаанд 10 байгууллагын 60 хүн хамруулж зохион байгуулснаар аяны хугацаанд оролцогчид нийт 93,4 кг жин хаясан. - Аймгийн Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд "Би хорт зуршилгүй залуу" аяны хүрээнд ерөнхий боловсролын 5 сургуулийн ахлах ангийн сурагчдад электрон тамхины хор нөлөөгөөр сургалт зохион байгуулсан. <p>Орхон аймгийн явган алхалтын холбоотой хамтран “Орхон 100 км”, “Туг аялуулах хөтөлбөр”, “Эрүүл мэнд эко гороо аялал”, “Эмчтэй хамт алхъя”, “Таны хөл бол эмч юм” гэх мэт 10 гаруй алхалтыг иргэдийн дунд зохион байгуулж, давхардсан тоогоор 3000 орчим иргэнийг хамруулсан.</p>	
Зорилт 2. Иргэн бүрийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд үе шаттайгаар хамруулах арга хэмжээг орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулах							
4	1.2.1. Иргэн бүрийг жилд 1 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажилд бүх шатны төрийн болон аж ахуй нэгж байгууллагын оролцоог сайжруулан, үүрэг хариуцлага, үр дүнг тооцон ажиллах ^{1,2}	ОНТ 90.0	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	34,4%	40%	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 673698 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 229454 хийгдэж, нийт үзлэгийн 34,1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0,3 хувиар буурсан. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг 89.5 хувь болж өмнөх оны мөн үеэс 57.0 хувиар нэмэгдсэн байна. 53 төрийн болон аж ахуй нэгж байгууллагын 1498 албан хаагчдыг эрт илрүүлэгт хамруулан хамтран ажиллаж эрт илрүүлэг үзлэг 9,6 хувиар нэмэгдсэн. Аймгийн Засаг даргын А/656 тоот захирамжаар “Эрүүл Эрдэнэт хүн” тусламж үйлчилгээний төслийг хэрэгжүүлэхээр 90.0 сая төгрөгийг шийдвэрлэн хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмаар өрхийн эрүүл мэндийн төвийг түшиглэн 31074 иргэнд 13 төрлийн тусламж үйлчилгээг үзүүлснээс эрүүл мэндийн даатгалгүй 955 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.	85,2
5	1.2.2. Улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт аймгийн иргэдийг насны бүлгээр бүрэн хамруулах, энэ чиглэлд ажил олгогчид болон салбар дундын хамтын		Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн хамралтын хувь	23,3%	40%	Аймгийн хэмжээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэ медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баян-Өндөр мед болон сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт иргэдийг хамруулж ажилласан. Тайлант хугацаанд 43660 иргэн буюу нийт хүн амын 41,1 хувь нь үзлэгт хамрагдсанаас 0-17 насны хүүхдийн 74,5% үзлэгт бүрэн хамрагдаж улсын хэмжээнд хүүхдийн үзлэгээр тэргүүлж байна. 18-аас дээш насанд 16197 хүн хамрагдаж хамруулахаар төлөвлөсөн хүн амын 23,5% үзлэгт бүрэн хамрагдсан. Үзлэгээр 26492 хүнд зөвлөгөө өгч, 3894	100

	ажиллагааг манлайлж ажиллах ⁵					<p>хүнийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад, 6633 хүнийг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт шилжүүлсэн байна.</p> <p>Хүүхдийн үзлэгээр амны хөндийн өвчлөл, насанд хүрэгсдийн үзлэгээр хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл тэргүүлж, аймгийн хэмжээнд эрт илрүүлэг, үзлэгээр 38 хавдрыг /Улаан хоолой 9, ходоодны хавдрын 29/ эрт үед нь илрүүлж, 21 хавдрыг Орхон аймагт салс хуулах хагалгаагаар эмчлэн эрүүлжүүлсэн байна.</p> <p>Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж буй анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэгт хяналтыг хийж зөвлөмжөөр ханган ажилласан ба зөвлөмжийн хэрэгжилт 54%-тай байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 53 төрийн болон аж ахуй нэгж байгууллагын 1498 албан хаагчдыг эрт илрүүлэгт хамруулан хамтран ажиллаж эрт илрүүлэг үзлэг 9,6 хувиар нэмэгдсэн. Мөн их дээд сургуулийн 342 оюутан сурагчдыг эрт илрүүлэг үзлэгт хамруулан үзлэгийн хамрагдалт 4.7 хувиар нэмэгдсэн. Эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог идэвхжүүлэхээр Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нийт 5 дуран шинээр авсан ба Бүсийн оношилгоо эмчилгээний төв дурангийн нэгдсэн кабинетыг нээн үзлэгийн хүлээгдлийг бууруулсан. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэгийн 34 төрлийн гарын авлага, шторк, зөвлөмжийг байршуулан 44645 иргэнд зөвлөмж түгээн ажилласан. Аймгийн Засаг даргын А/656 тоот захирамжаар “Эрүүл Эрдэнэт хүн” тусламж үйлчилгээний төслийг хэрэгжүүлэхээр 90.0 сая төгрөгийг шийдвэрлэн хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмаар өрхийн эрүүл мэндийн төвийг түшиглэн 31074 иргэнд 13 төрлийн тусламж үйлчилгээг үзүүлснээс эрүүл мэндийн даатгалгүй 955 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.</p>	
6	1.2.3. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг /хөх, умай, чихрийн шижин, цусны даралт ихсэх/ үзлэгийг эрчимжүүлэх ^{3,4,5}		Эрт илрүүлгийн хувь	40,5%	42%	<p>Тайлант хугацаанд хөх, умайн хүзүү, элэгний хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт ихсэх зэрэг өвчнийг эрт илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан. Тайлант хугацаанд халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг 89.5 хувь болж өмнөх оны мөн үеэс 57.0 хувиар нэмэгдсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 18-с дээш насны нийт 47765 буюу хамрагдвал зохих хүн амын 90.0 	100

						<p>хувийг эзэлж, өмнөх оноос (47.8) хувиар өсч үр дүнгийн үзүүлэлтээр 0.9 хувь нь онош батлагдсан.</p> <ul style="list-style-type: none"> - Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 40-дээш насны нийт 27420 буюу хамрагдвал зохих хүн амын 109.7 хувийг эзэлж, өмнөх оноос (57.5) хувиар өсч, үр дүнгийн үзүүлэлтээр 0.4 хувь онош батлагдсан байна. - Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 2931 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 105.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс (79.2) хувиар өссөн. Пап шинжилгээнд нийт 1215 сорьц хүлээн авсан байна. - Хөхний эрт илрүүлэг үзлэгт 16527 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 87,4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс (50,6) хувиар өссөн байна. - Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 887 хүн буюу (54.8) хувь нь хамрагдсан. <p>Илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх хүрээнд 80 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, аймгийн Засаг даргын А/793 тоот захирамжаар “Иргэн бүр зүрхээ хайрлая” аяныг зохион байгуулах 10,0 сая төгрөгийг шийдвэрлүүлэн төрийн болон хувийн хэвшил, анхан шатны байгууллагын 100 эмчийг сургалтад хамруулж, 9 төрлийн контент, шторкыг бэлтгэн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 10 удаагийн давтамжтай нэвтрүүлж, эрүүл мэндийн байгууллагын цахим хуудсаар давтагдсан тоогоор 161366 иргэнд түгээж ажилласан. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, сэргийлэх чиглэлээр 35 төрлийн постер, зөвлөмжийг 3200 иргэнд, цахимд 131 төрлийн гарын авлага, шторк, зөвлөмжийг байршуулан давхардсан тоогоор 443651 иргэнд хүргэж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 24 удаагийн ярилцлагыг иргэдэд хүргэсэн.</p>	
7	1.2.4. Сүрьеэгийн эрт илрүүлэлтийн хувийг зорилтот түвшинд хүргэх, далд хэлбэрийн сүрьеэг илрүүлэх арга хамжээг зохион байгуулж, үр дүнг тооцох ⁵	ОНТ 8.0	Сүрьеэгийн эрт илрүүлэлтийн хувь	87	87,2%	<p>Тайлант хугацаанд сүрьеэгийн өвчлөл 59 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 5,6 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0,8 промиллоор нэмэгдсэн. Тус хугацаанд нийт хийгдсэн үзлэгээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн дундаж хувь 82,5% байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Сүрьеэгийн диспансераар 4267 үзлэг хийгдсэнээс 3345 буюу 78.4% нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан байна. 	90

						<p>- Сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгийг сум, өрхийн эрүүл мэндийн төв, Цагдаагийн ерөнхийн газартай хамтран 3 удаа зохион байгуулж 926 иргэнийг цээжний рентген, хавьтлын 64 иргэнд туберкулины сорил тавьж цээжний рентгенд өөрчлөлттэй 40 иргэнээс цэрний сорьцод шинжилгээ хийв. Үүнээс сүрьеэгийн 8 тохиолдол, 4 далд халдвар илэрч нийт 11 тохиолдлыг эмчилгээнд хамруулсан.</p> <p>Сүрьеэгийн диспансерын хяналтад 37 өвчтөн эмчлэгдэж байгаагаас эмэнд мэдрэг сүрьеэ 36 (97.3%), нэг ба олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээтэй 1 (2.7%) байна.</p> <p>Дэлхийн сүрьеэтэй тэмцэх өдрийн хүрээнд 4 удаагийн сургалтад 216 хүнийг хамруулсан. Монголын Сүрьеэтэй Тэмцэх нийгэмлэгийн 8 эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн 16 хүний эмийг гэрээр хяналттай уулгасан. Мөн тус нийгэмлэгээс эмчилгээнд хамрагдаж буй 35 өвчтөнийг аминдэмжүүлж, амьжиргааны баталгаажих түвшин доогуур орлоготой 8 өвчтөнд сар бүр хүнсний тусламж үзүүлсэн байна.</p>	
8	1.2.5. Зорилтот бүлгийн хүн амын ДОХ/ХДХВ/БЗДХ-ыг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх ажлыг эрчимжүүлэх ^{3,5}		БЗДХ-ын илрүүлэг үзлэгийн хамралтын хувь БЗДХ-ын өвчлөл 10,000 хүн амд	36,2%	40%	<p>Тайлант хугацаанд:</p> <ul style="list-style-type: none"> - Орон нутгийн төсвөөс 20 сая төгрөгийг шийдвэрлүүлэн зорилтот бүлгийн 16-49 насны 2000 эмэгтэйг нөхөн үржихүйн болон бэлгийн замаар дамжих халдварын үзлэг шинжилгээнд 1895 буюу 94,7% хамруулж, лавлагаа шатлалд 457 эмэгтэйг илгээн, эмчлэн эрүүлжүүлсэн 354 буюу 77,5% нь бүрэн эмчлэгдсэн. - Бэлгийн замаар дамжих халдварын кабинетаар 4742 хүнд үйлчлүүлснээс 76.1% нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. - Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ХДХВ-ийн шинжилгээнд 3460, тэмбүүгийн шинжилгээнд 3824 иргэнийг хамруулсан байна. - Шинээр хяналтад хамрагдсан 1451 жирэмсэн эмэгтэйн бэлгийн замаар дамжих халдварын шинжилгээний үзүүлэлтэд трихомониаз 25 буюу 1.9 хувь нь эерэг, тэмбүү 8 буюу 0.6 хувь нь эерэг, заг хүйтэн 1 буюу 0.07 хувь эерэг гарч 100% эмчилгээнд хамрагдсан. - ДОХ/ХДХВ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэхийн ач холбогдлыг таниулах 14 төрлийн зурагт хуудсыг цахим орчинд байршуулан 19385 хүнд хүргэсэн байна. 	100

						<p>- Эрүүл мэндийг дэмжих сангийн 13,5 сая төгрөгийн санхүүжилтээр “Ний нуугүй ярилцъя” төслийн хүрээнд 1000 хүн, Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгтэй хамтран “Би найзынхаа итгэлтэй зөвлөх” нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн замын халдвараас сэргийлэх сургалтад ерөнхий боловсролын сургуулийн 168 хүүхэд, 86 оюутныг хамруулсан байна.</p> <p>Тайлант хугацаанд бэлгийн замаар дамжих халдварын 134 тохиолдол бүртгэгдсэнээс 42.5%-ийг тэмбүү, 14.2%-ийг заг хүйтэн, 43,3%-ийг трихомониаз тус тус эзэлж, 10000 хүн амд 12,7 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 1,8 промиллоор буурсан байна.</p>	
Зорилт 3. Агаар, ус, хөрсний бохирдлын хүн амын эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тандаж, бууруулах эрүүл мэндийн цогц арга хэмжээг бусад салбарын дэмжлэгтэй хэрэгжүүлэх							
9	1.3.1. Агаар, ус, хөрсний бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах салбар хоорондын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ⁴		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	80%-аас дээш	<p>Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагааны явцад ялгарах цагаан тоосны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлэх, асуумж судалгааг орон нутгийн төсвөөр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран хийсэн. Судалгаагаар:</p> <ul style="list-style-type: none"> - Нөлөөлөлд өртөж буй Говил, Баянцагаан, Улаантолгой баг, нөлөөллийн бус бүсийн Яргуйт, Уурхайчин, Дулаан-Уул баг болон хаягдлын далан тус бүрээс тоосны 7, ургамлын 7 нийт 2 удаагийн 28 дээж, усны 10 дээжийг шинжилсэн. - Орхон аймгийн оршин суугчдын хүрээлэн буй орчны талаарх сэтгэл ханамжийн судалгаанд 1603 иргэнийг хамруулан асуумж судалгааг авсан. <p>Судалгааны дүгнэлт гарч Аймгийн ИТХ-ын дэргэдэх Байгаль орчин, ногоон хөгжлийн хороо, Эрх зүйн нутгийн удирдлага, хөгжлийн хорооноос цагаан тоосны дэгдэлтийг бууруулах ажилтай газар дээр нь танилцаж, төрийн байгууллагын удирдлагууд болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд мэдээлэл хүргэж “Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах” хөтөлбөрийг 2024-2027 онуудад хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.</p> <p>Аймгийн хэмжээнд 561 худаг бүртгэгдсэнээс Баян-Өндөр суманд 277 өрөмдмөл, 39 гар худаг, эвдэрсэн 31, ашиглалттай 285 худаг, Жаргалант суманд 245 худаг бүртгэгдсэнээс 102 өрөмдмөл худаг, 17 эвдэрсэн худаг, 143 энгийн уурхайн худаг бүртгэгдсэн байна. Ус цаг уур орчны</p>	100

						шинжилгээний төвийн байгаль орчны шинжилгээний лаборатори нь Хангал, Эрдэнэт, Орхон голуудаас 76 сорьц авч 23 үзүүлэлтээр нийт 1748 удаагийн давталттай чанарын хяналт-шинжилгээг гүйцэтгэж хяналт шинжилгээний дүн мэдээг сарын бүрийн 5-ны дотор http://orkhon.tsagaar.gov.mn/ сайтад оруулж ард иргэдэд мэдээлэл хүргэн ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 85%-тай байна.	
10	1.3.2. Орчны эрүүл мэндийн тандалт, судалгааг өргөжүүлэх ⁴		Судалгааны тоо	1	1	Аймгийн хэмжээнд харшлын шалтгаант амьсгалын замын архаг өвчлөлөөс бронхийн багтраа 10,000 хүн амд 11,4 промилл, бронхит 10,000 хүн амд 6,9 промилл байна. Эрдэнэт медицина төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн харшлын кабинетаар үйлчлүүлсэн мэдээллийг үндэслэн харшлын шалтгаант өвчлөлийн тархалтын судалгааг хийсэн. Судалгаагаар: - 1474 үйлчлүүлэгч үзүүлснээс 897 буюу 60,8 нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан, 597 үйлчлүүлэгч харшлын өвчлөлийн онош батлагдсан байна. - Шинээр онош батлагдсан 579 тохиолдлоос хавьтлын харшилт дерматит, шалтгаан тодорхойгүй 23,5%, атопит дерматит, тодорхойгүй 18,6%, арьс хуурайших 11,1%, ургамлын тоосонцроос үүссэн харшилт ринит 9.9%, арьсны идээт халдвар 7,5%-ыг эзэлж, тэргүүлэх 5 өвчлөлд багтаж байна. - Хүүхдүүдийн дунд атопит дерматит, тодорхойгүй 26,5%, хавьтлын харшилт дерматит, шалтгаан тодорхойгүй 22,8% өвчлөлүүд тэргүүлж байна. Насанд хүрэгчдийн дунд хавьтлын харшилт дерматит, шалтгаан тодорхойгүй 21.5%, арьс хуурайших 9,7%, зоосон экзем 9,7% өвчлөлүүд нь давамгайлж байна.	70
11	1.3.3. Орчны бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эрүүл амьдрах хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг өргөжүүлэх чиглэлээр төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ⁴		Үйл ажиллагааны тайлан	-	85%-аас дээш	- Орчны бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эрүүл амьдрах хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр 3 тэмдэглэлт өдөр, 3 контент, 42 удаагийн сургалтаар 6201 иргэнийг хамруулж 32 төрлийн 1647 ширхэг гарын авлагыг түгээж, цахимаар давхардсан тоогоор 25363 иргэнд хүргэж ажилласан. - Ногоон ариусгал” ХХК-тай хамтран эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдал хариуцсан 42 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж эрүүл мэндийн	94,1

						<p>байгууллагуудын дэмжлэгт хяналтыг 28 байгууллагад хийж зөвлөмж хүргүүлэн зөвлөмжийн хэрэгжилт 84%-тай байна.</p> <ul style="list-style-type: none"> - “Гүүд нэйборс” олон улсын төрийн бус байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгч, Орхон аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу “Ундны ус эрүүл ахуй” хөтөлбөрийн хүрээнд сургагч багш бэлтгэх сургалтад 7 байгууллагын 26 албан хаагчийг бэлтгэн, гэр хорооллын 1166 өрхөд сургалт зохион байгуулсан. - Хог хаягдлын менежментийг иргэдийн оролцоотой сайжруулах” орон нутгийн хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын 8 багт хөдөлгөөнт чингэлгээр хог хаягдлын татан авалт хийж, гэр хорооллын айлуудын хог хаягдлыг сард 1 удаа ачих боломж бүрдсэнээр гэр хорооллын орчмын орчны бохирдол болон иргэдээс ирэх хог хаягдлын талаарх гомдол буурсан. <p>Үйл ажиллагааны тайлан 80%-тай байна.</p>	
12	1.3.4. Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын менежментийг сайжруулах, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах ⁴		Үйл ажиллагааны тайлан	85%	85%-аас дээш	<p>Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын тээвэрлэлт, устгалын үйл ажиллагааг бүх шатны эрүүл мэндийн байгууллага “Ногоон ариусал” ХХК-тай гэрээгээр гүйцэтгүүлж ажилласан. Тайлант хугацаанд “Ногоон ариусгал” ХХК-тай 66 эрүүл мэндийн байгууллага гэрээтэй ажиллаж халдвартай хог хаягдал 119934,7кг, хурц үзүүртэй, ирмэгтэй хог хаягдал 76383,8 кг, эмгэг хог хаягдал 253,73 кг, эсийн хог хаягдал 229,2кг, химийн хог хаягдал 6,7 кг устгасан байна. А/505 тоот тушаалын хэрэгжилтийг үнэлэх, эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор ажилтнуудад “Ногоон ариусгал” ХХК-тай хамтран эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдал хариуцсан 42 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж эрүүл мэндийн байгууллагуудын дэмжлэгт хяналтыг 28 байгууллагад хийж зөвлөмж хүргүүлэн ажилласан.</p> <p>Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны санхүүжилтээр аймгийн хэмжээнд хог хаягдлын нэгдсэн цэгт аюултай хог хаягдал хадгалах зориулалтын байр барих ажил 75%-тай явагдаж байна. Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2, Жаргалант сумын эрүүл мэндийн төвд 1</p>	100

						эмнэлгийн аюултай хог хаягдлыг ариутгах автоклав төхөөрөмж хуваарилагдан ирснээр 35458 кг эмнэлгийн аюултай хог хаягдлыг ариутган "Ногоон ариусгал" ХХК-д хүлээлгэн өгсөн байна. Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны тайлан 85%-тай байна.	
13	1.3.5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд эрүүл мэндийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх		Тарьсан модны тоо	2358	1000	Монгол улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, Орхон аймгийн Засаг даргын 2022 оны А/688 дугаар захирамж, Орхон аймгийн "Ногоон Эрдэнэт" хөтөлбөрийн хүрээнд нийт эрүүл мэндийн байгууллага нэгдэж тайлант хугацаанд нийт 35603 мод тарьснаас шинэс мод 520, монос 23, шар хуайс 35060 ширхгийг тус тус тарьсан байна.	100
Зорилт 4. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдал, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг бэхжүүлж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, салбар хоорондын оролцоо, халдварт өвчнийг хамтын ажиллагаанд тулгуурлан бууруулах.							
14	1.4.1. Халдварт өвчний тохиолдол бүрт тандалт судалгаа хийх, халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр хэрэгжиж буй тушаал шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах, эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ авах чиглэлээр холбогдох салбарын байгууллагуудтай хамтран ажиллах ⁴	ОНТ 3.0	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	90%	92%	2023 оны байдлаар халдварт өвчний 972 тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 91,5 ногдож, өмнөх оны мөн үеийнхээс 357,8 промиллоор буурсан байна. Нийт халдварт өвчний 53.9%-ийг амьсгалын замын халдварт өвчин, 13.8%-ийг бэлгийн замаар дамжих халдварт өвчин, 4.8%-ийг гэдэсний халдварт өвчин, 0,6%-ийг зоонозын халдварт өвчин, 0.7%-ийг цусаар дамжих халдвар тус тус эзэлж байна. Дархлаажуулалтын хамралт 99,75%-тай байна Тархвар судлалын заалтаар (Ковид-19)-ийн вакцинд 69, Хачигт энцефалитын вакцинд 533 иргэн, хачигт энцефалитийн ийлдэс эмчилгээнд 6 иргэн, галзуугийн вакцинд 237, галзуугийн ийлдэс эмчилгээнд 9 хүнийг тус тус хамруулсан. Дархлаажуулалт бүхий халдварт өвчний сэжигтэй болон батлагдсан тохиолдол бүртгэгдээгүй. Томуугийн ажлын хэсэг 6 удаа хуралдаж, 18 шийдвэр гарган, эрүүл мэндийн байгууллагуудад чиглэл, Боловсрол шинжлэх ухааны газарт зөвлөмж хүргүүлж, 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сум, өрхийн эрүүл мэндийн төв, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв зэрэг 11 байгууллагын халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр хэрэгжиж буй тушаал шийдвэрийн хэрэгжилтэд хяналт хийж зөвлөмжөөр хангасан. Эрүүл мэндийн байгууллагуудын цагаан хэрэгслээр хангасан тухай мэдээлэл, угаалгын газрын үйл ажиллагаанд үнэлгээ	90,7

						хийгдсэн. Монголын тархвар, халдвар судлагч эмч нарын нийгэмлэгтэй хамтран орон нутгийн 3.0 сая төгрөгийн санхүүжилтээр 47 халдвар хяналтын ажилтныг бэлтгэж гэрчилгээ олгосон. Тайлант хугацаанд сүрьеэгийн өвчлөл 10000 хүн амд 5,6 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0,8 промиллоор нэмэгдэж, бэлгийн замаар дамжих халдвар 10 000 хүн амд 12,7 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 1,8 промиллоор буурсан байна. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээ /2022-2025 он/-г хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 90,7%-тай байна.	
15	1.4.2. Зоонозын шалтгаант болон дамжуулагчаар дамжих өвчний тандалтын тогтолцоог өргөжүүлэх, хариу арга хэмжээний чадавхыг сайжруулах, салбарын байгууллагуудтай хамтран ажиллах ⁴		Хэрэгжилтийн хувь	84%	85%	Тайлант хугацаанд хачигт энцефалитийн 6 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 0.6 промилл байна. Галзуугийн сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдэж Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Мал эмнэлгийн газартай хамтран хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулсан. Тус галзуугийн сэжигтэй тохиолдол түргэвчилсэн болон лабораторийн шинжилгээгээр үгүйсгэгдсэн. “Хачигт халдвараас сэргийлье” сургалтыг зохион байгуулж нийт 45 эмч, мэргэжилтэн хамруулсан. Зонхилон тохиолдох зоонозын шалтгаант халдварт өвчнөөс сэргийлэх чиглэлээр 5 төрлийн зөвлөмж, эрүүл мэндийн газрын цахим хуудсаар дамжуулан түгээж 4517 хүнд хүргэсэн. Орон нутгийн телевизээр “Хачигт халдвараас сэргийлье” мэдээллийг иргэдэд хүргэсэн. Зоонозын шалтгаант болон дамжуулагчаар дамжих өвчний тандалтын тогтолцоог өргөжүүлэх, хариу арга хэмжээний чадавхыг сайжруулах үйл ажиллагааны хэрэгжилт 84,1%-тай байна.	90
Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, орчин үеийн оношилгоо эмчилгээний дэвшилтэт технологийг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.							
Зорилт 1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах							
16	2.1.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн дэвшилтэт технологийг ашиглалтыг сайжруулах, иргэдэд хүртээмжтэй болгох, үр дүнг тооцох	ОНТ 110.0	Ашиглалтын хувь	60%	90%	Тайлант хугацаанд лавлагаа шатлалд 12 нэр төрлийн өндөр өртөг бүхий техник тоног төхөөрөмж, тусламж үйлчилгээг нэвтрүүлж, тоног төхөөрөмжийн хангалт дунджаар 90,8%, ашиглалт 90,6% байна. - Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь чих хамар хоолойн үзлэгийн дуран, нүдний мэс заслын микроскоп, нярайн сонсгол шалгах аппарат, өвдөгний үений хөдөлгөөн нөхөн сэргээх аппарат болон орон нутгийн 180.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар зүрхэн дотор цахилгаан сэдэл өгөх	100

						<p>аппарат, 30.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар зүрхний холтер монитор шинэ технологи нэвтрүүлж оношилгооны чадавхыг нэмэгдүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Баян-Өндөр мед эмнэлэг хиймэл оюун ухаанд суурилсан умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг оношилгооны "ServiCare AI" системийг нэвтрүүлэн 138 хүнд үзлэг, шинжилгээ хийж, RMC эмнэлэгтэй хамтарч үргүйдлийн оношилгооны кабинетыг нээж 59 хүнд оношилгоо хийн, 13 хүнийг RMC эмнэлэгт илгээсэн. - Дурангийн тусламж үйлчилгээ үзүүлдэг клиник SUMSNUG брэндийн өндөр хүчин чадалтай ЭХО аппаратыг авч оношилгооны хүчин чадлыг нэмэгдүүлсэн. - Нейрон клиникт 24 цагийн нойрны бичлэг, уналт таталтыг тогтоох бичлэгийг бүс нутгийн хэмжээнд үзүүлж байна. - Тайлант хугацаанд сурфактант эмчилгээг тайлант хугацаанд амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 15 нярайд хийж, 86,6 хувийн үр дүн өгсөн байна - Эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх хүрээнд амилуулах суурь тусламжийн ажил мэргэжлийн уралдааныг Монголын Яаралтай тусламжийн Нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж 14 багийн 70 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, орчин үеийн технологи Kahoot, Quiz maker программыг анх удаа ашиглан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн гардан болон онолын мэдлэгийг нэмэгдүүлсэн. 	
17	2.1.2. Нотолгоонд суурилсан эмнэлзүйн тусламж үйлчилгээг нэвтрүүлэх, олон улсын түвшний "Up to date" платформыг ашиглалтыг сайжруулах		"Up to date" платформыг ашиглаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	62%	65%	<p>Нотолгоонд суурилсан анагаах ухаан, эмнэлзүйн заавар ашиглалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "UpToDate программын хэрэглээг өргөжүүлэх нь" ажил мэргэжлийн уралдаанд эрүүл мэндийн салбарын 7 багийн 35 эмч оролцсоноос тэргүүн байрыг Эрдэнэт Медикал эмнэлэг, дэд байрыг Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төв, гутгаар байрыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн баг тус тус эзэлж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа. UpToDate программын хэрэглээг өргөжүүлэх болон анагаахын англи хэлийг сайжруулах сургалтыг 3 удаа зохион байгуулж эрүүл мэндийн салбарын 50 эмч, сувилагч, эх баригч хамрагдсан. Нийт эмч нарын 70% нь тус платформд бүртгэл үүсгэж ашиглаж, өмнөх онтой харьцуулахад 10%-аар нэмэгдсэн.</p>	100
18	2.1.3. Улс, орон нутгийн түвшинд туршлага судлах,		Нэвтрүүлсэн шинэ төрлийн	3	3	<p>Бүсийн оношилгоо эмчилгээний төвд бүс нутгийн хэмжээнд доорх тусламж үйлчилгээг үзүүлэн сурталчлан ажиллалаа.</p>	100

	тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн шинэ төрөл, технологийг бүс нутгийн хэмжээнд өргөжүүлэх, сурталчлах		технологи, эмчилгээ, үйлчилгээний тоо			<ul style="list-style-type: none"> - Ангиографийн оношилгоо эмчилгээг 40 хүнд хийсэн байна. - Нүдний кабинетад дутуу нярайн нүдний гажгийг илрүүлэх шинжилгээг нүдний нийгэмлэгээр дамжуулан бусад аймгуудад сурталчлан ажилласан. - Эрэгтэйчүүдийн урологийн үзлэг, оношилгоо, хагалгааг бүс нутгийн хэмжээнд үзүүлж байна. - Эрүүл мэндийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг аймгийн эдийн засгийн форумд танилцуулсан. - Солонгос улсын Дэгү хоттой хамтран ажиллах гэрээг байгуулж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд алсын зайн оношилгооны төв байгуулсан. 	
19	2.1.4. Иргэдийн дунд авлагагүй донорын эгнээг өргөжүүлж, аюулгүй цус цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлэх ^{1,2,3} .	ОНТ 10.0 сая	ЦЦБ-ний нөөц	96%	96%- 97%	<p>Аймгийн Засаг даргын 2023 оны А/172 дугаар захирамжаар 5.0 сая төгрөгийг шийдвэрлэж, “Дусал цусаар амьдрал бэлэглэе” уриан дор сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх, цусны аюулгүй байдлыг хангах, донор хадгалах идэвх санаачилгыг өрнүүлэх аяныг зохион байгуулсан. Байгууллагын хамт олон дунд цом аялуулан ажилчдын 70-аас доошгүй хувийг сургалт, сурталчилгаанд хамруулж, 3-аас доошгүй байнгын донортой байж донороо хадгалах ажлыг зохион байгуулсны үр дүнд 36 байгууллагын 301 донор сайн дурын авлагагүй донорын эгнээнд нэгдэн цусаа бэлэглэж, нийт 903 хүний амь аварсан. Байнгын донорын эгнээг өргөжүүлж ажилласан Онцгой байдлын газар, 18 дугаар цэцэрлэгийг аймгийн Засаг даргын нэрэмжит шагналаар, шаардлагатай үед дуудагдан 4-өөс дээш удаагийн цус, сийвэн бэлэглэсэн 4 донорыг тус тус шагнаж урамшуулсан. Тайлант хугацаанд суурин цус цуглуулахтаар 497, явуулын байдлаар 108 донороос цус цуглуулсан. Цусны салбар төвд бүртгэлтэй 225 донорт цусны АВО, Резус бүлэг, Келл бүлэг, цус, цусан бүтээгдэхүүнээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээг хийж 100% баталгаажуулан ажилласан. Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх тусламж үйлчилгээний бэлэн байдлыг 2 байгууллагад үнэлэн, 67 эмч эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад хамруулсан.</p> <p>Тайлант хугацаанд 1372 нэгж цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн ба шинжилгээний хасагдалт өмнөх онтой харьцуулбал 4 тохиолдлоор буурсан. Нийт 496 улаан эсийн бүтээгдэхүүн, 418 сийвэнгийн бүтээгдэхүүнийг захиалгын дагуу олгосон. Цус цусан бүтээгдэхүүн сэлбэлттэй холбоотой</p>	100

						урвал хүндрэл бүртгэгдээгүй. Цус цусан бүтээгдэхүүний хангалт 100%-тай байна.	
20	2.1.5. Эрүүл мэндийн байгууллагуудын Халдварын сэргийлэлт хяналтын баг, Чанар аюулгүй байдлын албаны үйл ажиллагааг тогтмолжуулан хяналт тавих ⁵		Халдварын сэргийлэлт хяналтын төлөвлөгөөний хэрэгжилт Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт	90%	90%	Халдварын сэргийлэлт хяналтын салбар зөвлөлийн 2023 оны 12 заалт бүхий төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэн ажилласан. Эрүүл мэндийн байгууллагуудын төрөл, үзүүлж буй тусламж үйлчилгээ чиглэлээс хамааран хуваарийн дагуу дэмжлэгт хяналтыг 1-2 удаа хийж, зөвлөмж өгч ажилласан. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд 35 эмнэлгийн мэргэжилтнийг Халдвар хяналтын ажилтнаар бэлтгэсэн. Халдварын сэргийлэлт хяналтын төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн ортой 13 клиникт чанарын баг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг, Эрдэнэт сувилалд орон тооны бус чанарын алба ажиллаж байна. Тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудын Эмчилгээ чанарын албадыг чадавхжуулах чиглэлээр мэдээлэл 2 удаа өгч, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, Эмчилгээ чанарын албад, багийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт 1 удаа хийж зөвлөмжөөр хангасан. Тайлант хугацаанд нийт 9 байгууллагыг 100% магадлан итгэмжлэлд хамруулж, магадлан итгэмжлэлийн хугацааг 1-3 жилээр сунгуулсан байна. Магадлан итгэмжлэл сунгуулах байгууллагуудын “Чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө”-ний хэрэгжилт дунджаар 90% үнэлэгдсэн.	100
21	2.1.6. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба, багуудыг чадавхжуулах хяналт тавих ⁵		Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт	90%	90%	Тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудын Эмчилгээ чанарын албадыг чадавхжуулах чиглэлээр мэдээлэл 4 удаа хийж, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал эмнэлэг, хувийн хэвшлийн ор бүхий 11 клиникийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, Эмчилгээ чанарын албад, багийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт 2 удаа, гүйцэтгэлийн хяналт 1 удаа хийж зөвлөмж өгсөн. Уг хяналтаар: - Эрүүл мэндийн байгууллагуудын 85,0% нь үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгчийг танин тодруулах журмыг хэрэгжүүлж хэвшсэн бөгөөд хэрэгжилт 89,5%-тай байна.	100

						<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн байгууллагуудын 95,0% нь үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж, унаж халтирахаас сэргийлсэн, санамж байршуулсан, ажилбар хийхээс өмнө үйлчлүүлэгчид танилцуулж, зөвшөөрөл авч хэвшсэн байна. - Эмчилгээ чанарын албад 100% байгууллагын даргын тушаалаар байгуулагдан, гишүүдэд үүрэг чиглэл өгсөн, чанарын төлөвлөгөөтэй, чанарын албаны хурал 52, дотоод хяналт 84, ижил мэргэжилтний үзлэг 18 чиглэлээр 136 удаа хийж, тусламж үйлчилгээтэй холбоотой 84 тохиолдол бүртгэн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр төвийн болон дотоодын 16 сургалт, 3 хэлэлцүүлэг зохион байгуулж, давхардсан тоогоор 452 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан байна <p>http://eburtgel.moh.gov.mn цахим программд тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдлыг бүртгүүлж хэвшсэн ба Эрүүл мэндийн газраас программын бүртгэл, хариу арга хэмжээний хэрэгжилтийн байдалд тогтмол хяналт тавьж ажилласан. Тайлант хугацаанд бүртгэгдсэн 84 тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдлоос эмнэлзүйн шалтгаан 48,6%, эмнэлзүйн бус шалтгаан 44 бүртгэгдсэн. Батлагдсан. Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагуудад өгч, 2 удаагийн сургалтад 49 хүнийг хамруулж, 199 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, удирдлагад мэдээлэл хүргэн ажилласан.</p> <p>Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай байна.</p>	
Зорилт 2. Анхан шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг нэг цэгээс тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх							
22	2.2.1. Өрхийн эрүүл мэндийн төвтэй гүйцэтгэлийн гэрээ байгуулж, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавин ажиллах ^{4,5}		Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээний дундаж хувь	90,2%	90,5%	<p>Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй Засаг Дарга, ЭМГ-ын дарга гүйцэтгэлийн гэрээ байгуулж өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ болон удирдлага зохион байгуулалтын чиглэлээр тайлант хугацаанд дэмжлэгт хяналтыг 3 удаа, зөвлөмж 1, чиглэл 1 хүргүүлж гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> - Аймгийн хэмжээний нийт үзлэгийн 47.9 хувийг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хийгдэж, нэг эмчид ногдох үзлэгийн тоо 5980 буюу нэг өдөрт 272 хүн тусламж үйлчилгээ авсан үзүүлэлттэй байна. Нийт үзлэгт урьдчилан 	70

						<p>сэргийлэх үзлэг 50.0 байгаа нь өмнөх оны мөн үеэс (2.6) хувиар, гэрийн идэвхтэй үзлэг 31.7 байгаа нь өмнөх оны мөн үеэс (1.6) хувиар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</p> <ul style="list-style-type: none"> - Эрт илрүүлэг үзлэгт нийт хамрагдвал зохих хүн амаас 10846 буюу 86.1 хувь нь 5 хүртэлх насныхан, 16617 буюу 62.2 хувь нь 6-17 насныхан, 16197 буюу 23.6 хувь нь 18-аас дээш насныхан тус тус хмаруулсан. - Жирэмсний хяналтад шинээр 1451 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдан эхний 3 сартайд 1427 буюу 98.3 хувь нь хяналтад орж, өмнөх оны мөн үеэс эрт үеийн хяналт (1.8) хувиар нэмэгдсэн. - Дархлаажуулалтын хамтарл 99,8% болж өмнөх оны мөн үеэс 1%-аар нэмэгдсэн. - Нийт 54354 шинжилгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 24449 тохиолдлоор нэмэгдсэн. - Өөрсдийн санхүүжилтээр 25 сая төгрөгийн цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппарат, биохимийн хагас автомат аппарат, шээсний шинжилгээний аппаратыг авч оношилгооны чадавхыг нэмэгдүүлсэн. - Уламжлалт, сэргээн засахын чиглэлээр 7 төрлөөр тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэн. 3 өрхийн эрүүл мэндийн төв сэтгэлзүйн тусламж үйлчилгээ, 4 өрхийн эрүүл мэндийн төв цагаан хорхойн шинжилгээг хийж ажилласан. <p>2023 оны жилийн эцсийн байдлаар өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гүйцэтгэлийн гэрээний дундаж хэрэгжилт 87,9%-тай буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,3%-аар буурсан байна.</p>	
23	2.2.2. Жаргалант сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллах		Гэрээний хэрэгжилтийн хувь	92%	92%	<p>Тайлант хугацаанд Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эрүүл ахуй халдвар хамгааллын чиглэлээр удирдамж бүхий хяналтыг хийж, зөвлөмж, албан шаардлагыг хүргүүлсэн.</p> <p>Жаргалант сумын эрүүл мэндийн төвд нийт 9253 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 4066 буюу 43.9% байна. Үүнээс гэрийн идэвхтэй эргэлт 14.2% буюу өмнөх оны мөн үеэс 7.5%-аар буурч, жирэмсний эрт үеийн хяналт 98.3% болж өмнөх оны мөн үеэс 1,8%-аар нэмэгдсэн, заавал хийх дархлаажуулалтын хамрагдалт 100% байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэн болон гүйцэтгэлийн санхүүжилтээр 722,202,1 төгрөгийн санхүүжилт авч оношилгоо, шинжилгээнд 941, өдрийн эмчилгээнд 186,</p>	100

						сэргээн засах тусламж үйлчилгээнд 532, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээнд 162, яаралтай тусламжид 317, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээнд 401, түргэн тусламжийн дуудлагаар 907 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Эрүүл мэндийн сургалт сурталчилгаанд нийт 1625 хүнийг хамруулж цахим хуудсаар 821 иргэнд 208 төрлийн мэдэ мэдээллийг хүргэсэн байна. Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 92,7% байна.	
24	2.2.3. Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан стандарт чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчин бүрдүүлэх		Стандартын шаардлага хангасан орчин бүрдүүлсэн эрүүл мэндийн төв	88,9%	100%	Өрхийн эрүүл мэндийн төвийн 6 нь стандартын шаардлага хангасан өөрийн байртай, 2 өрхийн эрүүл мэндийн төв багийн байранд “Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS5292:2017” стандартын шаардлагыг 100% ханган ажиллаж байна. Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд өрхийн 48 эмч, 49 сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн 43 ажиллаж иргэдэд анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан. Аймгийн Эрүүл мэндийн газраас Мэндцэцэн, Анхны-Оч өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжид үнэлгээ хийн, шинээр өрхийн эрүүл мэндийн төв байгуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж Аймгийн Засаг даргад шинээр өрхийн эрүүл мэндийн төв байгуулах хүсэлтийг албан бичгээр хүргүүлсэн. Мөн Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг бариулах хүсэлтийг аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. Жаргалант сумын эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс 20,0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, урсгал засвар хийгдсэн. Тайлант хугацаанд өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хүрээнд тоног төхөөрөмжийн хангалт 95% байгаа ба нийт 322904 үзлэг хийсэн нь аймгийн хэмжээний нийт үзлэгийн 47,9%-ийг эзэлж, урьдчилан сэргийлэх үзлэг 50% байгаа нь өмнөх оны мөн үеэс 1,4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	100
Зорилт 3. Эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах, тусламж, үйлчилгээнд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах							
25	2.3.1. Нярайн тусламж үйлчилгээнд стандартын шаардлага хангасан дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ³		Нярайн эндэгдэлд эзлэх амьсгал хямралын хам шинжийн хувь	28,5%	28,5%	Орон нутагт нярайн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи сурфактант эмчилгээг 2015 оноос эхлэн нэвтрүүлсэн. Тайлант хугацаанд: - Сурфактант эмчилгээг амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 16 нярайд хийж, 70 хувийн үр дүн өгсөн байна.	100

						<ul style="list-style-type: none"> - Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийг төрсөн 1920 нярайд 100 хувь үзүүлсэн. - Нярайн тандалт скрининг шинжилгээнд төрсөн нярай бүрийг 100% хамруулж байгаа бөгөөд түнхний үений ЭХО оношилгоонд 2040, давтан үзлэг 956, сонсголын скрининг 1823, анхдагч гипотиреоз илрүүлэх скрининг оношилгоонд 935 нярай, дутуу нярайн ретинопатийн оношилгоонд 19 нярайг хамруулж, 54 удаагийн үзлэг хийж, 4 нярайг лавлагаа шатлалд илгээсэн байна. Нярайн эрт илрүүлгийн зааврын хэрэгжилт 95,8%-тай байна. - Төрөлхийн хөгжлийн гажигтай 22 хүүхэд бүртгэгдсэнээс зүрхний төрөлхийн гажигтай 11 хүүхэд төрж, эрт үедээ оношлогдон, лавлагаа шатлалд 11 нярайг илгээсэн байна. Тайлант хугацаанд нялхсын эндэгдэлд эзлэх нярайн эндэгдэл 70.6 хувь байгаагаас амьсгал хямралын хам шинжийн шалтгаант эндэгдэл 2 бүртгэгдсэн нь нийт нярайн эндэгдлийн 16,7 хувийг эзэлж байна. 	
26	2.3.2. Суурь өвчтэй хүүхдүүдийг улирлын чанартай гэр сувилалд хамруулан эрүүлжүүлэн чийрэгжүүлэх ³	ОНТ 30.0	Суурь өвчтэй хүүхдийн эрүүлжсэн хувь	85%	88%	Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувилал ажиллуулахаар орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийг шийдвэрлэн, Уян чагнуур ХХК-ийн Бүжинлхам эмнэлэг 2023 оны 6 сарын 15-ны өдрөөс эхлэн 7 ээлжээр ажиллан сульдаа, уураг илчлэгийн дутагдал, цус багадагдал зэрэг суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй 150 хүүхдийг нар ус агаараар чийрэгжүүлэх зуны сувилалд хамруулан эмчлэн эрүүлжүүлсэн байна.	100
27	2.3.3. Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэх, жирэмсний хяналтын чанарыг сайжруулан, жирэмсэн үеийн ХДХВ, тэмбүү, гепатитын В,С вирусийн илрүүлэг шинжилгээний хамралт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн, эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, хавьтлын илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний байдалд хяналт тавин ажиллах ⁵		Жирэмсний эрт хяналтын хувь	96,8%	96,9%	Аймгийн хэмжээнд жирэмсний тусламж үйлчилгээг сум, 8 өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Жирэмсний өртөмтгий бүлгийн хяналтын кабинет, Төрөх тасаг үзүүлж байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд нь эх баригчийг орон тоогоор дагнан ажиллуулж, жирэмсний нэрийн хяналт, төрөх насны эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, бүртгэл, тайланг нэгтгэн, товлолын дагуу жирэмсэн эхийг хяналтад бүрэн хамруулж, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад давхардсан тоогоор 945 жирэмсэн эхийг хамруулсан нь нийт жирэмсэн эхийн 70,4%-ийг эзэлж байна. Тайлант хугацаанд жирэмсний эрт үеийн хяналт 98,3%-тай, өмнөх оны мөн үеэс эрт үеийн хяналт 1,8 хувиар нэмэгдсэн. Хяналтад байгаа 1451 жирэмсний 87,1% нь жирэмсний хэвийн явцтай анхан шатлалд, 12,9% нь жирэмсний өндөр	100

						<p>эрсдэлтэй гэж үнэлэгдэн лавлагаа шатлалын эмнэлэгт хянагдаж байна. Хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 99.9 хувь цусны шинжилгээнд хамрагдсанаас 77 буюу 5.3 хувь нь цус багадалттай байна.</p> <p>Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн гепатитын В,С вирусийн илрүүлэг шинжилгээ, ХДХВ, тэмбүүгийн хурдавчилсан сорилд 100% хамруулж, трихомониаз 25, тэмбүү 8, заг хүйтэн 1 эерэг гарч, оношийг баталгаажуулан, хавьтагчийн хамт эмчилгээнд 100% хамруулсан байна. Төрөлхийн тэмбүүгийн 1 тохиолдол бүртгэгдсэн байна.</p> <p>Тайлант хугацаанд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн жирэмсний тусламж үйлчилгээний чанар хүртээмжид 2 удаа үнэлгээ хийж, зөвлөмж өгч жирэмсний хяналтыг сайжруулах чиглэлээр салбар дундын цахим хурлыг 60 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан 1 удаа зохион байгуулснаар үзлэгийн хувийг өмнөх оноос 5.4 хувиар нэмэгдүүлсэн. Мөн Булган аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, сумуудын эрүүл мэндийн төвийн дарга, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг оролцуулсан цахим хурлыг зохион байгуулсан.</p>	
28	2.3.4. Хүүхэд, өсвөр үе болон нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх ^{2,4}	ОНТ 20.0	Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн үзлэгт хамруулсан хувь	18,5%	19%	<p>"Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, шалгуурын хэрэгжилт 88.5 хувьтай байна.</p> <p>Тайлант хугацаанд:</p> <ul style="list-style-type: none"> - Жирэмсний хяналт, эх хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр 4 албан тоот, 1 албан даалгавар, 6 мэдээллийг хүргүүлэн хяналт хийн зөвлөмж өгсөн. - Томуу, томуу төст өвчний алаг цоог дэгдэлтийн үед 150-200 ор нэмэлтээр дэлгэж, гэрийн эргэлт, уртасгасан цагийн зохицуулалтаар өрхийн 75 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг нэмэлтээр ажиллуулж тусламж үйлчилгээний ачааллыг бууруулсан. - Эх хүүхэд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний стандарт, чанар хүртээмжид 2 удаа үнэлгээ хийн зөвлөмжөөр хангасан. - Эрт илрүүлэг үзлэгт 0-17 насны хүүхдийн 74,5 хувь нь хамрагдаж улсын хэмжээнд тэргүүлсэн. - Тайлант хугацаанд бүртгэгдсэн амьгүй болон гэрийн төрөлт, 0-5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийн нийт 29 тохиолдолд үзүүлсэн тусламж үйлчилгээг Эмчилгээ чанарын албад, 	100

						<p>Магадлан хэлэлцэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн зөвлөмж өгч ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> - ЭХЭМҮТ, ЭМХТ, ЭМГ-аас зохион байгуулсан сургалтаар давхардсан тоогоор нийт 305 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан. - Хүүхдийн эрхийг хамгаалах хороо 2 удаагийн хурлаар эрх нь зөрчигдсөн 2 кейсийг хэлэлцэж, СЭТҮТ-д өсвөр насны 1 хүүхдийг илгээн түр хамгаалах байранд 2 хүүхдэд сэтгэл зүйн тусламж үзүүлсэн. - Жирэмсний эрт үеийн хяналт 98.3 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1,8 хувиар нэмэгдсэн. - 2079 эх амаржсанаас 16-19 насны 52 буюу 1000 эмэгтэйд ногдох охидын төрөлт 15.8 промилл болж өмнөх оны мөн үеэс 3.4 промиллоор буурсан. - Нялхсын эндэгдлийн 17 тохиолдол буюу 8,2 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 3,9 промиллээр нэмэгдсэн, - Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн гэр бүл төлөвлөлтийн арга хэрэгслийн хангалт 75.8 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 14.1 хувиар нэмэгдсэн. - Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны нийт эмэгтэйчүүдийн 22 хувь нь үзлэгт хамрагдсан байна. 	
29	2.3.5. Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, шүд цоорлоос сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах ⁵	ОНТ 25.0	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	1	4	<p>Тайлант хугацаанд хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, шүд цоорлоос сэргийлэх чиглэлээр 20 удаагийн сургалтад 1200 хүн, 3 удаагийн үзлэгт 600 хүн, шүд угаалтын авраг шалгаруулах тэмцээнд 184 хүүхдийг тус тус хамруулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - БШУГ-тай хамтран ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын нийт 63 байгууллагын 749 удирдлага, багш, эмчид амны хөндийн эрүүл ахуй, хүүхдийн шүдний зөв угаах аргачлалаар сургалтад хамруулсны үр дүнд 7 хоногийн 1 өдөр шүд угаах цаг гарган сургалт дадлага хийж хэвшиж байна. - 2 цэцэрлэг, 1 сургуульд эцэг эхчүүдийн санаачилгаар шүд угаах буланг тохижуулан ажиллуулсан. - Монголын шүдний мэргэжилтний холбоотой хамтран Японы шүдний эмч нарын санхүүжилтээр 350 хүнд эмчлэн эрүүлжүүлэлт хийсэн. - Орхон аймгийн Шүдний мэргэжилтний холбоотой хамтран шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээнийг 23 багийн 	100

						<p>184 хүүхдийг хамруулж орон нутагт анх удаа зохион байгууллаа. Сургууль, цэцэрлэгийн 200 хүүхэд, 600 эцэг эхийг хамруулсан амны хөндийн эрүүл ахуйн талаарх мэдлэг хандлага дадлыг үнэлэх судалгаагаар оо, сойзыг тогтмол хэрэглэдэг. Мөн туслах хэрэглэгдэхүүн шүдний утсыг 54,3% (n=100) нь хэрэглэдэг, асран хамгаалагчийн мэдлэг 87,2%, хандлага 75.9%, дадал 64.7%-тай байна.</p> <p>Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын цахим хуудсаар дамжуулан хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, шүд цоорлоос урьдчилан сэргийлэх зорилгоор 30 төрлийн постер, видео зөвлөмжүүдийг 82151 хүнд хүргэсэн байна.</p>	
Зорилт 4. Уламжлалт, сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж үйлчилгээг цогц, нэгдмэл байдлаар хөгжүүлж, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх							
30	2.4.1. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээг нэгдмэл байдлаар үзүүлэх, бусад тусламж үйлчилгээтэй хослуулан төрөлжүүлэн үзүүлэх ⁴		Үйл ажиллагааны тайлан, хэрэгжилтийн хувь	85%	86%	<p>Уламжлалт анагаах ухааны хүний нөөцийн хангалт 82 хувьтай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Уламжлалт хөнгөвчлөхийн тасаг, Сэргээн засах тусламж үйлчилгээний тасагт их эмч 4, бага эмч 4, хөдөлгөөн засалч 2, сувилагч 8 - Сум, өрхийн эрүүл мэндийн төв тус бүрт уламжлалтын эмч тус бүр 1, бага эмч 1, бариа заслын сувилагч 1 - Эрдэнэт сувиллын сэргээн засахын их эмч 3, хөдөлгөөн засалч 1, Уламжлалт анагаах ухааны их эмч 1, бага эмч 4 - Хувийн хэвшлийн ортой болон клиникийн 16 эрүүл мэндийн байгууллагад уламжлалт анагаах ухааны 33 их эмч, бага эмч сувилагч 15 нийт 88 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллалаа. <p>Тайлант хугацаанд уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг давхардсан тоогоор 98868 иргэнд, сэргээн засах эмчилгээг давхардсан тоогоор 52884 иргэнд тус тус үзүүлсэн байна.</p> <p>Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 3 удаагийн хяналт хийж, зөвлөмж өгч ажилласан. Уламжлалт анагаах ухааны клиник, ор бүхий клиникүүдийн тусламж үйлчилгээний эмчилгээний чанарт хяналт хийхэд 87%-тай үнэлэгдэж, эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд танилцуулж ажилласан. “Төвийн бүсийн аймгуудын МУАУ-ны нөлөөлөл-2023” хэлэлцүүлэгт 16 эмч, мэргэжилтэн оролцсон. Тус хэлэлцүүлгийн хүрээнд Удирдлага-Нөлөөллийн багийг орон нутагтаа байгуулсан. Эмч мэргэжилтнийг чадавхжуулах чиглэлээр дотоодын 2</p>	100

						<p>сургалт, “Тэжээхүй ухаан” ТББ-тай хамтарсан сургалтад 37 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. “Уламжлалт аргаар дархлаагаа дэмжицгээе” зөвлөмжийг цахим хуудаст байршуулан давхардсан тоогоор 17825 иргэнд хүрсэн байна. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/749 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд 14 үйл ажиллагааг зохион байгуулж холбогдох тайланг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээний үйл ажиллагааны хэрэгжилт 90%-тай байна.</p>	
31	2.4.2. Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах, нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг өргөжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх ⁴		Сувилахуйн төвийн зураг төсөв газрын асуудлыг шийдвэрлүүлэх	-	Гарсан шийдвэр	<p>Сувилахуйн төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг боловсруулах “Сувилахуйн тасралтгүй сургалтын чиг хандлага” сэдэвт цахим сургалт, хэлэлцүүлгийг Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Жайка олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан. Сувилагч мэргэжилтний цогц чадамжид суурилсан эмнэл зүйн ур чадварын шатлал болон шинэ төгссөн сувилагчийн сургалтын удирдамж боловсруулах ажлын хэсэгт аймгаас 4 сувилагч мэргэжилтэн хамтран ажиллаж байна. Нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх ажлын хүрээнд “Up To date программыг өргөжүүлэх нь” сэдэвт сургалтад 47 ахлах сувилагч, эх баригчийг хамруулсан.</p> <p>Сувилагчдын Эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж 3 илтгэлийг шалгаруулж 2.5 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа.</p> <p>Эрүүл мэндийн салбарын хэмжээнд “Сувилагч мэргэжлээр суралцагчдын шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэх нь” зэрэг номд оюуны өмчийн эрхийг авсан бөгөөд цахим хуудаст байршуулан сурталчлан ажилласан.</p> <p>“Сувилахуй ба эрх зүй” сургалт, хэлэлцүүлэг, “Сувилагч ба эрүүл мэнд” аяныг УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэнгийн ажлын албатай хамтран Орхон аймагт зохион байгуулж, төвийн бүсийн 6 аймгийн 300 гаруй сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд оролцсон. Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах зорилгоор 2 хэлэлцүүлэг, 2 удаагийн сургалтыг зохион байгуулж 158 сувилагч хамрагдсан.</p> <p>Сувилахуйн мөн чанар, үнэ цэнийг сурталчлан таниулах өдөрлөгт ерөнхий боловсролын 14 сургуулийн ахлах ангийн</p>	70

						704 сурагч оролцож сувилахуйн тусламж үйлчилгээний төрөл, сувилагч нарын өдөр тутмын үйл ажиллагаатай танилцсан. Орон нутгийн санхүүжилтээр 11 сувилагч БНХАУ-ын Ордос хотын Төв эмнэлгийн сувилахуйн төвд харилцан туршлага судалсан. БОЭТ-ийн Төгсөлтийн дараах сургалтад 2022-2023 оны хичээлийн жилд “Яаралтай тусламжийн сувилахуй”-аар 8, “Эрчимт эмчилгээний сувилахуй”-аар 8 суралцагчийг сургаж төгсгөж, “Яаралтай тусламжийн сувилахуй”-аар 4, “Эрчимт эмчилгээний сувилахуй”-аар 1 сувилагч тус тус суралцаж байна. Сувилахуйн төвийн барилгын төсвийг улсын төсөвт тусгуулахаар ЭМЯ-нд төслийг хүсэлтийн хамт хүргүүлсэн.	
32	2.4.3. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх ⁴		Хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	952	958	Орхон аймагт урт хугацааны асаргаа сувилгаа шаардлагатай 1639 үйлчлүүлэгч байгаагаас 1465 эрүүл мэндийн IV бүлэг, 174 эрүүл мэндийн V бүлэг, 95 хорт хавдрын III, IV шатанд оношлогдсон байна. Тайлант хугацаанд гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээг нийт 1446 иргэнд хүргэсэн бөгөөд сэргээн засах эмчилгээг гэрээр 7 хоног тасралтгүй хийж зөвлөгөө өгч ажилласан. БОЭТ-ийн Хөнгөвчлөх тасагт 641 үйлчлүүлэгч 4208 ор хоног хэвтэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөвчлөх шалтгааны улмаас эмнэлэгт хэвтэлт 186 тохиолдлоор нэмэгдсэн. Орны эргэлт 26,6, дундаж ор хоног 6,5, нас баралт 5 бүртгэгдсэн. Хорт хавдрын шалтгааны улмаас хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 30,1%-ийг хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл, 3,4 хувийг амьсгалын замын эрхтэн тогтолцоо, 24,7%-ийг бусад өвчлөл эзэлж байна. Сарниулах эмчилгээний төрлүүд болох зураг эмчилгээ, тоглоом эмчилгээ, хөгжим эмчилгээг давхардсан тоогоор 210 хүнд хүргэж ажилласан. Нийт 130 үйлчлүүлэгч, 25 сахиурт давхардсан тоогоор 43 удаа сургалт зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын захирамжаар 109 иргэнд 43,2 сая төгрөгийн эмийн болон эмчилгээний дэмжлэгт үзүүлсэн нь шинээр хорт хавдрын хяналтад орсон иргэдийн 69,2 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд 641 хүнд хөнгөвчлөх тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.	70
Зорилт 5. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн чадавхыг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээний тасралтгүй шуурхай байдлыг ханган хамтран ажиллах							

33	2.5.1. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ байгуулж, стандартын хэрэгжилтийг хангуулах		Гэрээний хэрэгжилтийн дундаж хувь	93%	95%	<p>Хувийн хэвшлийн 1 нэгдсэн эмнэлэг, 11 ор бүхий клиникүүдтэй аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллалаа. Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 95111 үзлэг хийсэн нь аймгийн хэмжээнд хийгдсэн нийт үзлэгийн 14.1%-ийг, 17074 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн нь нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн 49.4%-ийг эзэлж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ачааллыг хуваалцсан байна. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын клиникийн бүтэц үйл ажиллагаа MNS6673:2017 стандартын хэрэгжилт дунджаар 89% байна.</p> <p>Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангуудын стандартын хэрэгжилт дунджаар 93,5%-тай байгаа нь өмнөх жилтэй харьцуулахад 0,6%-аар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан гэрээний 2023 оны хэрэгжилтийн дундаж үнэлгээ 95,3%, стандартын дундаж 91,2%-тай байна.</p>	100
34	2.5.2. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын оношилгооны чадавхыг сайжруулах, тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, өдрийн эмчилгээг өргөжүүлэх		Оношилгооны чадавхын хувь	85%	85,5%	<p>Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд оношилгооны чадавхыг сайжруулж, оношилгооны чадавх 90%-тай байна. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> - Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг нь RMC эмнэлэгтэй хамтарч үргүйдлийн оношилгооны кабинетыг нээж, 59 хүнд оношилгоо хийж, 13 хүнийг RMC эмнэлэгт илгээсэн байна. Мөн хиймэл оюун ухаанд суурилсан умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг оношилгооны "CerviCare AI" системийг нэвтрүүлэн 138 хүнд үзлэг, шинжилгээ хийсэн байна. - Дурангийн тусламж үйлчилгээ үзүүлдэг клиник SUMSNUG брэндийн өндөр хүчин чадалтай ЭХО аппаратыг авч оношилгооны хүчин чадлыг нэмэгдүүлсэн. - Тайхар клиник DRGEM (GXR) дижитал рентген аппарат мөн CM1200B зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар хангагдаж оношилгооны чадавхаа нэмэгдүүлсэн. - Нейрон клиникт 24 цагийн нойрны бичлэг, уналт таталтыг тогтоох бичлэгийг бүс нутгийн хэмжээнд үзүүлж байна. - Хувийн хэвшлийн эмнэлгүүдэд өдрийн эмчилгээний 115 орыг хуваарилж нийт 456 иргэнийг хамруулсан байна. 	100

35	2.5.3. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх	ОНТ 30.0	Гэрээт үйлчилгээний тоо	1	2	<p>Хувийн хэвшлийн 1 нэгдсэн эмнэлэг, 11 ор бүхий клиниктэй аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллалаа. Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 75683 үзлэг хийсэн нь аймгийн хэмжээнд хийгдсэн нийт үзлэгийн 14.2 хувийг, 31238 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн нь нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн 48,9 хувийг эзэлж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ачааллыг хуваалцсан байна. Хувийн хэвшлийн төрөлжсөн эмнэлэг 1, хүүхдийн 4 клиник томуу томуу төст өвчний үеийн тусламж үйлчилгээний ачаалал, хүлээгдлийг бууруулах чиглэлээр уртасгасан цагийн зохицуулалт хийж хамтран ажилласан. Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулахад 6 хувийн хэвшлийн нөхөн үржихүйн клиниктэй гэрээ байгуулан 16-49 насны 1895 эмэгтэйг үзлэгт хамруулан 354 буюу 77.5 хувийг бүрэн эмчлэн эрүүлжүүлэн, лавлагаа шатлалд 457 эмэгтэйг илгээсэн байна.</p> <p>Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын оношилгооны чадавх 90 хувьтай байна.</p> <p>“Эрүүл эрдэнэт хүн” төслийн хүрээнд 29 багийн 31074 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг явуулаар хүргэхэд хувийн хэвшлийн 5 байгууллага хамтран ажилласан байна.</p> <p>Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувилал ажиллуулахаар орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийг шийдвэрлэн, сульдаа, уураг илчлэгийн дутагдал, цус багадалт зэрэг суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй 150 хүүхдийг нар ус агаараар чийрэгжүүлэх зуны сувилалд хамруулан эрүүлжүүлсэн.</p>	90%
Зорилт 6. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, эмнэлзүй, эм зүйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, нянгийн тэсвэржилтийг судалж, антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хяналтыг сайжруулна. ^{1,2}							
36	2.6.1. ЭХНБ-ын MNS 5530:2014, Эмийн сангийн MNS5260:2015 стандартын хэрэгжилтийг хангуулах, хянах		ЭХНБ, эмийн сангуудын стандартын хэрэгжилт	90,1%	90,5%	<p>Аймгийн хэмжээнд нийтийн үйлчилгээтэй 79 эмийн сан, 8 эм ханган нийлүүлэх байгууллага иргэдэд үйлчлэн ажилласан. Тайлант хугацаанд 5 эмийн сан шинээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгож, 11 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг цуцлан, 4 эмийн сан үйл ажиллагааг нь түр түдгэлзүүлсэн.</p> <p>Эм ханган нийлүүлэх байгууллага болон эмийн сангуудын стандартын хэрэгжилт дунджаар 93,5 хувь байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 0,6 хувиар нэмэгдсэн байна. Үүнд:</p>	100

						<ul style="list-style-type: none"> - “Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандарт”-аар хяналт хийхэд 93,15%-тай үнэлгээтэй гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 1,25%-аар сайжирсан байна. - Эм ханган нийлүүлэх байгууллагын стандартын шаардлага 92,5%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 1,1%-аар сайжирсан байна. <p>Эмийн чанар, эмийн гаж нөлөөний сургалтад 86 эрхлэгчийг хамруулж, “Антибиотик эмийг жороор олгоё” 3 сарын аянд 71 эмийн сан нэгдэн антибиотикийг 100 хувь жороор олгон, 111 эмч эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад хамруулан гарын авлагаар ханган, антибиотикийн зохистой хэрэглээний талаар мэдээлэл, зөвлөмжийг 2516 хүнд өгсөн байна. Зайлшгүй шаардлагатай эмийн 8-р жагсаалт дахь зохих эмийн хангамж эм ханган нийлүүлэх байгууллагуудад дунджаар 89 хувьтай болж, өмнөх оноос 1.6 хувиар өссөн байна.</p>	
37	2.6.2. Эмнэлзүйн эм зүйн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх ^{3,4}		Хэрэгжилтийн хувь	81,6	82%	<p>Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 115 эм зүйч, 121 эм найруулагч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эм зүйч 2.6 хувь, эм найруулагч 4.8 хувиар тус тус нэмэгдсэн байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 4 клиник эм зүйч, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад 9 клиник эм зүйч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10,5%-иар нэмэгдсэн байна.</p> <p>Эмнэлзүйн эм зүйн тусламж үйлчилгээнд хяналт хийхэд нийт өвчтөний 52.5-61 хувьд тарилгыг хийж, 39-46,5 хувьд уухаар эмийг өгсөн байгаа нь өмнөх онтой харьцуулахад эмийг тарилгын хэлбэрээр хэрэглэх явдал 3.5 хувиар буурч, ууж хэрэглэх эмийн хувь 2,6-3,8 хувиар нэмэгдсэн, зонхилон тохиолдох эмгэгийн оношилгоо, эмчилгээний удирдамжийн хэрэгжилт 83,5 хувь болж 0,9 хувиар нэмэгдсэн, эмийн зохистой хэрэглээ алдагдал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,5 хувиар буурсан байна.</p> <p>Эмнэлзүйн тусламж үйлчилгээний хэрэгжилт 82,1 хувьтай байна.</p>	100
38	2.6.3. Нянгийн тэсвэржилтийг судалж, антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ² , антибиотекийг жоргүй		Хяналтын дүн, хийгдсэн судалгааны тоо	1	1	Улсын хэмжээнд хэрэгжиж буй нянгийн тэсвэржилтийн сүлжээнд бүх аймгийн нэгдсэн эмнэлгийг холбож, мэдээллийн санг бүрдүүлэх төслийн хүрээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн лабораторийг тус нэгдсэн сүлжээнд холбох төслийн хүрээнд нянгийн тэсвэржилт үзэх тоног	100

	олгох үйл ажиллагааг таслан зогсоох, энэ чиглэлээр байнгын хяналт тавих					<p>төхөөрөмжүүд болон урвалж оношлуурыг хангалт бүрэн хийгдсэн. Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газраас олон улсын антибиотикийн тэсвэржилт бүртгэх программ /WONet/ нэвтрүүлсэн бөгөөд тайлант хугацаанд нян судлалын лаборатори 31451 шинжилгээ хийснээс антибиотик мэдрэг чанар тодорхойлсон 3,986/12,67%/ шинжилгээг бүртгэсэн.</p> <p>Монгол улсад эм хангамжийн байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан нийтийн үйлчилгээтэй 75 эмийн сан “Антибиотикийг жороор олгоё” аяныг хэрэгжүүлэн жортой эмийг жороор олгох, 1320 иргэнд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, 210 үйлчлүүлэгчдэд гаж нөлөөний талаар мэдээлэл хүргэсэн байна. Мөн 2 удаагийн өдөрлөгөөр 450 иргэнийг эмийн зохистой хэрэглээний мэдээлэл сурталчилгаанд хамруулсан. Эмийн сангуудад жорын маягт, жор бичилтийн MNS5376:2016 стандарт болон анхан шатны бүртгэл хөтлөлт зэрэгт хяналтыг 1-р зэрэглэлийн 40 эмийн санд хийж жороор олгох эмийг жоргүй олгосон 12 эмийн сан, анхан шатны бүртгэл буруу болон дутуу хөтөлсөн 24 эмийн санд зөрчлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлэн хяналт тавьж ажилласан. Жор бичилт, жорын маягт MNS5376:2016 стандартын хэрэгжилт 83,4%-тай байна.</p>	
39	2.6.4. Мансууруулах, сэтгэц нөлөөт эмийн хяналтыг сайжруулах ²		Хяналтын дүн, хэрэгжилтийн хувь	85%	85,5%	<p>Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны “Нийтийн үйлчилгээтэй эмийн сангуудад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх, худалдан борлуулах эрх олгох тухай” А/55 дугаар тушаалаар 2 эмийн санд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээр, 5 эмийн санд сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх эрх олгосон.</p> <p>Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Анзаар” аяны хүрээнд 10 эм ханган нийлүүлэх байгууллага, 80 эмийн сангийн 160 эрхлэгч, жор баригч нарыг сургалтад хамруулсан.</p> <p>Тайлант хугацаанд ЭМГ-аас нийт давхардсан тоогоор 11 байгууллагад 4,735 мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн жорыг дугаарлаж олгосноос мансууруулах эмийн жорыг 5 байгууллагад нийт 614/12,97%/ жорыг, сэтгэцэд нөлөөт эмийн жорыг 9 байгууллагад 4,121/87,03%/ жорыг тус тус дугаарлан олгож хяналт тавин ажилласан.</p> <p>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх эр бүхий 8 эмийн сан, 2 эм ханган нийлүүлэх байгууллагад ЭМС-ын А/68</p>	100

						тоот тушаал, Жорын маягт, жор бичилтийн стандарт MNS5376:2016, эмийн хадгалалт, олголт, зарцуулалт, устгал, бүртгэл хөтлөлт зэргээр хяналт хийхэд эм ханган нийлүүлэх байгууллагуудын хувьд хэрэгжилт дунджаар 98,1%, эмийн сангуудад хэрэгжилт дунджаар 96,6% байгаа нь өмнөх онтой харьцуулахад 1,2%-аар өссөн байна.	
40	2.6.5. Эм эмнэлгийн хэрэгслийг оновчтой тооцон худалдан авах ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, ерөнхий гэрээгээр худалдан авч буй эм, эмнэлгийн хэрэгслийг өөр эх сурвалжаас авахгүй байх арга хэмжээг хэрэгжүүлэх ⁵		Хэрэгжилтийн хувь	100%	100%	Тайлант хугацаанд БОЭТ-д төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу эм эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур худалдан авах тендерт нийт 61 багцад зарласан бөгөөд Тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж 2 /62,63/ багцыг зориулалтын дагуу задлан нийт 63 багцад 100% амжилттай зохион байгуулж, 22 компанитай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. Мөн 2023 онд худалдан авах ажиллагааны нийт төсөвт өртөгт 6,3 тэрбум төгрөг үүнээс нээлттэй тендер шалгаруулах журмаар 5,5 тэрбум төгрөг /87,3%/, ерөнхий гэрээгээр 80 нэрийн эм, 6 нэрийн эмнэлгийн хэрэгслийг 800 сая /12,7%/ -д худалдан авахаар 16 компанитай гэрээ байгуулан худалдан авч ажилласан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт төсөвт өртөг 6,3 тэрбум төгрөг байгаа нь 42,06%-аар нэмэгдсэн. Үүнээс нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 2.45 тэрбум төгрөг буюу 44,5%-аар, ерөнхий гэрээгээр 200 сая төгрөг буюу 75%-аар илүү төсөвлөгдсөн байна. Мөн худалдан авах ажиллагааг зөвхөн гэрээ байгуулсан 38 компаниас авч ажилласан.	100
Стратегийн зорилго 3. Эрүүл мэндийн ажилтны урт чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, харилцаа, хандлагыг дээшлүүлэн, нийгмийн баталгааг сайжруулна. ^{1,2}							
Зорилт 1. Эмнэлгийн мэргэжилтний нийгмийн асуудлыг дэмжих, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах.							
41	3.1.1. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудлыг дэмжих “Эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ^{3,4}	ОНТ 175.0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	96%	96,2%	Тайлант хугацаанд “Эмч” хөтөлбөрийн үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг батлан, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 175.0 сая төгрөгийн төсвийг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд: - Төгсөлтийн дараах сургалтад 112, ажлын байран дахь сургалтад 2221 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. - “UpToDate программын хэрэглээг өргөжүүлэх нь” ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулж нийт 35 эмч оролцлоо.	100%

						<ul style="list-style-type: none"> - Эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж нийт 30 илтгэл хэлэлцүүлэв. - Өндөр хөгжилтэй оронд нийт 60 эмч, мэргэжилтэн суралцаж, мэдлэг, чадвараа дээшлүүлснээс 54 эмч “Эмч” хөтөлбөрөөс дэмжлэг авсан байна. - Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээр 47 удаагийн соён гэгээрүүлэх сургалтад 2257 эмч, мэргэжилтнийг хамруулсан байна. - Тайлант хугацаанд 2 өргөдөл ирснийг судлан шийдвэрлэсэн. - Эрүүл мэндийн салбарын 40 наснаас дээш нийт 400 ажилтныг бамбай булчирхайн дааврын шинжилгээнд хамруулан 49 ажилтан өөрчлөлттэй гарсныг эмчлэн, эрүүлжүүлж байна. - Эрүүл мэндийн байгууллагуудын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос зохион байгуулагдсан 4 төрөлт спортын наадамд Орхон аймгийн эрүүл мэндийн салбарын баг тамирчид амжилттай оролцон 2-р байр эзэллээ. <p>Тайлант хугацаанд төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 13,1 байгаа нь өмнөх оноос 0,6%-аар нэмэгдсэн ба нийгмийн дэмжлэгт хамрагдсан хувь 24.4% байна. Тус хөтөлбөрийн хэрэгжилт 100%-тай байна.</p>	
42	3.1.2. Үр бүтээлтэй ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудад олгох урамшууллын багцыг хэрэгжүүлэн ажиллах ⁵		Шагнал урамшуулалд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо	10,4%	10,5%	<p>Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолын дагуу эрүүл мэндийн салбарын төрийн захиргааны албан хаагчдын цалин 12%, Засгийн газрын 2022 оны 489 дугаар тогтоолоор орон нутагт ажилласны нэмэгдэл 20%, 2022 оны 491 дугаар тогтоолоор төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тус тус олгосон. Эрүүл мэндийн байгууллага бүр албан хаагчдын үр дүнг сар бүр үнэлж, урамшууллыг улирал тутам олгож ажилласан. Аймгийн Засаг даргын А/82 дугаар захирамжийн дагуу Эрүүл мэндийн газрын 5 мэргэжилтэнд төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвийг журмын дагуу нэмэгдүүлсэн. Дэлхийн эмч нарын баярыг тохиолдуулан Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь шилдэг эмч нараа шалгаруулан нийт 6 шилдэг эмчид тус бүр 2.0 сая төгрөг, “Олон улсын сувилагчдын эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан шилдэг 6 сувилагч, тусгай мэргэжилтэнд тус бүр 1,0 сая төгрөг, 1 чадварлаг сувилагчид 500.000 төгрөгийн шагнал, урамшуулал олгосон.</p>	100

						<p>"Олон улсын сувилагчдын эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан аймгийн Засаг дарга 10 сувилагчийг БНХАУ-ын Ордос хотод сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр туршлага судлах эрхийн бичгээр шагнаж урамшуулсан. Эрдэнэт сувиллын цогцолбор орон сууц худалдан авсан нийт 2 ажилтанд тус бүр 13.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тайлант хугацаанд төрийн одон медалиар 3, ЭМЯ-ны шагналаар 53, орон нутгийн шагналаар 211 эмч, эмнэлгийн мэргэжилтэн тус тус шагнагдсан байна. Шагнал урамшуулалд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны эзлэх хувь 10.5%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 01 хувиар өссөн байна.</p>	
Зорилт 2. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн төлөвлөлт, хөгжлийг хангах							
43	3.2.1. Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтийг батлуулах, хэрэгжүүлэх		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	85%	86%	Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн 2023-2024 оны төлөвлөлтийг шинэчлэн боловсруулж батлуулсан. Хүний нөөцийн төлөвлөлтийг 2 чиглэлээр төлөвлөж, хангалт 89,8%-д хүрч өмнөх оноос 4.8%-аар нэмэгдсэн.	100

44	3.2.2. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн /нэн шаардлагатай мэргэжлээр бэлтгэх/ сургалтад хамруулах ^{4,5}		Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь	12,9%	13%	<p>Тайлант хугацаанд 2022-2023 онд төрийн сангийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад 191 эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцсанаас төрийн сангийн санхүүжилтээр 18,3% нь суралцсан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн “Ерөнхий мэргэшил судлал”-аар тайлант хугацаанд 6 резидент эмч суралцаж төгссөн, 2023-2024 онд буюу 6 дахь жилийн сургалтад 2 резидент эмчийг элсүүлэн сургалтыг үргэлжлүүлэн амжилттай зохион байгуулж байна байгаа ба 2022-2023 оны хичээлийн жилд “Яаралтай тусламжийн сувилахуй”-аар 8, “Эрчимт эмчилгээний сувилахуй”-аар 8 суралцагчийг сургаж төгсгөн, одоо “Яаралтай тусламжийн сувилахуй”-аар 4, “Эрчимт эмчилгээний сувилахуй”-аар 1 сувилагч тус тус суралцаж байна. Мөн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төгсөлтийн дараах сургалтыг түшиглэн Этүгэн их сургуультай хамтран туслах сувилагчийн сургалтад 20 хүнийг суралцуулж байна. Төрийн сангийн санхүүжилтээр төгсөлтийн дараах сургалтад 9 эмч тайлант хугацаанд төгсөн ирж захиалагч байгууллагадаа ажилласан. Нэн шаардлагатай мэргэжил эзэмшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь 81%-тай байна.</p> <p>Эмч" хөтөлбөрийн санхүүжилтээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 29 эмч Солонгос, Камбож, Япон, Малайз, Румын зэрэг улсад мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж олон улсын хурал, чуулганд оролцсон. Мөн БНХАУ-ын Ордос, Хөх хот, БНСУ, Япон улсуудад 17 сувилагч богино хугацааны сургалтад хамрагдсан.</p> <p>Тайлант хугацаанд төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 13,1% байгаа ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,6%-аар өссөн үзүүлэлттэй байна.</p>	100
45	3.2.3. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байрны, зайн сургалтад хамруулах ⁴		Сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь	74,4%	75%	<p>Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын хэмжээнд 1461 эмч эмнэлгийн мэргэжилтэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан бөгөөд давхардсан тоогоор 1095 эмч, эмнэлгийн мэргэжилтэн буюу 74,9% ажлын байрын болон зайн сургалтад хамрагдсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Ажлын байрны болон алсын зайн сургалтад нийт 293 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. 	83,3

						<ul style="list-style-type: none"> - Төвийн болон орон нутагт зохион байгуулсан ажлын байранд дадлагажуулах 16 удаагийн сургалтад 238 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. - Төрийн албаны зөвлөлөөс цахимаар зохион байгуулагдсан сургалтад 180 албан хаагчийг хамруулсан байна. - “Up to date”, болон амилуулах суурь тусламжийн ажил мэргэжлийн уралдаанд 103 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцсон. - Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал хариуцсан 12 ажилтныг мэргэшүүлэх сургалт, давтан сургалтад хамруулсан. - Аймгийн Засаг даргын тамгын газрын дэмжлэгтэйгээр дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын ажилтан бэлтгэх сургалтад давхардсан тоогоор 100, халдвар хяналтын ажилтан бэлтгэх сургалтад 47 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдан гэрчилгээ авсан. 	
46	3.2.3. Эмнэлгийн мэргэжилтнийг дээд шатлалын эмнэлэгт ажлын байранд дадлагажуулан сургах, лавлагаа шатлалын эмнэлгийн мэргэжилтнийг БОЭТ, төв эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон анхан шатлалд сэлгэн ажиллуулах арга хэмжээг авах ^{4,5}		Ажлын байранд дадлагажуулсан эмнэлгийн мэргэжилтний тоо	35	40	Тайлант хугацаанд 108 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг лавлагаа шатлалд болон анхан шатлалд сэлгэн ажиллуулсан байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хүүхдийн тасагт томуу томуу төст өвчний дэгдэлттэй холбоотой өрхийн эрүүл мэндийн төвийн давхардсан тоогоор нийт 75 эмчийг ажлын байранд сэлгэн ажиллуулсан. - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн инженерийг хувийн хэвшлийн эмнэлгүүдэд болон сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд гэрээгээр ажиллаж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийж үйлчилсэн. - Хувийн хэвшлийн ор бүхий 10 клиник 8 эмч зүйчийг гэрээгээр сэлгэн ажиллуулж байна. - Хүүхдийн өвчний цогц менежментийн дадлагат сургалтад Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, Эрдэнэт медиал төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн 24 эмч, мэргэжилтнийг хамруулан чадавхжуулсан. 	100
Стратегийн зорилго 4. Эрүүл мэндийн салбарт чиглэсэн санхүүгийн урсгалын тогтвортой байдлыг хангах, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллах							
Зорилт 1. Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчин бүрдүүлэх							

47	4.1.1. БОЭТ-ийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр үе шаттай хангаж, иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломж бүрдүүлэх ^{3,4}	УТ 602.0 ОНТ 210.0	Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	92%	92,5%	Тайлант хугацаанд орон нутгийн 210.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвд зүрхэн дотор цахилгаан сэдэл өгөх аппарат, зүрхний холтер зэрэг аппаратууд нийлүүлэгдэн тусламж үйлчилгээнд ашиглагдаж байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 602.0 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 92.5 хувьтай байна.	100
48	4.1.2. БОЭТ-ийн амбулаторийн өргөтгөлийн барилгатай болгож, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах	ОНТ 20.0	БОЭТ-ийн амбулаторийн 2 давхар өргөтгөл баригдсан байх.	-	Өргөтгөл баригдсан байна.	Тайлант хугацаанд: - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн амбулаторийн өргөтгөлийн барилгын зураг төсөвт орон нутгаас 20.0 сая төгрөг батлагдаж зураг бүрэн зурагдсан. - Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь лабораторийн тасгийн засварыг 274.8 сая төгрөг, амбулаторийн 3, 4-р давхрын засварыг 372.8 сая төгрөгийн байгууллагын санхүүжилтээр хийж гүйцэтгэлээ.	100
49	4.1.3. БОЭТ-ийн барилга их засвар, дэд агааржуулалтын системийг сайжруулан стандарт чанарын шаардлага хангасан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлэх		БОЭТ-ийн агааржуулалтын нэгдсэн систем шинэчлэгдсэн байна.	-	100%	2024 онд БОЭТ-ийн агааржуулалтын системд хэсэгчилсэн засвар үйлчилгээг хийхээр төлөвлөгдсөн.	30
50	4.1.4. Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн хуучин барилгын засварын ажлыг эхлүүлэх ³	ОНТ 20.0	Их засвар	-	Их засвар хийгдсэн байна.	Тайлант хугацаанд Жаргалант сумын Эрүүл мэндийн төвд Жаргалант сумын төсвөөс 20.0 сая төгрөг шийдвэрлэн стандартын дагуу болгож засварлах урсгал засвар хийгдсэн	100
Зорилт 2. Санхүүгийн зарцуулалтад хяналт тавин, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллах							
51	4.2.1. Төсвийн тухай” хуулийн 8.9.2 дахь заалтын дагуу орон нутаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн жилийн тайланг хугацаанд нь төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх ⁵		Хугацаандаа хүргэгдсэн тайлан	Тайлан хугацаанд хүргэгдсэн	Тайлан хугацаандаа хүргэгдсэн байна.	Төсвийн тухай хуульд заасны дагуу Эрүүл мэндийн салбар байгууллагуудын 2023 оны сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, өр авлагын мэдээг авч нэгтгэн төсвийн ерөнхийлөн захирагчид хугацаанд нь хүргүүлсэн. 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчид холбогдох баримт материал, Төрийн аудитын дүгнэлтийн хамт 2022 оны 03 дугаар сарын 08-нд нэгтгүүлсэн.	100
52	4.2.2. Худалдан авах ажиллагааг төлөвлөх		Хуульд заасан хугацаанд	100%	100%	Эрүүл мэндийн салбарын хэмжээнд аймгийн Өмчийн алба нийт 235.0 сая төгрөгийн нээлттэй тендер зарлаж худалдан	100

	тайлагнахдаа Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалыг дагаж мөрдөх, цахим системд хуульд заасан хугацаанд оруулах, холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах		цахим системд оруулсан хувь			<p>авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын дагуу зохион байгуулж 100 хувь нийлүүлэгдсэн.</p> <p>Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь нийт 1 тэрбум 248,5 сая төгрөгийн их засвар болон тоног төхөөрөмжийн нээлттэй тендер, эм эмнэлгийн хэрэгслийн 63 багц дээр дээр 6.3 тэрбум төгрөгийн нээлттэй тендер зарлагдан 100 хувь нийлүүлэгдсэн.</p> <p>“Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын “Эрдэнэт Медикал” төрөлжсөн төв эмнэлэг нь нийт 25 төрлийн бараа ажил үйлчилгээ болон эм эмнэлгийн хэрэгслийн нээлттэй тендер зарлагдаж 13 нэр төрөл дээр гэрээ хийгдэн нийлүүлэгдсэн.</p> <p>Хуульд заасан хугацаанд цахим системд оруулсан хувь 100% байна.</p>	
Стратегийн зорилго 5. Эрүүл мэндийн салбарт мэдээлэл, технологийн удирдлагыг хөгжүүлнэ.							
Зорилт 1. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэн, орон нутагт хийгдэх оношилгоо эмчилгээнд алсын зайн технологи ашиглаж, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ							
53	5.1.1. Орон нутагт хийгдэх алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмжийг сайжруулан, цахим эрт илрүүлэг, алсын зайн оношилгоо хийх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ^{2,4,5}		Алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмжийн хангалтын хувь	33%	34%	<p>Алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмжийн хангалт 2021-2022 онд 33 хувьд хүрч, суурь үзүүлэлтээс 16 хувиар нэмэгдсэн.</p> <p>Тайлант хугацаанд телемедициний хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - БНСУ-ын Бусан хотын Үндэсний их сургуультай хамтран ажиллах санамж бичиг байгуулснаар тус их сургуулийн эмнэлгийн алсын зайн оношилгоо, эмчилгээний төвийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шинээр байгуулсан. - Жаргалант сумын эрүүл мэндийн төвд эмнэлзүйн хүнд өвчтөнд авах арга хэмжээний зөвлөмжийг БОЭТ-ийн нарийн мэргэжлийн, мэргэшсэн эмч нараас телемедицинээр авах нөхцөл бололцоо бүрдсэн. - Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, хэвтэрт байдаг иргэдийг Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хуралд телемедицинээр гэрээсээ өрхийн эмчийн хамт орон хөнгөвчлөх ажлыг зохион байгуулахаар туршилтын хурлыг зохион байгуулсан. <p>Тайлант хугацаанд 4 өвчтөний мэдээллийг алсын зайн сүлжээгээр дамжуулж лавлагаа шатлалын эмнэлгүүдээс оношилгоо, эмчилгээний зөвлөмж авсан байна.</p>	100%
54	5.1.2. Нотолгоонд тулгуурласан шийдвэр		Мэдээний чанар	94%	95%	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй 176 байгууллагаас үйл ажиллагааны чиглэлээр сар бүр албан	100

	гаргах үйл ажиллагаанд эрүүл мэндийн байгууллага ялангуяа хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын мэдээ мэдээллийн үнэн, зөв, шуурхай байдлыг ханган ажиллах ^{4,5}					<p>ёсны мэдээ тайланг батлагдсан маягтын дагуу 143 үзүүлэлтээр хүлээн авч нэгтгэн, мэдээлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Хувийн хэвшлийн ортой болон амбулаторийн тусламж үйлчилгээний клиник нийт 61 байгууллагын мэдээний чанар, мэдээ өгөлтийг нэмэгдүүлэх хүрээнд клиникүүдийн мэдээг 2 дугаар сараас эхлэн цахим хэлбэрээр авч эхэлснээр мэдээ өгөлт 95.3 хувьд хүрсэн. Хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдийн мэдээний чанарт 4 удаа цахим хяналт хийж, зөрчлийг арилгуулан зөвлөмж өгч ажилласан. - Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 75 эмийн сангийн мэдээ өгөлт 66.7% болж өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар өссөн. - Тайлант хугацаанд өрхийн эрүүл мэндийн төвүүдийн мэдээний чанарт 9 удаа цахим хяналт хийснээс нийт үзлэгийн 0.5 хувийг үзлэгийн төрөл, хэлбэрийг буруу сонгосон, халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн 12.3 хувийг дутуу алдаатай бүртгэж мэдээлсэн, нийт халдварт бус өвчлөлийн 1.7 хувийг буруу кодолж бүртгэсэн алдааг илрүүлэн дүгнэлт зөвлөмжийг хүргүүлэн зөрүү алдааг залруулж баталгаажуулсан. - Мэдээний үнэн зөв байдлыг хангуулах зорилгоор танхимын 6 удаагийн сургалтад эрүүл мэндийн байгууллагуудын бүртгэл статистик хариуцсан ажилтан, байгууллагын удирдлага давхардсан тоогоор 98 хүнийг хамруулсан. <p>Тайлант хугацаанд мэдээ өгөлт 87,5%, мэдээний чанар 95.6% байна.</p>	
55	5.1.3. Эрүүл мэндийн байгууллагуудыг шилэн кабельд үе шаттайгаар холбож, интернетийн хурдыг сайжруулж, эмнэл зүйн “E health”, “E-hospital” программ хангамжийн ашиглалтыг сайжруулж, тасралтгүй байдлыг хангах ⁵		Шилэн кабельд холбогдсон эрүүл мэндийн байгууллагын тоо	10	12	<p>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн 168 байгууллага интернэтийн сүлжээнд 100% холбогдсоноос 13 эрүүл мэндийн байгууллага Юнивишн, Мобинет ХХК-ийн dedicated 20mb хурдтай өндөр хурдны шилэн кабелийн интернэтийн сүлжээнд холбогдсон. Интернэтийн хурд сайжирснаар өрхийн эрүүл мэндийн төвүүд эрүүл мэндийн цахим программуудыг өндөр хурдны интернетийн сүлжээгээр ашиглаж, иргэдэд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэн, мэдээ мэдээллийн тасралтгүй байдлыг ханган ажилласан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ашиглаж буй E-Health цахим системийн хөгжүүлэлт тогтмол хийгдэж, эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг тус системд холбосон. Тайлант хугацаанд мэдээлэл солилцооны нэгдсэн платформ ННЕР-д E-Health</p>	100

						системд холбогдсон. Мөн дүрс оношилгооны PACS систем НIEP системтэй холбогдон мэдээлэл солилцох боломжтой болсон. Төрийн үйлчилгээний нэгдсэн платформ E-Mongolia системээс эрүүл мэндийн чиглэлээр 15 үйлчилгээг авч байна.	
56	5.1.4. Эрүүл мэндийн байгууллагуудад цахим мэдээллийн аюулгүй байдлын 4 багц хуулийг чандлан мөрдөж, эрүүл мэндийн ажилтнуудад тухайн чиглэлээр тасралтгүй сургалт зохион байгуулах ⁵		Сургалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны хувь	-	60%	Эрүүл мэндийн байгууллагуудад цахим мэдээллийн аюулгүй байдлын тухай багц хуулиудын сургалтыг эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагууд, мэргэжилтнүүдэд 2 удаа, эрүүл мэндийн байгууллагууд дотооддоо сургалтууд зохион байгуулж нийт давхардсан тоогоор 789 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.	90,0
ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, иргэн бүрийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.							
Зорилт 1. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, олон нийтийн оролцоо, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах замаар эрүүл мэндийг дэмжих орчин бий болгох							
57	1.1.1. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих “Эрүүл хамт олон” хөдөлгөөн өрнүүлж, сайн туршлагыг нийтийн хүртээл болгон урамшуулах ^{3,4}	ОНТ 6.0	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо	2	3	Тайлант хугацаанд шинээр 5 байгууллага Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болж, 4 байгууллага зэрэглэл ахиулсан байна. 21 төрийн байгууллагын 1180 албан хаагчийг эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хамруулж, “Энэ жилдээ эрүүл жиндээ” аяны хүрээнд жин бууруулах 1 сарын уралдааныг 10 байгууллагын 60 хүнийг хамруулж зохион байгуулснаар аяны хугацаанд оролцогчид нийт 93.4 кг жин хаяжээ. Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийг дэмжигч байгууллага 81 байгаагаас боловсролын салбарын 45, эрүүл мэндийн салбарын 14, үйлдвэр аж ахуйн нэгж 12, бусад 10 байгууллага байна. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих аян өрнүүлэх, эрүүл мэндийг дэмжигч байгууллагыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 6.0 сая төгрөгийг шийдүүлэн ажилласан.	100
Зорилт 2. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдал, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг бэхжүүлж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, салбар хоорондын оролцоо, халдварт өвчнийг хамтын ажиллагаанд тулгуурлан бууруулах.							
58	1.2.1. Заавал хийх товллолын дархлаажуулалтад хүүхэд бүрийг бүрэн хамруулах, тархвар судлалын		Дархлаажуулалтын хамралтын хувь	99	99,2%	2023 оны байдлаар заавал хийх дархлаажуулалтын бүрэн тунгийн хамралт 99,7% өнгөрсөн оны мөн үеэс 1%-аар өссөн. Тархвар судлалын заалтаар (Ковид-19)-ийн вакцинд 69, Хачигт энцефалитын вакцинд 533 иргэн, хачигт энцефалитийн ийлдэс эмчилгээнд 6 иргэн, галзуугийн вакцинд 237, галзуугийн ийлдэс	100

	заалтаар хийх дархлаажуулалтыг зохион байгуулж, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл, тарилгатай халдварт өвчний бүртгэл, мэдээлэл, тандалтыг эрчимжүүлэх ⁴					эмчилгээнд 9 хүнийг тус тус хамруулсан. В вирусийн эсрэг тархвар судлалын заалтаар дархлаажуулалтад 642 иргэн хамрагдсан. Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтад 10112 хүүхэд хамрагдсан байна. Нийт 35824 хүүхдийн дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалт хийж, хүндрэлийн 1 тохиолдол, урвалын 258 тохиолдлыг бүртгэж сар бүр ХӨСҮТ-д мэдээг илгээж ажилласан. Дархлаажуулалтын 10 нэгжийн вакциначар сувилалч нарыг чадавхжуулах 10 удаагийн сургалтыг ажлын байранд нь зохион байгуулж, харилцан туршлага судлуулж ажилласан. Тайлант хугацаанд 10 удаагийн сургалтад 265 хүнийг хамруулж, цахим орчинд 37 зөвлөмж мэдээллийг 26570 хүнд хүргэсэн.	
Зорилт 3. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх							
59	1.3.1. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж, хариу арга хэмжээний чадавхыг нэмэгдүүлэх ^{4,5}	ОНТ 25.0	Хариу арга хэмжээний чадавх нэмэгдсэн байна	95%	96%	Тайлант хугацаанд тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж, хариу арга хэмжээний чадавх нэмэгдүүлэх хүрээнд орон нутгийн төсвөөс 25.0 сая төгрөгийг шийдвэрлэснээр эрүүл мэндийн байгууллагуудад дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хариуцсан 40 мэргэжилтэн бэлтгэгдэж, эрүүл мэндийн 3 байгууллагад олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001 стандарт эрсдэлийн менежментийн тогтолцоо ISO31000:2018 стандарт нэвтрэн, томуу, томуу төст өвчний дэгдэлтийг хүндрэл бэрхшээлгүй даван туулсан. ХӨСҮТ-д нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрсдэлийн үнэлгээ хийх төвийн сургалтад ЭМГ-аас 2 мэргэжилтнийг хамруулж чадавхжуулсан. ОБЕГ-аас зохион байгуулсан Стратеги команд штабын сургуулилтад эрүүл мэндийн албаны 15 гишүүн, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэргэжлийн ангийн 55 бие бүрэлдэхүүн оролцож, Онцгой байдлын газраас өгөгдсөн 7 удаагийн цагийн байдалд хариу арга хэмжээ авч ажилласан. Эрүүл мэндийн байгууллагуудын гамшигын үеийн нөөцийн хангалт дунджаар 95% байна. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 95% болж өмнөх оноос 5%-аар нэмэгдсэн байна.	98,9
60	1.3.2. Гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагуудын нөөцийг нэмэгдүүлэх ⁴		Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн	89,8%	90%	Тайлант хугацаанд: - Эрүүл мэндийн яамнаас нийт 3 удаагийн татан авалтаар 9 нэр төрлийн 19.0 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж хэрэгслийн хангалтыг хийж нөөцийг нэмэгдүүлсэн.	100

			нөөцийн хангалтын хувь			- ЭМГ-ын гамшгийн нөөцөөс 8 нэр төрлийн нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, оношлуур, эм, эмнэлгийн хэрэгслийг сумын болон өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал төрөлжсөн төв эмнэлэгт хүлээлгэн өгч, нөөцийг нэмэгдүүлсэн. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 95%-тай байна. Эрүүл мэндийн байгууллагуудын гамшгийн үеийн нөөцийн хангалт 95 хувь болж 5%-аар нэмэгдсэн.	
Зорилт 4. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах чиглэлээр ⁵							
61	1.4.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, цар тахалтай тэмцэх чиглэлээр салбар дундын оролцоо бүхий багаар халдварын нөхцөл байдал, эрсдэлд тухай бүр үнэлгээ хийж, хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгон, төлөвлөгөөний хэрэгжилт, тайлагналтад хяналт тавьж ажиллах ⁵		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90,5	90,5	Тайлант хугацаанд коронавируст халдвар /КОВИД/-ын тохиолдол 1 бүртгэгдсэн. Коронавируст халдвар /КОВИД/-ын Бх-ПГУ-ын шинжилгээг 988, түргэвчилсэн тестийн шинжилгээ 1765 хийгдсэн. Коронавируст халдвар /КОВИД/-ын тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотой эрүүл мэндийн байгууллагуудад 2 удаагийн чиглэл, сургууль цэцэрлэгүүдэд 1 зөвлөмж хүргүүлж, салбарын шуурхай, сургууль цэцэрлэгийн эмч нарын сургалтад мэдээлэл хүргэсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын тасагт 2 удаагийн тандалт хийгдсэн. Коронавируст халдвар /КОВИД/-ын мэдээллийг өдөр бүр ХЭСҮТ-д хүргүүлэн ажилласан.	70
62	1.4.2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын шинэ хувилбарын тархалтаас урьдчилан сэргийлэх, тандалтыг эрчимжүүлэх, нийгмийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг орон нутагт оновчтой, үр дүнтэй зохион байгуулах, нөөцийн бэлэн байдал, шаардлагатай нөөцөөр хангах, шат бүрт хяналт тавих, нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, салбар дундын хамтын		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	90%	Зонхилон тохиолдож буй Омикрон хувилбарын дэд хувилбарын тандалтад суурилсан чиглэл, зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж ажилласан. Тандалтыг эрчимжүүлэх чиглэлээр өрхийн эрүүл мэндийн төвүүдийг түргэвчилсэн тест, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 45-р долоо хоногоос эхлэн Бх-ПГУ шинжилгээг 988 иргэнд хийхэд коронавируст халдвар (КОВИД-19) 1 тохиолдол батлагдсан байна. Коронавируст халдварын орон нутгийн нөхцөл байдлын мэдээлэл 52 удаа хийж коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг цахимаар хийж давхардсан тоогоор 103528 иргэнд түгээн ажилласан. Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлын үед ЭМЯ-аас цар тахалтай тэмцэх, хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллагууд 5 нэр төрлийн 44 төрлийн эм, 6 төрлийн эмнэлгийн хэрэгсэл, 15 төрлийн хувийн хамгаалах хэрэгсэл, 4 төрлийн ариутгалын бодисыг нөөцөд авч бэлэн байдлыг ханган ажилласан.	90

	ажиллагаагаар хангаж ажиллах ⁵						
63	1.4.3. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээг шуурхай авах зорилгоор нөөцийн бэлэн байдлын талаарх мэдээллийн санг бүрдүүлж, тухай бүрт шаардлагатай мэдээ мэдээллээр баяжуулж хяналт тавих ⁵		Мэдээний сангийн баяжилтын хувь	100%	100%	Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд burtgel.mohs.mn сайтад өдөр бүр нөөцийн мэдээг оруулж байгаагаас Эрүүл мэндийн газар сар тутам, Бүсийн оношилгоо эмчилгээний төв 7 хоног бүр, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд 14-21 хоног тутам нөөцийн орлого зарлагыг бүртгэн ажилласан. Тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллагууд дунджаар 61 хоногийн нөөцтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 /38,5%/ хоногийн нөөцөөр илүү байна. Эрүүл мэндийн байгууллагуудын нөөц бүрдүүлэлт дунджаар 93,5%-тай байна. Үүнд: - Эрүүл мэндийн газарт 98,3% - Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 91,9%, - Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд дунджаар 88,5%-тай, - Эм ханган нийлүүлэх байгууллагуудын нөөц 91,1%-тай байна. Мөн ЭМС-ын 6 тушаалаар хуваарилсан эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, багаж хэрэгсэл олгосон бөгөөд нийт 141,78 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисыг татан авч 291,7 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, түргэвчилсэн оношлуур, тоног төхөөрөмж, халдваргүйтгэлийн бодисыг ЭМГ-ын даргын 2023 оны А/04, А/28, А/63, А/68, А/69, А/90 тоот тушаалуудаар Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд болон Эрүүл мэндийн газрын нөөцөд хуваарилсан.	100
64	1.4.4. Нийт хүн ам болон зорилтот бүлэгт чиглэсэн Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, сэргийлэх мэдээлэл сургалт, сурталчилгааг цахим хэлбэрээр тогтмол зохион байгуулах ⁵		Цахим хэлбэрээр хийгдсэн мэдээлэл, сургалтад хамрагдсан хүний хувь	85%	85%-аас бууруул ахгүй байх	Тайлант хугацаанд коронавируст халдвар(КОВИД-19)-ын орон нутгийн нөхцөл байдлын мэдээллийг 52 удаа хийж, коронавируст халдвар(КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх 99 төрлийн постер, видео шторк, аудио шторк, зөвлөмжийг цахим хэлбэрээр байршуулан давхардсан тоогоор 103528 /97,4%/ иргэнд түгээн ажилласан.	100
65	1.4.5. Коронавируст /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, халдвар хамгааллын дэглэм баримтлах, халдварын үеийн оношилгоо,		Сургалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилны тоо	60%	60%-65%	Тайлант хугацаанд 9 удаагийн сургалт, арга хэмжээнд давхардсан тоогоор 368 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан нь нийт хамрагдах эмч эмнэлгийн мэргэжилтний 42%-ийг эзэлж байна. Үүнд:	70

	эмчилгээ зэрэг сэдвээр эрүүл мэндийн ажилтнуудад тасралтгүй байдлаар “сэргээх” сургалтыг зохион байгуулах, цахимаар сургалтад хамрагдах боломж нөхцөлийг бүрдүүлэн ажиллах5					<ul style="list-style-type: none"> - Томуу, томуу төст өвчний үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний сургалтыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 72 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд - ХӨСҮТ-ээс зохион байгуулсан коронавируст халдвар /КОВИД/-ын үеийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх цахим сургалтад 5 - Эрүүл мэндийн байгууллагуудын дотоодын сургалтаар 241 эмч, эмнэлгийн мэргэжилтэн - Амьсгалын замын халдвар, хүндрэл сэдвээр цахим сургалтад сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 30 эмч - "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үеийн туршлага, сургамж" сэдвээр цахим сургалт, хэлэлцүүлэгт 15 албан хаагч - "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үеийн туршлага, сургамж" эрдэм шинжилгээний хуралд 5 мэргэжилтэн оролцлоо. 	
Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангаж, орчин үеийн оношилгоо эмчилгээний дэвшилтэт технологийг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.							
Зорилт 1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах							
66	2.1.1. Эмнэлгүүдийг магадлан итгэмжлэлд хамруулж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх		Батлагдсан хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт	90%	90-95%	Тайлант хугацаанд нийт 9 байгууллага магадлан итгэмжлэлийг хугацааг сунгахаар, 2 байгууллага шинээр сонгон шалгаруулалтад оруулахаар хүсэлтийг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүсэлтийг хүргүүлэн байгууллагуудын баримт бичгийг цахим программаар бүрдүүлэн 100% магадлан итгэмжлэлд хамруулж, магадлан итгэмжлэлийн хугацааг 1-3 жилээр сунгуулсан байна. Магадлан итгэмжлэл сунгуулах байгууллагуудын “Чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө”-ний хэрэгжилт дунджаар 90% үнэлэгдсэн.	100
Зорилт 2. БОЭТ-ийн менежментийг сайжруулж, оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлж, иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлэн шинэ дэвшилтэт технологийг нутагшуулна ¹							
67	2.2.1. БОЭТ-ийг санхүүжилт болон удирдлагын бие даасан хэлбэрт шилжүүлэх	БОЭТ гүйцэтгэлийн санхүүжилт 474.0	БОЭТ-ийг санхүүжилт болон удирдлагын бие даасан хэлбэрт шилжсэн байна.	-	Бие даасан хэлбэрт шилжсэн байна.	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд 1 эмч, 1 сувилагч, 1 тусгай мэргэжилтнийг сонгон шалгаруулсан бөгөөд ЭМС-ын 2020 оны А/563 дугаар тушаалын дагуу олон нийтийн төлөөллийн мэргэжлийн нийгэмлэг 1, төрийн бус байгууллагын 1 төлөөллийг Эрүүл мэндийн яамтай хамтран сонгон шалгаруулж, 8 хүний бүрэлдэхүүнтэй болоод байна. Иргэн даатгуулагчийн төлөөллийг шалгаруулах нээлттэй сонгон шалгаруулалтыг зарласан боловч ирүүлсэн материал тэнцээгүй байна.	70

						Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 419 оношийн хамааралтай бүлгээр сонгон шалгаруулалтад тэнцэж, ЭМДЕГ-тай гэрээ байгуулан санхүүжилт авч ажилласан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмч нарын цалинг 10,0%, эмнэлгийн тусгай мэргэжилтний цалинг 15%-аар нэмэгдүүлсэн. БОЭТ-ийн санхүүжилтээр 280.0 сая төгрөгөөр лабораторийн нэгдсэн тасаг, 194.0 сая төгрөгөөр амбулаторийн 3 давхарт засвар хийгдсэн.	
Стратегийн зорилго 3. Эрүүл мэндийн ажилтны ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, харилцаа, хандлагыг дээшлүүлэн, нийгмийн баталгааг сайжруулна. ^{1,2}							
Зорилт 1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн төлөвлөлт, хөгжлийг хангах							
68	3.1.1. Эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, боловсролын болон мэргэжлийн зэрэг ахиулах үйл ажиллагааг зохион байгуулах ⁴		Мэргэжлийн зэрэг ахиулсан эмч мэргэжилтний хувь	26,7%	26,8%	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд докторын зэрэгтэй эмч 5, магистрын зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн 81, зөвлөх зэрэгтэй 10, тэргүүлэх зэрэгтэй 90, ахлах зэрэгтэй 123 эмч, эмнэлгийн мэргэжилтэн байгаа нь нийт эмнэлгийн мэргэжилтний 18,8%-ийг эзэлж байна.	70
Зорилт 2. Эрүүл мэндийн ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх							
69	3.2.1. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, хэсгийн хороодын үйл ажиллагааг тогтмолжуулж, ёс зүйн алдаа зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, алдаа, зөрчлийг бүртгэн мэдээлэх, эмнэлгийн ажилтны харилцаа хандлагыг сайжруулах ажлыг тогтмол зохион байгуулах		Хэрэгжилтийн хувь	90%	92%	Тайлант хугацаанд: - ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээр 47 удаагийн соён гэгээрүүлэх сургалтад 2257 эмч, мэргэжилтнийг хамруулсан байна. - ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооноос “Эмнэлгийн эрх зүй ба ёс зүй” сэдэвт 2 багц цагийн сургалтыг зохион байгуулж 60 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. - Тус хороонд 2 өргөдөл ирснийг судлан шийдвэрлэсэн. - Дэлхийн эмч нарын баярыг тохиолдуулан Эрүүл мэндийн байгууллагуудын ажиллагсдын Үйлдвэрчний эвлэлийн хороо хамтран “Эмчийн гангараа” ярилцлага уулзалтыг зохион байгуулж 15 клиникийн 30 ахмад эмч нарыг хамруулсан. - “Ахмадаа хүндэтгэе” арга хэмжээг зохион байгуулж нийт 35 ахмад оролцлоо. - Эмч эмнэлгийн мэргэжилтний дунд “Яруу эгшиглэн-2023” шүлгийн уралдааныг 2 үе шаттай зохион байгуулж ирүүлсэн шүлгүүдээр “Нигүүлслийн цагаан өд” шүлгийн эмхэтгэл гарган түгээсэн.	100

						ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны төлөвлөгөөний хэрэгжилт 95.8%-тай байна.	
ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Нийтлэг чиг үүрэг №1. Төрийн захиргааны удирдлага							
70	1.1. Төрийн албан хаагчдын ёс зүйг төлөвшүүлэх, мэндийн ажилтны харилцаа хандлагыг сайжруулах тасралтгүй байгуулах		Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	64,6%	64,8%	Төрийн албанаас зохион байгуулсан төрийн албан хаагчийн үр дүн, гүйцэтгэл, бүтээмжийг дэмжих, ёс зүй, харилцаа хандлагын сайжруулах чиглэлээр 7*4*10 сургалтад давхардсан тоогоор 180 төрийн албан хаагчийг хамруулсан. Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны зайн сургалтад 2 албан хаагч амжилттай хамрагдсан. Тайлант хугацаанд Эрүүл мэндийн газрын Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой ирүүлсэн 1 өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн. Төрийн бус байгууллагуудтай хамтран ёс зүй, харилцаа хандлагын чиглэлээр сургалтад давхардсан тоогоор 240 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Сургалтад нийт төрийн албан хаагчдын 75 хувь нь хамрагдсан байна.	100
71	1.2. Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, чиглэлээр үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх		Төлөвлөгөөний хэрэгжилт	98%	98%	Эрүүл мэндийн байгууллагын хүрээнд 2023 онд Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 5 зорилт 11 хэрэгжүүлэх үйл ажиллагаа бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж төлөвлөгөөний хэрэгжилт 98%-тай байна. - Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн үүрэг чиглэл, байгууллагын даргын батлагдсан удирдамжийн дагуу өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нөхөрлөлийн гишүүдийг хамруулсан уулзалт, хэлэлцүүлгийг аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Аудитын газар, Эрүүл мэндийн газрын удирдлагыг оролцуулан зохион байгуулсан. - Эрүүл мэндийн газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга, нягтлан бодогч, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг оролцуулан үүрэг чиглэл өгч, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нөхөрлөлийн тухай хууль, Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн чиглэлээр сургалт, мэдээллийг хийгдсэн. - ХАСХОМ гаргалтын талаар соён гэгээрүүлэх ажлыг 75 албан хаагч нарыг хамруулан зохион байгуулсан. - ЭМГ-ын тусгай зөвшөөрөл олгох комиссын 5 гишүүдээс тус бүр 6 удаагийн 30 удаагийн мэдэгдлийг гаргуулсан.	100

						- ЭМГ-ын дарга болон салбарын санхүү нягтлан бодох бүртгэлийн ажилтнаас тэтгэмжийн төсвийн зарцуулалтын мэдэгдэл тайлбарыг тухай бүр гаргуулан авсан.	
72	1.3. Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг бүх хэлбэрээр авч, шийдвэрлэн, шийдвэрлэлтэд хяналт тавьж, мэдээлэх ⁴		Шийдвэрлэлтийн хувь	100%	100%	Байгууллагын өргөдөл гомдол хариуцсан албан хаагчийг томилон ажиллуулж мэдээлэл болон холбоо барих утасны дугаар, өрөөний дугаар болон иргэдээс мэдээлэл, санал, хүсэлт, талархал, гомдол авах цагийн хуваарийг байгууллагын or.mohs.gov.mn цахим хуудасны “Санал гомдол” цэс болон байгууллагын мэдээллийн самбарт ил тод байршуулан мэдээлэл өгч ажилласан. Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой цахимаар 92, бичгээр 38, нийт 130 хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд нь иргэдэд хүлээлт чирэгдэл үүсгэлгүйгээр 100% шийдвэрлэсэн. Үүнээс талархал 47,3%, хүсэлт 48,6%, гомдол 4,1%-ийг эзэлж байгаа бөгөөд нийт талархлын 89,2 хувийг өрхийн эрүүл мэндийн төв болон хувийн хэвшлийн байгууллагын хамт олонд ирүүлсэн талархал эзэлж байна. Мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төвд ирүүлсэн 6 иргэний хүсэлтийг цахимаар хүлээн авч хуулийн дагуу шийдвэрлэн аймгийн Засаг даргын тамгын газрын холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. Өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн мэдээлэл нь аймгийн ЗДТГ-ын шуурхай хурал, erdenet.mn , 70353511 дугаарт утсанд бүртгэгдэн мэдээлэгдэж, Эрүүл мэндийн газрын www.or.mohs.gov.mn цахим хуудаст байршуулж ил тод байдлыг ханган ажилласан. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг ЭМЯ болон аймгийн ЗДТГ-т хугацаанд нь хүргүүлэн ажилласан.	100
73	1.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль, Шилэн дансны тухай болон Жендерийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх		Хэрэгжилтийн хувь	90%	90%	Авлига, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 92%-тай байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хэмжээнд гэмт хэрэг гарах, халдлагад өртөхөөс урьдчилан зорилгоор “Тэгшийн гол морьт” ХХК-тай гэрээ хийж 24 цагийн биечилсэн харуул хамгаалалтын ажилтнуудыг ажиллуулж, 108 хяналтын камер суурилуулан ашиглаж байгаагаас гадна талын 4, нийтийн эзэмшлийн талбайд 66, эмнэлгийн дотоод үйл ажиллагааны хяналтад зориулсан 42 IP хяналтын камер, Эрүүл мэндийг дэмжих төвд 8 камерыг суурилуулан ашигласан. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу заавал байршуулах 5 талбарын 130 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулан олон нийтэд мэдээлсэн ба байгууллагын санхүүгийн ил тод байдлын самбар, байгууллагын цахим хуудаст бүрэн	100

						байршуулсан. Жендерийн хууль тогтоомжийн хэрэгжүүлэх хүрээнд эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулж хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байранд жендерийн эрх тэгш байдлыг хангах зэрэгт анхааран ажилласан. Тайлант хугацаанд гэмт хэрэг, зөрчил, ажлын байран дээрх ялгаварлан гадуурхалт, хүний эрхийг зөрчсөн асуудал бүртгэгдээгүй байна. Тус төлөвлөлтүүдийн хэрэгжилтийн дундаж 90,6%-тай байна	
74	1.5. Хариуцлагын тогтолцоог үйл ажиллагаандаа мөрдүүлэн албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлж хууль, тогтоомжийг сахин биелүүлэх, сахилга бат, хариуцлагын чиглэлээр гарсан тогтоол шийдвэрийн хүрээнд тайлангийн хугацаанд төлөвлөгөөг гарган үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн мөрдүүлэх арга хэмжээг авч ажиллах		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	85	86%	Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбар байгууллагуудын шуурхай танхимаар 21, Эрүүл мэндийн газрын шуурхай танхимаар 31 удаа хуралдан, мэдээллээр ханган, үүрэг даалгавар өгч ажилласан. Эрүүл мэндийн газрын Удирдлагын зөвлөлийн хурал 13 удаа хуралдан эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлууд, ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлүүдийг хэлэлцэж, сахилга хариуцлагыг өндөржүүлж, гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан ажилласан. Тус хугацаанд Эрүүл мэндийн сайдын албан даалгавар 6 Эрүүл мэндийн сайдын тушаал 15 аймгийн Засаг даргын захирамж 21 Эрүүл мэндийн газрын даргын А тушаал 92, Б тушаал-53 батлагдсаныг хяналтад аван Эрүүл мэндийн газрын www.or.mohs.gov.mn цахим хуудаст байршуулж, салбар байгууллагуудад хүргүүлж сурталчлан хэрэгжилтийг ханган ажилласан. Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагууд албан хаагчдын цаг ашиглалтад хяналт тавин улирал тутам үр дүнгийн урамшуулалд нэг үзүүлэлт болгон оруулж цаг ашиглалтыг сайжруулан ажилласан. Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналтыг <u>Жаргалант сумын</u> эрүүл мэндийн төв, төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй өрхийн эрүүл мэндийн төвүүд, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд тус бүр 1 удаа хийж, хяналтын дүнг ЭМГ-ын Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн зөвлөмжөөр ханган, ажлын гүйцэтгэлийг сайжруулах чиглэлээр үүрэг чиглэл өгч ажилласан. Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн хууль бусад хууль тогтоомж зөрчсөн сахилгын арга хэмжээ авагдсан тохиолдол гараагүй байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 85,8	80
75	1.6. Байгууллагын хэмжээнд И оффис системийг бүрэн ашиглах		Системийн ашиглалт	90%	90-100%	ЭМГ-ын даргын А/56 дугаар тушаалаар “Байгууллагын дотоод үйл ажиллагааны и-оффис системийг ашиглах нийтлэг журам”-ын хэрэгжилтэд байгууллагын Дотоод хяналтын баг хяналт хийж 90 хувьтай үнэлэгдсэн бөгөөд 3 заалт бүхий зөвлөмж ирүүлсэн.	100

						Зөвлөмжийн дагуу албан хаагчдад И-оффис системийн биелэлтийг албан хаагч бүрээр гаргаж шуурхай хурал дээр танилцуулсан. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн систем ашиглаж байгаа эмч, мэргэжилтнүүд, Эрүүл мэндийн газарт шинээр орсон 7 албан хаагчид систем ашиглалтын гарын авлагыг нэг бүрчлэн хүргүүлж ашиглалтыг, хянах ажлуудыг зохион байгуулсан. Тус программаар нийт 485 албан бичиг хүлээн авч 295 бичиг хүргүүлж, иргэдээс 112 санал хүсэлт, талархал хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Мөн И системд холбогдсон албан хаагчдын 6 төрлийн мэдээллийг бүрэн шинэчилж И оффис системийг ашиглалт 100% байна,	
Нийтлэг чиг үүрэг №2. Хэвлэл мэдээлэл							
76	2.1. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах		Мэдээлэл сурвалжилгын тоо	98	98	Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар нийт 107 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизтэй хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн.	100
77	2.2. Аймаг, орон нутгийн батлан хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, дэд хөтөлбөрүүдийг иргэд олон нийтэд хүргэх, зохион байгуулж буй үйл ажиллагааг иргэд олон сурталчлах ⁴		Сурталчилсан тоо	13	16	<ul style="list-style-type: none"> - Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй 23 хөтөлбөрийг 30 албан хаагчид сурталчилсан. - Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хурлаар батлуулсан “Хамтдаа Эрдэнэт хөгжье” хөтөлбөрийн дагуу ажлын хэсгийн хуралд 2 удаа оролцож, төлөвлөгөөнд нийт 4 ажлыг тусгуулсан. Эрүүл мэндийн байгууллагууд хамтран Улаанбаатар хотод АШУҮИС, ЭТҮГЭН их сургуулийн 5-6 дугаар курсийн 280 гаруй оюутан, удирдлагуудыг оролцуулсан өдөрлөг зохион байгуулж аймгийн эрүүл мэндийн салбарын хүрээнд баримталж буй бодлого шийдвэрийг танилцуулсан. - “Эмч” хөтөлбөрийн 2023 оны хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөл болон Иргэдийн хурлын зөвлөлөөр хэлэлцүүлж, хэрэгжилтийг видео бичлэг болгон хэвлэл мэдээллийн хэрэгслээр ЭМГ-ын сайт болон цахим хуудсаар түгээн сурталчилсан. - Эрүүл мэндийн газраас 2023 онд хийгдсэн шинэлэг ажлын нэвтрүүлэг, сэтгүүлийг бэлтгэж цахимд байршуулсан. - Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан 21 захирамжийг хэрэгжүүлэх явцад зохион байгуулсан үйл ажиллагааг тухай бүр сурталчлан ажилласан. - Хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, тусламж үйлчилгээний чанарын талаарх иргэдийн сэтгэл ханамжийг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, магадлан итгэмжлэгдсэн эмнэлгүүд QR кодоор 	100

						авч үнэлж байгаа бөгөөд Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс хөндлөнгийн үнэлгээг хийж байна.	
Нийтлэг чиг үүрэг №3. Төсөв, санхүү, эдийн засаг							
78	3.1. Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4 болон 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон ажиллах ⁵		Өр авлага үүсээгүй байна	-	-	2023 оны 12 сарын байдлаар авлага үүсгэлгүй батлагдсан төсөв, гүйцэтгэлийн санхүүжилтэд үндэслэн санхүүжилтээ авч ажилласан. 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэлээр өр төлбөргүй гарсан бөгөөд 2023 оны эхний 12 сарын байдлаар эрүүл мэндийн салбар нийт 1.959,6 сая төгрөгийн өр төлбөртэй байна. Тухайлбал: - Бүсийн оношилгоо эмчилгээний төв 1,918.1 сая төгрөг - Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд нийт 41,4 сая төгрөгийн өр төлбөртэй байгаа нь цахимаар төрийн сангийн гүйлгээ хийж эхэлсэнтэй холбоотой харилцагч байгууллагуудаас анхан шатны баримт материалыг дутуу өгснөөс үүдэн шилжүүлгийг хийж чадаагүйгээс үүссэн өр төлбөр байна. Мөн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас авах авлага 2.640,0 сая төгрөг байгаа бөгөөд оны эцэст авлагаараа өр төлбөрөө бүрэн барагдуулах боломжтой байна. 2023 оны жилийн эцэс буюу 12 сарын төсвийн хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулах замаар өр төлбөрийг бүрэн барагдуулж ажиллахаар Эрүүл мэндийн яаманд саналыг албан бичгээр хүргүүлсэн байна	90
79	3.2. Өмч хөрөнгийн бүртгэл, тооллого, хөдөлгөөн, ашиглалт хамгаалалт, эзэмшигчийн хариуцлагыг дээшлүүлэх ажлыг байгууллагуудын хэмжээнд сайжруулах арга хэмжээг авч ажиллах		Арга хэмжээний тоо	2	2	Эрүүл мэндийн газрын 2022 оны А/57 дугаар тушаалаар байгуулагдсан Өмч хамгаалах байнгын зөвлөл нь 2023 оны ажлын төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэн ажилласан. Тус зөвлөл 3 удаа хуралдаж ЭМГ-ын Удирдлагын зөвлөлийн хурлаар 1 асуудлыг хэлэлцүүлж, шийдвэрийг хэрэгжүүлсэн. Эрүүл мэндийн газрын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 9 төрлийн 24 ширхэг хөрөнгийг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шилжүүлэхээр аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүсэлт хүргүүлж, Орхон аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/212 дугаар захирамжаар шилжүүлсэн. Байгууллагын албан хаагчийн хөрөнгийн картыг шинэчилж баталгаажуулсан. Эрүүл мэндийн газраас 17 нэр төрлийн хөрөнгийг акталж Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгсөн. Орон нутгийн өмчийн газарт 3 өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга байгууламж 8, газар 4, нийтийн эзэмшлийн талбай 5 нийт 17 нэр төрлийн 549,2 сая	100

						төгрөгийн хөрөнгийг шилжүүлэхээр аймгийн Засаг даргын захирамжид тусгуулсан.	
Нийтлэг чиг үүрэг №4. Тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээ							
80	4.1. Монгол улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2023 оны улсын болон аймгийн жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж тайлагнах		Биелэлтийн хувь	90%-94%	92-94%	2023 оны байдлаар Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 93,9%-тай /тодорхой үр дүнд хүрсэн/, Монгол улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт 97,8%-тай /тодорхой үр дүнд хүрсэн/ дүгнэгдсэн. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд эрүүл мэндийн салбартай хамааралтай 10 зорилтын хүрээнд 25 арга хэмжээний хүрээнд хийгдсэн хэрэгжилт дунджаар 96,4%, аймгийн хөгжлийн 2023 оны жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 92,6%-тай дүгнэгдсэн. Хяналт шинжилгээний дүнг Эрүүл мэндийн газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, тайланг Эрүүл мэндийн яам болон аймгийн Засаг даргын тамгын газарт албан тоотоор хугацаанд нь хүргүүлсэн.	100
81	4.2. Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргын 2023 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж тайлагнах		Хэрэгжилтийн хувь	95%	90-95%	Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргын 2022 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтээр улсад 5 дугаар байр эзэлсэн. Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргын 2023 онд хамтран ажиллах гэрээнд 8 чиглэлээр 55 заалт тусгагдан хэрэгжүүлэн ажилласан. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.	-
82	4.3. Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тогтоосон хугацаанд тайлагнах		Хэрэгжилтийн хувь	92,5%	92,8%	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу Эрүүл мэндийн газраас нэгтгэгдэн гарч буй хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгийн 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх явцад албан хаагчдыг зөвлөмжөөр ханган тайланд тухай бүр сайжруулалт хийж, илтгэх хуудсыг албан хаагчдад хүргүүлэн ажилласан. Нийт 20 тайланд хяналт шинжилгээ хийгдсэн. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хяналт шинжилгээний дүнг Эрүүл мэндийн газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн И оффис системд оруулж, тайланг Эрүүл мэндийн яам болон аймгийн Засаг даргын тамгын газарт албан тоотоор хугацаанд нь хүргүүлсэн. Хэрэгжилтийн дундаж хувь 93%-тай байна.	100
83	4.4. Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний		Хяналт-шинжилгээ,	2	2	Тайлант хугацаанд 2023 оны эхний хагас болон жилийн эцсийн байдлаар Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг	100

	хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмжөөр хангах		үнэлгээний дүн, зөвлөмж			Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох байгууллагуудад хэрэгжилтийг хурлын тэмдэглэлийн хамт хүргүүлэн ажилласан. 2023 онд Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 чиглэлийн дагуу 96 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан ба хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 95,5%-тай үнэлэгдсэн. Хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлэн ажилласан.	
84	4.5. Байгууллагад хийгдэх дотоод хяналтыг удирдан зохион байгуулж, төлөвлөгөөний дагуу хяналт хийж, зөвлөмж өгөх		Дотоод хяналт хийгдсэн тоо	10	10	Байгууллагын Дотоод хяналтын багийг шинэчлэн байгуулах тухай Эрүүл мэндийн газрын даргын А/44 дүгээр тушаал, 2023 оны төлөвлөгөөг батлуулан ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай байна. Тайлант хугацаанд төлөвлөгөөт 8, төлөвлөгөөт бус 3 нийт 11 хяналтыг хийж 2 хяналтын дүгнэлтийг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох эрүүл мэндийн салбар, албан хаагчдад хяналтын дүнг танилцуулан зөвлөмжөөр ханган ажилласан.	100

ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, иргэн бүрийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.

Зорилт 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах

85	1.1.1. Эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, сургалт, сурталчилгаа, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх үйл ажиллагааг шинэлэг хэлбэрээр зохион байгуулж, салбар дундын хамтын ажиллагааг ханган хамтран ажиллах ⁵	Эрүүл мэндийг дэмжих сан 29.5 ОНТ 29.0	Сургалт сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо	139900	140000	Тайлант хугацаанд нийт 131 удаагийн сургалт, сурталчилгаа зохион байгуулж давхардсан тоогоор 28288 иргэнийг хамруулж, 80 төрлийн сурталчилгааны материалыг 2500 иргэнд түгээсэн. Цахим хуудаст 644 төрлийн гарын авлага, шторка, зөвлөмжийг байршуулан 1588230 хандалттай байна. Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар нийт 107 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизтэй хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 4 төслийг хэрэгжүүлэн ажилласан. - Эрүүл мэндийг дэмжих сангаас 13,5 сая төгрөгийн “Ний нуугүй ярья” төсөл, 16,0 сая төгрөгийн “Сэтгэцийн эрүүл мэндийг хүн бүрт” төсөл хэрэгжүүлж, 1000 хүнд бэлгийн эрүүл мэндийн боловсрол олгож, 3000 гаруй хүнд сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгож хүрч ажилласан байна. - Орон нутгийн 29,0 сая төгрөгийн санхүүжилтээр “Энэ жилдээ эрүүл жиндээ” төслийг хэрэгжүүлж, төрийн 10 байгууллагын 60 хүн хамрагдан, төслийн хүрээнд нийт оролцогчид 93,4 кг жин хаясан. - “Зөвийг дадал болгоё” төслийн хүрээнд ерөнхий боловсролын	100
----	--	---	--	--------	--------	--	-----

						сургуулийн 4-5 дугаар ангийн 2100 сурагч, 500 иргэнийг шүд угаах сургалтад хамруулан, мэдлэг, дадал олгон, шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагт анх удаа зохион байгуулсан.	
86	1.1.2. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг дэмжин ажиллах	ОНТ 25.0	Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын тоо	6	8	Тайлант хугацаанд эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 8 төрийн бус байгууллагатай хамтран ажилласан. Тухайлбал: <ul style="list-style-type: none"> - Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн сайн дурын 8 идэвхтэнтэй хамтарч сүрьеэ өвчнөөр эмчлэгдэж байгаа 16 иргэний эмийг хяналттай уулгасан. Мөн 35 иргэнд аминдэм олгож, давхардсан тоогоор 40 иргэнд хүнсний тусламж олгосон байна. - Эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах хүрээнд “Гэсэр Ундарга” төрийн бус байгууллагатай хамтран 1 сарын аян зохион байгуулсан. - Аймгийн явган алхалтын холбоотой хамтран “Энэ жилдээ эрүүл жиндээ” явган алхалтыг 2 удаа зохион байгуулж 250 гаруй хүн хамрагдсан. - Сэтгэлийн анир төслийн хүрээнд сэтгэл зүйчдийн багтай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 100 эцэг эх, сургуулийн 8 -12 ангийн 726 хүүхдийг сэтгэл зүйн судалгаанд хамруулж, 12 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө, 150 иргэнд бүлгийн ярилцлага 78 иргэнд сургалт зохион байгуулж, цахим зөвлөмжийг давхардсан тоогоор 5600 гаруй иргэнд хүргэсэн. -“Харилцааны гайхамшиг” төрийн бус байгууллагатай хамтран уулзалт ярилцлагыг 2 удаа зохион байгуулж 80 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. - Эрүүл мэндийг дэмжих сангийн 16,0 сая төгрөгийн санхүүжилтээр “Ариунсаруулбат” төрийн бус байгууллага “Сэтгэцийн эрүүл мэндийг хүн бүрт” төсөл хэрэгжүүлж, 3000 гаруй хүнд сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгосон байна. - “Энхийн хөтөч” төрийн бус байгууллагатай хамтран сургуулийн нийгмийн ажилтан, эцэг эхийн төлөөлөл 86 хүнд өсвөр үеийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндийн сургалтад хамруулсан. - Монголын шүдний ерөнхий эмч нарын холбоотой хамтран “Шүд угаалтын аварга шалгаруулах” тэмцээнд 23 сургуулийн 184 сурагч,152 багшийг хамруулж зохион байгуулсан. 	100

						- Орхон аймгийн шүдний мэргэжилтний холбоотой хамтран “Амны хөндийн эрүүл ахуйн” мэдлэг хандлага дадлыг тодорхойлох судалгаанд 757 хүнийг хамруулан хийсэн.	
87	1.1.3. Нийгмийн халамж нэн шаардлагатай жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг аминдэмд хамруулах ³	ОНТ 10.0	Аминдэмжүүлэлтийн хангалтын хувь	12%	15%	- Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхийг аминдэмжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2023 оны А/195 дугаар захирамжаар батлагдсан 10.0 сая төгрөгийн санхүүжилтийн хүрээнд сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 20100 ширхэг аминдэмийг хуваарилан 689 эхийг 100% амин дэмжүүлсэн. Аминдэмжүүлэлтэд хамрагдсан нийт 689 эхээс цус багадалттай 264 эх байгаа нь 38.3 хувийг, нийгмийн халамж дэмжлэг нэн шаардлагатай бүлгийн 128 эх, эх барихын ужиг дутагдалтай 297 эхийг аминдэмжүүлж, эх барихын хүндрэлгүй төрүүлсэн. Эхийн аминдэмийн төсөв өмнөх онтой харьцуулахад 42 хувиар, аминдэмд хамрагдах эхийн тоо өмнөх онтой харьцуулахад 1.4 дахин нэмэгдсэн.	100
88	1.1.4. Хорт хавдартай иргэдийн эмийн болон эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх	ОНТ 69.8	Дэмжлэгт хамрагдсан хорт хавдартай иргэдийн хувь	17,2%	17,2	Тайлант хугацаанд хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр орон нутгийн төсвөөс 162 иргэнд 69.8 сая төгрөгийг тус тус олгосон байна. Тайлант хугацаанд хавдрын 159 тохиолдол бүртгэгдэж, хяналтад орсноос эмийн болон эмчилгээний дэмжлэгт 69.2 хувь нь хамрагдсан байна.	100
Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангаж, орчин үеийн оношилгоо эмчилгээний дэвшилтэт технологийг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.							
Зорилт 1. Эмнэлгийн яаралтай тусламжийн төвлөрлийг сааруулах, иргэдэд үзүүлэх яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх.							
89	2.1.1. Яаралтай тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад нэгж байгуулах, амь тэнссэн тусламж үйлчилгээг үзүүлэх чадавхыг нэмэгдүүлэх ³	БОЭТ гүйцэтгэлийн санхүүжилт 45.0	Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний чадавх	85%	90%	Яаралтай тусламж үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэх хүрээнд хүний нөөцийн чиглэлээр: - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төгсөлтийн дараах сургалтын сургалтад 2022-2023 оны хичээлийн жилд “Яаралтай тусламжийн сувилахуй”-аар 8, “Эрчимт эмчилгээний сувилахуй”-аар 8 суралцагчийг төгсгөж, “Яаралтай тусламжийн сувилахуй”-аар 4, “Эрчимт эмчилгээний сувилахуй”-аар 1 сувилагч суралцаж байна. - Хувийн хэвшлийн 7 эмнэлэг яаралтай тусламжийн мэргэшсэн сувилагчийг ажиллуулж байна. - БОЭТ-ийн Яаралтай тусламжийн тасагтай хамтран 7 удаагийн сургалтад 52 эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнийг хамруулж чадавхжуулсан. - Амилуулах суурь тусламжийг сайжруулах ажил мэргэжлийн уралдааныг Монголын Яаралтай тусламжийн Нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж 14 багийн 70 эмч, эмнэлгийн	100

						<p>мэргэжилтэн хамрагдаж, орчин үеийн технологи Kahoot, Quiz maiker программыг анх удаа ашиглан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн гардан болон онолын мэдлэгийг нэмэгдүүлсэн. Мөн амилуулах суурь тусламжаар 121 эмч эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжууллаа.</p> <p>Тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - БОЭТ-ийн Төрөх тасгийн хүлээн авах тасагт SAMSUNG ЭХО аппаратын датчикийг байгууллагын 45 сая төгрөгийн санхүүжилтээр шийдвэрлэж оношилгооны чадавхыг нэмэгдүүлсэн. - Яаралтай түргэн тусламжийн тасагт шархны анхдагч цэгцлэлтийн багажаар хангасан. - Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалт 95% байна. <p>БОЭТ-ийн түргэн тусламжийн тасагт туулах чадвар сайтай, бүрэн тоноглогдсон 7, хагас тоноглогдсон 4 нийт 11 машин яаралтай тусламжийн дуудлагад үйлчилж ажилласан.</p> <p>Түргэн тусламжийн үйл ажиллагааны зардалд орон нутгаас 285 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд нийт 14686 дуудлагад үйлчилснээс алсын дуудлага 286 буюу 1,9% байна. Нэн яаралтай тусламжийн дуудлагад 20 минутын дотор очсон хувь 100% байна. Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний чадавх, мэргэшсэн хүний нөөц, багаж тоног төхөөрөмжийн хангалт өмнөх оноос 5 хувиар нэмэгдэж 90 хувьд хүргэсэн.</p>	
90	2.1.2. Түргэн тусламжийн төв, салбаруудын үйл ажиллагааг жигдрүүлэх, түргэн тусламжийн үйлчилгээг шуурхай үзүүлэх	ОНТ 285.0	Түргэн тусламжийн төвийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ, Яаралтай дуудлагад 20 минутын дотор очсон хувь	98%	98%	<p>Түргэн тусламжийн гэр хорооллын салбарыг Учралтбаяр, Нийцэл өрхийн эрүүл мэндийн төвүүдэд байрлаж тусламж үйлчилгээг үзүүлж байна. Түргэн тусламжийн үйл ажиллагааны зардалд орон нутгаас 285 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Түргэн тусламжийн үйл ажиллагаанд 2 удаа хяналт хийж, зөвлөмжөөр ханган ажилласан. Тайлант хугацаанд нийт 14686 дуудлагад үйлчилснээс алсын дуудлага 286 буюу 1,9%. Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн дуудлага 360, алсын дуудлага 74 буюу 20,5%-ийг тус тус эзэлж байна. Аймгийн хэмжээнд БОЭТ-ийн Яаралтай түргэн тусламжийн тасгийн 11 машин дуудлагад үйлчилж байна.</p> <p>Яаралтай тусламжийн дуудлагад 20 минутын дотор очсон хувь 100% байна.</p>	100

Зорилт 2. Анхан шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг нэг цэгээс тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх

91	2.2.1. Алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын тусламж үйлчилгээ”-г зохион байгуулах ⁴	ОНТ 30.0	Тусламж үйлчилгээнд хамрагдсан хувь	10%	12%	Тайлант хугацаанд явуулын тусламж үйлчилгээнд нийт 31859 иргэн буюу нийт хүн амын 29,9%-ийг хамруулсан байна. Үүнд: - Жаргалант сумын алслагдсан өрхийн иргэд, Баян-Өндөр сумын 10 чиглэлд оторлож буй малчдад сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар 2 удаа явуулын тусламж үйлчилгээг үзүүлж 105 өрхийн 365 иргэнд эрүүл мэндийн анхан шатны явуулын тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. - Цагдаагийн газар болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хорих ангийн 420 алба хаагчийг хамруулан ажлын байран дээр явуулын үзлэгийг зохион байгуулж, зөвлөмжөөр хангасан. - “Эрүүл эрдэнэт хүн” төслийн хүрээнд 29 багийн 31074 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг явуулаар хүргэсэн байна. Орон нутгийн төсвөөс алслагдсан багийн иргэдийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр явуулын тусламж үйлчилгээнд 30,0 сая төгрөгийг шийдвэрлэсэн.	100
Стратегийн зорилго 6. Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага зохион байгуулалт ил тод байдлыг ханган ажиллах							
1. Төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган, төрийн үйлчилгээг сайжруулах							
92	6.1.1. Чанарын ISO 9001-2015 стандартыг эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлэх		Чанарын ISO 9001-2015 стандарт нэвтэрсэн байгууллагын тоо	1	2	Тайлант хугацаанд Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001-2015 стандартыг 4 өрхийн эрүүл мэндийн төв, 3 хувийн хэвшлийн ортой клиникт нэвтрүүлж, 2 удаагийн баталгаажилтад оруулан, 6 байгууллага гэрчилгээгээ гардан авсан. Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001-2015 стандартын хүрээнд: - Дотоод аудитор бэлтгэх сургалтыг орон нутагтаа 2 удаа зохион байгуулж нийт 53 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд дотоод аудиторын гэрчилгээг олгосон. - G2G сургалтын төвийн тэргүүлэх аудиторуудтай хамтран чанарын менежментийн тогтолцоо ISO 9001-2015 стандартын сургалтад нийт 162 албан хаагчийг хамруулсан. - “MOSHPA” сургалтын төвөөс эрсдэлийн менежментийн сургалтыг орон нутагт зохион байгуулж Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001-2015 стандартыг нэвтрүүлсэн байгууллагуудын удирдлага, эрсдэл хариуцсан ажилтныг хамруулж гэрчилгээ олгосон. - Монголын дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын хөгжил холбоотой хамтран дотоод хяналтын болон эрсдэлийн удирдах арга зүйн сургалтад 100 эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан олгосон.	100

93	6.1.2. “Хамтдаа Эрдэнэтэд хөгжье” хөтөлбөрийг хэрэгжүүлэн Улаанбаатар хотоос орон нутагт шилжин ирж буй эрүүл мэндийн ажилтныг дэмжих ажиллах		Шилжин суурьшсан эрүүл мэндийн ажилтны тоо	-	5-10	<p>“Хамтдаа Эрдэнэтэд хөгжье” хөтөлбөрийн хүрээнд эрүүл аймгийн мэндийн салбарын төлөөлөл 13 удирдлага АШУУИС, Этүгэн их сургуулийн удирдлага болон эмчилгээний ангийн 5,6 дугаар курсийн 280 гаруй оюутныг хамруулан орон нутагт шилжин суурьших боломж, шаардлагатай мэргэжлийг сурталчлах өдөрлөгийг зохион байгууллаа. Тус өдөрлөгийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын танилцуулга сурталчилгааны материалыг түгээж, видео танилцуулгыг хүргэн, АХА тэмцээн зохион байгуулан, чөлөөт ярилцлагыг зохин байгуулсан. Мөн орон нутгийн хэвлэл мэдээлэл болон UBN телевизийн ярилцлагад холбогдох удирдлага, ногоон карт авсан оюутнуудыг оролцуулан сурталчилсан.</p> <p>Улаанбаатар хот болон бусад аймгаас шилжин ирсэн 11 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байраар хангасан.</p>	100
94	6.1.3. Байгууллагын хэмжээнд иргэд, олон нийтэд хүрсэн шинэлэг ажлыг зохион байгуулж үр дүнг мэдээлэх		Зохион байгуулсан шинэлэг ажлын тоо	2	2	<p>Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын хэмжээнд иргэд олон нийтэд хүрсэн 11 ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 35679 хүнийг хамруулсан. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> - Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд төрийн байгууллага, албан хаагчдад сар бүрийн эхний 7 хоногт сургалт зохион байгуулж хэвшсэн бөгөөд тайлант хугацаанд нийт 1180 албан хаагчийг сургалтад хамруулсан байна. - “Сувилахуй ба эрх зүй” сургалт, хэлэлцүүлэг, “Сувилагч ба эрүүл мэнд” аяныг УИХ-ын гишүүн Д.Батлут, Ж.Чинбүрэн гишүүний ажлын албатай хамтран зохион байгуулж, төвийн бүсийн 6 аймгийн 300 гаруй сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд оролцлоо. - Сувилагчийн мөн чанар үнэ цэнийг сурталчлан таниулах өдөрлөг 9 удаа зохион байгуулж 14 сургуулийн 723 сурагчийг хамруулсан. - Мэргэжил сурталчлах өдөрлөгийг зохион байгуулж АШУУИС, Этүгэн их сургуулийн удирдлага болон эмчилгээний ангийн 5,6 дугаар курсийн 280 гаруй оюутныг хамруулсан. - Эмч тандаа баярлалаа” өдөрлөгийн үеэр алслагдсан 3 багийн 475 иргэдийг хамруулж, сурталчилгаа, үзлэг оношилгоо хийгдсэн. - “Бүх хайраа гэр бүлдээ өдөрлөгөөр 500 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сурталчилгааг хийж ажилласан байна. 	100

						<ul style="list-style-type: none"> - Энэ жилдээ Эрүүл жиндээ аяны хүрээнд 691 хүний биеийн жингийн индекс, өөхлөг эдийн хэмжээг тодорхойлж, цахимаар зөвлөмжийг 31598 иргэнд хүргэсэн. - “Мэдсэнээ хуваалцъя- Мэдээлэл хүргэе” аяны хүрээнд нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, оношилгоо, зөвлөгөө, мэдээлэл сурталчилгаанд хөгжлийн бэрхшээлтэй 120 иргэнийг хамруулсан. - Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээнд 23 сургуулийн 184 сурагч, 152 багшийг хамруулж зохион байгуулсан. - Соёлыг түгээе” аяны хүрээнд соён гэгээрүүлэх чиглэлээр 3 сургалт, 9 олон нийтийн нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. - “Эрүүл эрдэнэт хүн” төслөөр 29 багийн 31074 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэж, Орхон аймгийн нийт хүн амын 29,3%-д, эрүүл мэндийн даатгалгүй 955 иргэнийг хамруулсан нь зорилтот бүлгийн 39,6%-д хүрсэн. 	
95	6.1.4. Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг ил тод цахимжуулах, хөнгөн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах ⁴		Цахимжуулсан үйлчилгээний тоо	2	1-2	<p>Цахимаар үзүүлж буй үйлчилгээний талаар erdenet.mn, or.mohs.gov.mn, Орхон аймгийн Эрүүл мэндийн газар цахим хуудас, олон нийтийн сүлжээнд мэдээ мэдээллийг байршуулан, иргэдэд түгээсэн. Цахимаар иргэдэд хүргэж буй үйлчилгээ:</p> <ul style="list-style-type: none"> - Засгийн газар, ЭМЯ-наас E-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн системийн хөгжүүлэлтийг нэгдсэн журмаар зохион байгуулж байгаа бөгөөд тус "E-Mongolia" системээс эрүүл мэндийн 17 төрлийн үйлчилгээг иргэн авч байна. - Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй “Цахим Эрдэнэт-1” төслийн хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн гэрийн дуудлага, гэрийн эргэлт болон Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн түргэн тусламжийн дуудлагын үед цахим программд үзлэгийн бүртгэл хөтлөх ажиллагааг хялбаршуулах, хөнгөлөлттэй эмийн жорыг тухайн газарт нь бичиж, кодыг олгох зориулалтаар ашиглах зөөврийн таблет ашиглаж байна. - Хувийн хэвшлийн клиникүүдийн статистик мэдээг google формат ашиглан цахимаар авч байгаа нь мэдээний ирцийг нэмэгдүүлсэн. 	100
96	6.1.5. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	90%	<p>ЭМГ-ын даргын 11 сарын А/92 тоот тушаалаар Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж ажлын төлөвлөгөөг гарган батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж төлөвлөгөөний хэрэгжилт 95%-тай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Аймгийн Засаг даргын тамгын гарын болон Нийгмийн даатгалын хэлтсийн цахим архивын үйл ажиллагаатай танилцан туршлага судаллаа. 	100

						<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар архивын хадгаламжийн нэгжүүдийг Төрийн архивт шилжүүлэх, салбар байгууллагуудын баримтыг акт үйлдэж, буцаан өгөх, хадгалах хугацаа дууссан баримтуудыг устгах ажлуудыг зохион байгуулсан. - Албан хаагчдын 2022 оны хадгаламжийн нэгжүүдийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу тулган, баримтын үнэ цэнийг нягтлан шалгаж нийтлэг 5 зөрчлийг арилгуулан 147 хадгаламжийн нэгжийг архивт хүлээн авсан. 	
Хэрэгжилтийн дундаж хувь 95.4% (тодорхой үр дүнд хүрсэн)							

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

Орхон аймгийн Эрүүл мэндийн газар

2023 оны 12 дугаар сарын 12

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар байгууллагын цахим хуудас or.mohs.gov.mn болон мэдээллийн самбарт ил тодоор байршуулан, тухай бүр шинэчилсэн. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн orkhonboet.moh.gov.mn цахим хуудсаар болон эрүүл мэндийн салбар байгууллагууд нийгмийн сүлжээний цахим хуудсандаа ил тодоор байршуулж байна. Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй бодлого зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төрийн үйлчилгээ үзүүлж байгаа ажил хариуцсан албан хаагчдын овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, харилцах утас зэрэг мэдээллийг шинэчлэн байгууллагын цахим хуудас, төрийн албан хэрэг хөтлөх И оффис программд болон байгууллагуудын мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулсан. Эрүүл мэндийн газар /www.or.mohs.gov.mn/ , Бүсийн оношилгоо эмчилгээний төв /www.orkhonboet.moh.gov.mn/ зэрэг байгууллагууд байгууллагын вэб сайттай бөгөөд бусад эрүүл мэндийн байгууллагууд facebook page хуудас ажиллуулан мэдээллийг иргэдэд хүргэн ажилласан. Тайлант хугацаанд /www.or.mohs.gov.mn/ Эрүүл мэндийн газрын вэб хуудсыг шинэчилсэн. Мөн Орхон аймгийн Эрүүл мэндийн газар Facebook page хуудсыг тогтмол ажиллуулж иргэдэд эмнэлгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэж ажилласан бөгөөд тус page хуудсыг 13000 хүн дагаж байна.	100
1.2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Аймгийн Засаг даргын 2023 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн А/84 дүгээр захирамжаар Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тоо, үйл ажиллагааны чиг үүргийг шинэчлэн баталсан. Шинэчлэгдсэн бүтэц, чиг үүргийг байгууллагын цахим хуудас www.or.mohs.gov.mn болон нийгмийн сүлжээний facebook хуудсанд ил тодоор байршуулсан. Мөн байгууллагын хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаягийг www.or.mohs.gov.mn цахим хуудаст ил тодоор байршуулсан.	100

1.3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	<p>Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт, статистик үзүүлэлтэд дүн шинжилгээ хийн сар, улирлаар гарган анхан шатны эрүүл мэндийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудын цахим систем, Эрүүл мэндийн газрын вэб сайтад ил тод байршуулсан. Эрүүл мэндийн салбарын удирдлагын шуурхайд улирал тутам статистик үзүүлэлтийг танилцуулан эргэн мэдээллээр ханган ажилласан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу Эрүүл мэндийн газраас нэгтгэгдэн гарч буй хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх явцад албан хаагчдыг зөвлөмжөөр ханган тайланд тухай бүр сайжруулалт хийж, илтгэх хуудас, зөвлөмжийг албан хаагч тус бүрд хүргэн ажилласан. Нийт 25 тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдсэн. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн тухай Эрүүл мэндийн газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, тайланг Эрүүл мэндийн яам болон аймгийн Засаг даргын тамгын газарт албан тоотоор хугацаанд нь хүргүүлсэн. Байгууллагын Дотоод хяналтын багийн 2023 оны төлөвлөгөөг батлуулан ажиллаж, тайлант хугацаанд төлөвлөгөөт 8, төлөвлөгөөт бус 3 нийт 11 хяналтыг хийж хяналтын дүгнэлтийг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох эрүүл мэндийн салбар, албан хаагчдад хяналтын дүнг танилцуулан зөвлөмжөөр ханган ажилласан.</p> <p>Төрийн аудитын газраас 2022 оны санхүүгийн тайланд хяналт, шалгалт хийгдэж, Төрийн аудитын газраас ирүүлсэн аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын тайланг аудитын тайлангийн хамт шилэн дансны нэгдсэн системд бүрэн тайлагнасан</p>	100
1.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаар мэдээллийг цахим хуудас болон самбарт шинэчлэн байршуулж сурталчилсан. ЭМЯ-наас Эрүүл мэндийн газрын 2022 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлсэн зөвлөмжийн дагуу байгууллагын гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөг батлуулан, цахим хуудаст байршуулан хэрэгжүүлэн ажилласан. Цахим мэдээллийн аюулгүй байдлын тухай багц хуулиудын сургалтыг эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагууд, мэргэжилтнүүдэд 2 удаа, эрүүл мэндийн байгууллагууд дотооддоо сургалтууд зохион байгуулж нийт давхардсан тоогоор 789 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.</p>	70
1.5	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг цаг хугацаанд нь ЭМГ-ын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүргүүлсэн. Үүнд:	100

		<ul style="list-style-type: none"> - Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн салбартай хамааралтай 29 арга хэмжээний хүрээнд хийгдсэн арга хэмжээний 2023 оны хэрэгжилт дунджаар 90,2%-тай /тодорхой үр дүнд хүрсэн/ үнэлэгдсэн. - Монгол улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний эрүүл мэндийн салбартай хамааралтай 11 арга хэмжээний 2023 оны хэрэгжилт дунджаар 97,8%-тай үнэлэгдсэн. - Тус бодлогын зорилтыг хэрэгжүүлэхээр батлагдсан Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 96,4%, Орхон аймгийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт 93,9%, Орхон аймаг, Эрдэнэт хотын 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт 97,8% дүгнэгдсэн. 	
1.6	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Тус хугацаанд Эрүүл мэндийн сайдын албан даалгавар 6, Эрүүл мэндийн сайдын тушаал 15, аймгийн Засаг даргын захирамж 21, Эрүүл мэндийн газрын даргын А тушаал 92, Б тушаал 53 батлагдсаныг хяналтад аван Эрүүл мэндийн газрын www.or.mohs.gov.mn цахим хуудаст байршуулж, салбар байгууллагуудад хүргүүлж сурталчлан хэрэгжилтийг ханган ажилласан. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хүрээнд 17 хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг 2023 оны байдлаар дүгнэж төрийн албан хэрэг хөтлөлтийн И оффис программд оруулж, байршуулсан. Хэрэгжилт дунджаар 91,2%-тай үнэлэгдсэн. Хүчингүй болсон, хяналтаас хасуулах заалт байхгүй байна. Хэрэгжилтийг ЭМГ-ын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох газруудад хүргүүлэн ажилласан.	100
1.7	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Эрүүл мэндийн газрын төрийн үйлчилгээ үзүүлж байгаа албан хаагчдын овог, нэр, албан тушаал, албан тушаалын тодорхойлолт, албаны харилцах утас, цахим шуудангийн хаягийн мэдээллүүдийг байгууллагын www.or.mohs.gov.mn цахим хуудас, Эрүүл мэндийн газар болон Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Жаргалант сумын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйлчилгээ үзүүлж байгаа албан хаагчдын овог, нэр, албан тушаал, харилцах утас, цахим шуудангийн хаягийн мэдээллүүдийг төрийн албан хэрэг хөтлөх И-оффис программ, аймгийн ЗДТГ-ын erdenet.mn цахим хуудасны лавлагаа мэдээлэл болон байгууллагын мэдээллийн самбарт ил тод нээлттэй байршуулсан.	100
1.8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Байгууллагын өргөдөл гомдол хариуцсан албан хаагчийг томилон ажиллуулж мэдээлэл болон холбоо барих утасны дугаар, өрөөний дугаар болон иргэдээс мэдээлэл, санал, хүсэлт, талархал, гомдол авах цагийн хуваарийг байгууллагын or.mohs.gov.mn цахим хуудасны “Санал гомдол” цэс болон байгууллагын мэдээллийн самбарт ил тод байршуулан мэдээлэл өгч ажилласан. Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын үйл	100

		ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой цахимаар 92, бичгээр 38, нийт 130 хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд нь иргэдэд хүлээлт чирэгдэл үүсгэлгүйгээр 100% шийдвэрлэсэн. Үүнээс талархал 47,3%, хүсэлт 48,6%, гомдол 4,1%-ийг эзэлж байгаа бөгөөд нийт талархлын 89,2 хувийг өрхийн эрүүл мэндийн төв болон хувийн хэвшлийн байгууллагын хамт олонд ирүүлсэн талархал эзэлж байна. Мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төвд ирүүлсэн 6 иргэний хүсэлтийг цахимаар хүлээн авч хуулийн дагуу шийдвэрлэн аймгийн Засаг даргын тамгын газрын холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. Өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн мэдээлэл нь аймгийн <u>ЗДТГ-ын шуурхай хурал</u> , erdenet.mn, 70353511 дугаарт утсанд бүртгэгдэн мэдээлэгдэж, Эрүүл мэндийн газрын www.or.mohs.gov.mn цахим хуудаст байршуулж ил тод байдлыг ханган ажилласан. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг ЭМЯ болон аймгийн <u>ЗДТГ-т</u> хугацаанд нь хүргүүлэн ажилласан	
1.9	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	<p>Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй 176 байгууллагаас үйл ажиллагааны чиглэлээр сар бүр албан ёсны мэдээ тайланг батлагдсан маягтын дагуу 143 үзүүлэлтээр хүлээн авч нэгтгэн, Эрүүл мэндийн хөгжлийн төв болон аймгийн статистик, эрүүл мэндийн байгууллагуудад мэдээлж, байгууллагын цахим хуудас or.mohs.gov.mn-д ил тод байршуулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн салбарын статистик мэдээллийг сар, улирлаар байгууллагын сайт /www.or.mohs.gov.mn/, и-оффис болон телеграм групп, байгууллагын ханын самбарт сар бүр байршуулан мэдээллийн ил тод байдлыг хангасан. - Статистик үзүүлэлтэд дүн шинжилгээ хийн анхан шатны эрүүл мэндийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудын цахим системд байршуулан улирлаар брошур гарган мэдээллээр хангасан. - Мэдээний үнэн зөв байдлыг хангуулах зорилгоор танхимын 6 удаагийн сургалтад эрүүл мэндийн байгууллагуудын бүртгэл статистик хариуцсан ажилтан, байгууллагын удирдлага давхардсан тоогоор 98 хүнийг хамруулсан. - Тайлант хугацаанд мэдээ өгөлт 87,5%, мэдээний чанар 95.6% байна. 	100
1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	<p>Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын хэмжээнд иргэд олон нийтэд хүрсэн 11 ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 35679 хүнийг хамруулсан. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> - Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд төрийн байгууллага, албан хаагчдад сар бүрийн эхний 7 хоногт сургалт зохион байгуулж хэвшсэн бөгөөд тайлант хугацаанд нийт 1180 албан хаагчийг сургалтад хамруулсан байна. - “Сувилахуй ба эрх зүй” сургалт, хэлэлцүүлэг, “Сувилагч ба эрүүл мэнд” аяныг УИХ-ын гишүүн Д.Батлут, Ж.Чинбүрэн гишүүний ажлын албатай хамтран зохион байгуулж, 	100

		<p>төвийн бүсийн 6 аймгийн 300 гаруй сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд оролцлоо.</p> <ul style="list-style-type: none"> - Сувилагчийн мөн чанар үнэ цэнийг сурталчлан таниулах өдөрлөг 9 удаа зохион байгуулж 14 сургуулийн 723 сурагчийг хамруулсан. - Мэргэжил сурталчлах өдөрлөгийг зохион байгуулж АШУҮИС, Этүгэн их сургуулийн удирдлага болон эмчилгээний ангийн 5,6 дугаар курсийн 280 гаруй оюутныг хамруулсан. - “Эмч тандаа баярлалаа” өдөрлөгийн үеэр алслагдсан 3 багийн 475 иргэдийг хамруулж, сурталчилгаа, үзлэг оношилгоо хийгдсэн. - “Бүх хайраа гэр бүлдээ өдөрлөгөөр 500 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сурталчилгааг хийж ажилласан байна. - Энэ жилдээ Эрүүл жиндээ аяны хүрээнд 691 хүний биеийн жингийн индекс, өөхлөг эдийн хэмжээг тодорхойлж, цахимаар зөвлөмжийг 31598 иргэнд хүргэсэн. - “Мэдсэнээ хуваалцъя- Мэдээлэл хүргэе” аяны хүрээнд нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, оношилгоо, зөвлөгөө, мэдээлэл сурталчилгаанд хөгжлийн бэрхшээлтэй 120 иргэнийг хамруулсан. - Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээнд 23 сургуулийн 184 сурагч, 152 багшийг хамруулж зохион байгуулсан. - Соёлыг түгээе" аяны хүрээнд соён гэгээрүүлэх чиглэлээр 3 сургалт, 9 олон нийтийн нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. - “Эрүүл эрдэнэт хүн” төслөөр 29 багийн 31074 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэж, Орхон аймгийн нийт хүн амын 29,3%-д, эрүүл мэндийн даатгалгүй 955 иргэнийг хамруулсан нь зорилтот бүлгийн 39,6%-д хүрсэн. 	
		Хэсгийн дундаж хувь- 97%	
Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод байдал			
2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	<p>Төрийн захиргааны албан тушаалын 8 сул орон тооны мэдээллийг Төрийн албаны салбар зөвлөлийн цахим хуудсанд нээлттэй байршуулж, төрийн албан хаагчийн ерөнхий болон тусгай шалгалт зохион байгуулах захиалгыг Орхон аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж, шалгалтад орсон иргэдийг мэдээллээр хангаж ажилласнаар 5 төрийн захиргааны албан хаагчийг ажлын байраар хангасан. Мөн төрийн үйлчилгээний албан хаагчдын сул орон тооны зарыг www.or.mohs.gov.mn www.orkhonboet.mn, орон нутгийн “Мэдээллийн бирж” телевиз, Эрүүл мэндийн хөгжлийн төв /https://old.hdc.gov.mn/account s.php/, сайтуудад ил тод нээлттэй байршуулж, шаардлагатай 7 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг авч ажиллуулсан.</p>	100

2.2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Эрүүл мэндийн байгууллагууд эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байраар хангахдаа Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон байгууллагуудын хөдөлмөрийн дотоод журамд заасан болзол шалгуурын дагуу нээлттэй зохион байгуулж ажилласан. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацаанд сул орон тоог нөхөх 8 албан тушаалын хүсэлтийг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, сул орон тоог нөхөх журмын дагуу сонгон шалгаруулалт зарлаж төрийн албаны нөөцөд бүртгэлтэй 5 хүн төрийн захиргааны албан хаагчийн сонгон шалгаруулалтад тэнцэн мэргэжилтнээр ажилласан. Тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудад 62 ажилтныг шинээр ажлын байраар хангаснаас Эрүүл мэндийн газарт 5 хүн, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 43, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 11, Жаргалант сумын эрүүл мэндийн төвд 3 эмч, эмнэлгийн мэргэжилтэн шинээр ажлын байраар ханган хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлсэн байна.	100
2.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” болон Эрүүл мэндийн газрын дэргэдэх Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, ЭМС-ын 2019 оны А/406 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” болон Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны 2023 оны төлөвлөгөөг байгууллагын цахим хуудаст ил тодоор байршуулсан. Мөн Эрүүл мэндийн газрын албан хаагчийн үйлчилгээнд тавих шаардлага CS61-0020:2015-ыг байгууллагын цахим сайтад байршуулсан.	100
2.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн салбарт нийт 2006 эмч эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байгаагаас 440 их эмч, 487 сувилагч, 162 эм зүйч, 194 эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой, 54 нийгмийн эрүүл мэндийн ажилтан бусад ажилчид 419 ажилласан. Төлөвлөлтөөр хүний нөөцийн хангалт 92,6 хувь хэрэгжилттэй байна. Байгууллагын вэб сайтын ил тод цэсэд хүний нөөц хэсэгт ажлын байрны талаарх мэдээлэл, сул ажлын байрны зар болон хүний нөөцийн сургалт, хөгжил, нийгмийн баталгааг хангах, албан хаагчдын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр гарсан тушаал шийдвэр, дүрэм, журмыг байршуулан, тухай бүр шинэчлэн ил тод байдлыг ханган ажилласан. Хүний нөөцийн удирдлагын систем хөтлөлийг сайжруулж, тухай бүр шинэчлэн ажилласан. Эрүүл мэндийн ажилчдын нийгмийн баталгааг дэмжих чиглэлээр аймгийн Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 08 дугаар тогтоолоор 2021-2024 онд хэрэгжих “Эмч хөтөлбөрийг батлуулан, тайлант хугацаанд орон нутгийн төсвөөс 175,0 сая төгрөгийг шийдвэрлүүлэн, хэрэгжүүлж, хөтөлбөрийн хэрэгжилт 96,2 хувьтай байна. Тус хөтөлбөрийн үйл ажиллагааг сурталчлан ажилласан.	100

2.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, эрх зүйн баримт бичгүүд, орон нутаг, байгууллагаас гарсан шийдвэрийг цахим хуудас, мэдээллийн самбарт тогтмол байршуулан мэдээлж ажилласан. Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтэц, орон тоог Аймгийн Засаг даргын 2023 оны өдрийн А/84 дугаар захирамжаар баталж, 5 хэлтэст төрийн захиргааны 31 албан хаагч, төрийн үйлчилгээний 10 ажилтан нийт 41 албан хаагч ажилласан. Бүтэц, орон тооны батлагдсан тушаалыг Эрүүл мэндийн газар цахим хуудаст байршуулсан. Удирдах албан тушаалтнуудыг захиргааны зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд нээлттэйгээр байгууллагын вэб сайтад байршуулан ажилласан.	70
2.6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний ажилчдын цалин 15-18% нэмэгдсэнээр олгож байна. Засгийн газрын 2022 оны 489 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэл 20%, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 11/04 дүгээр тогтоолын дагуу орон нутагт ажилласны нэмэгдэл 40% нэмэгдсэнээр олгож байна. Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 03 сарын 01-ний Б/24, 2023 оны 08 сарын 21-ны Б/49 дугаар тушаалын дагуу Эрүүл мэндийн газрын 5 мэргэжилтэнд төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвийг журмын дагуу нэмэгдүүлсэн. Эрүүл мэндийн байгууллага бүр албан хаагчдын үр дүнг сар бүр үнэлж, урамшууллыг улирал тутам олгож ажилласан. Тухайлбал Эрүүл мэндийн газар нийт төсвийн 34%, БОЭТ нь нийт төсвийн 59%, Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн нийт төсвийн 74% -ийг цалин, шагнал урамшуулалд зарцуулсан байна. Тайлант хугацаанд төрийн одон медалиар 3, ЭМЯ-ны шагналаар 53, орон нутгийн шагналаар 211 эмч, эмнэлгийн мэргэжилтэн тус тус шагнагдсан байна. Шагнал урамшуулалд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны эзлэх хувь 10.5%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 01 хувиар өссөн байна. Урамшуулал, шагналын талаарх мэдээллийг тухай бүр www.or.mohs.gov.mn цахим хуудсанд байршуулан ил тод байдлыг ханган ажилласан.	100
Хэсгийн дундаж хувь-95%			
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх			
3.1.	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	Шилэн дансны хуулийн дагуу 2022 оны төсвийн гүйцэтгэл болон 2023 оны эхний 05 сарын төсвийн гүйцэтгэл, 2023 оны төсвийн төсөөллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн системд бүрэн байршуулсан.	100

3.2.	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	2022 оны 4-р улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн Эрүүл мэндийн яаманд 2023 оны 03 дугаар сарын 08-ны дотор бүрэн тайлагнасан. 2023 оны хагас жилийн санхүүгийн тайлан болон хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг тайлбарын хамт Эрүүл мэндийн яамны нэгтгэлийн тайланд бүрэн нэгтгүүлсэн.	100
3.3.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Төсвийн тухай хуульд заасны дагуу Эрүүл мэндийн газар болон эрүүл мэндийн салбар байгууллагуудын нэгтгэсэн санхүүгийн тайланг 2023 оны 01 дүгээр сарын 25-ны дотор Төрийн Аудитад хүлээлгэн өгч 2023 оны 02 дугаар сарын 25-ны дотор аудитын дүгнэлтийг гаргуулан, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчид холбогдох баримт материал, Төрийн аудитын дүгнэлтийн хамт 2023 оны 03 дугаар сарын 08-нд нэгтгүүлсэн. Мөн шилэн дансны нэгдсэн системд дүгнэлтийг бүрэн эхээр нь байршуулсан.	100
3.4.	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	ЭМДҮЗ-ын тогтоол, төлбөртэй тусламж үйлчилгээний журмын шинэчлэлт жагсаалтыг shilendans.gov.mn цахим хуудас болон www.orkhonboet.moh.gov.mn хуудас, самбарт байршуулсан. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгоход Улсын тэмдэгтийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.3-т зааснаар тэмдэгтийн хураамжийг төлүүлэн ажилласан. Эрүүл мэндийн газрын вэб сайтын Тусгай зөвшөөрөл цэсэд бүрдүүлэх материалын жагсаалтад тэмдэгтийн хураамжийн хэмжээг бичиж байршуулсан. Худалдаанд байгаа эмийн үнийг иргэдэд нээлттэй ил тод байдлыг хангахаар эмийн сангууд эмийн үнийг иргэдэд харагдахуйцаар байршуулан, Эрүүл мэндийн даатгалын үндэсний шинэчлэн батлагдсан тогтоолыг хэвлэмэл нэг төрлийн самбараар иргэдэд мэдээлэл өгч ажилласан.	100
3.5.	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	2023 оны эхний 12 сарын байдлаар батлагдсан төсвийн хуваарийн дагуу сар бүр төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг тайлбарын хамт шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хаягаар дамжуулан нийтэд ил тодоор мэдээлэн нийт давхардсан тоогоор 11 удаа мэдээлсэн байна.	100
3.6.	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	2023 оны эхний 12 сарын байдлаар батлагдсан төсвийн хуваарийн дагуу 5 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй худалдан авалтыг зардлын зүйл батлагдсан төсөв, гүйцэтгэлийн төсвийг өссөн дүнгээр 54 байгууллага, иргэний 6 нэр төрлийн ажил үйлчилгээгээр нийт 722.6 сая төгрөгийн гүйцэтгэлийг авч гэрээний нийт дүн, нийлүүлэгч байгууллага, хаяг шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хаягаар дамжуулан нийтэд ил тодоор мэдээлж ажилласан.	100

3.7.	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	2023 оны 12 сарын байдлаар батлагдсан төсөв болон нэмэлт дансаар нийт 24 удаагийн гүйлгээгээр 1.447.3 сая төгрөгийн орлого, 722.6 сая төгрөгийн зарлагын гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, олгосон, хүлээн авагчийн нэрийн хамт шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хаягаар дамжуулан нийтэд ил тодоор мэдээлж ажилласан.	100
3.8.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	2023 оны 12 сарын байдлаар нийт бараа материал хуваарилах, шилжүүлэхтэй холбоотой 8 тушаалаар нийт 315,4 сая төгрөг, 34 тушаал шийдвэрээр 894.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө зарцуулахтай холбоотой тушаалыг шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хаягаар дамжуулан нийтэд ил тодоор мэдээлж ажилласан.	100
3.9.	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	Шилэн дансны тухай хуульд заасны дагуу 2023 оны 12 сарын эхний байдлаар заавал байршуулах 5 талбарын 143 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулан олон нийтэд мэдээлсэн ба байгууллагын санхүүгийн ил тод байдлын самбар, байгууллагын цахим хуудаст бүрэн байршуулсан. 20 мэдээллийн хуулийн хугацаа нь болоогүй байна. Мөн 2022 оны санхүүгийн тайлангаар өгсөн Төрийн аудитын газраас ирүүлсэн аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын тайланг аудитын тайлангийн хамт шилэн дансны нэгдсэн системд бүрэн тайлагнасан.	100
3.10.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендер оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендер шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	Тайлант хугацаанд БОЭТ-д төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу эм эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур худалдан авах тендер нийт 61 багцад зарласан бөгөөд Тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж 2 /62,63/ багцыг зориулалтын дагуу задлан нийт 63 багцад 100% амжилттай зохион байгуулж, 22 компанитай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. Мөн 2023 онд худалдан авах ажиллагааны нийт төсөвт өртөгт 6,3 тэрбум төгрөг үүнээс нээлттэй тендер шалгаруулах журмаар 5,5 тэрбум төгрөг /87,3%/, ерөнхий гэрээгээр 80 нэрийн эм, 6 нэрийн эмнэлгийн хэрэгслийг 800 сая /12,7%-д худалдан авахаар 16 компанитай гэрээ байгуулан худалдан авч ажилласан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт төсөвт өртөг 6,3 тэрбум төгрөг байгаа нь 42,06%-аар нэмэгдсэн. Үүнээс нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 2.45 тэрбум төгрөг буюу 44,5%-аар, ерөнхий гэрээгээр 200 сая төгрөг буюу 75%-аар илүү төсөвлөгдсөн байна. Мөн худалдан авах ажиллагааг зөвхөн гэрээ байгуулсан 38 компаниас авч ажилласан.	100
3.11.	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;	Тайлант хугацаанд төрийн аудит, санхүүгийн хяналт дотоод аудит, дүгнэлтийг тухай бүрт shilendans.gov.mn цахим хуудас болон байгууллагын вэб сайтуудад, ил тод байдлын самбарт байршуулан, ажилчдын нэгдсэн хурал дээр танилцуулан ажилласан. Худалдан авах ажиллагаа хийгдээгүй.	100

3.12.	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;		-
3.13.	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	<p>Орон нутгийн төсвөөс 2.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс төсөл хөтөлбөрт нийт 960,0 сая төгрөгийг шийдүүлсэн. Тайлант хугацаанд 4 арга хэмжээг зохион байгуулж байна.</p> <p>Тайлант хугацаанд гадаадын төсөл 2 хэрэгжиж, хэрэгжилт дунджаар 95%-тай байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Жайка олон улсын байгууллага “Анхан болон хоёрдох шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах” төсөл-100% 2. Глобаль сан “сүрьеэгийн тохиолдлыг эрт илрүүлэх дадлыг дэмжих замаар үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, өвчтөн төвтэй нэгдсэн халамж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажиллагааг бүрдүүлж хэвшүүлэх, эмийн дасалттай сүрьеэгийн аюулд анхаарах” төсөл-90% 	100
3.14.	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	<p>Дэлхийн эмч нарын болон олон улсын сувилагчдын өдрийн хүрээнд Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж 30 илтгэл хэлэлцүүлэгдсэн байна. Тус эрдэм шинжилгээний бага хурлын зардалд орон нутгаас 14,6 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Хэлэлцүүлсэн илтгэлүүдийг “Анагаах увидас” сэтгүүлд эмхэтгэн 300 ширхгийг хэвлүүлж, эмч мэргэжилтнүүдийн гарын авлага болгосноос гадна судалгааны илтгэлүүдийг Эрүүл мэндийн газрын цахим хуудаст байршуулсан.</p> <p>Мөн “Эрүүл Эрдэнэт хүн” төслийн хүрээнд “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш байдал”-ын судалгаа хийгдэж аймгийн Засаг даргын шуурхай хуралд танилцуулагдаж судалгааны дүнг цахим байршуулсан.</p>	100
3.15.	Хууль тогтоомжид заасан бусад.	<p>Шинэчлэгдсэн ашиг сонирхлын зөрчил болон авлигын эсрэг хуулийг сурталчлах хүрээнд салбарын хэмжээнд 2 удаагийн сургалтад 132 удирдлага, эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулсан. Тухай бүр зөвлөмжөөр ханган ажилласан.</p> <p>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн үүрэг чиглэл, байгууллагын даргын батлагдсан удирдамжийн дагуу өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нөхөрлөлийн гишүүдийг хамруулсан уулзалт, хэлэлцүүлгийг аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Аудитын газар, Эрүүл мэндийн газрын удирдлагыг оролцуулан зохион байгуулсан. ХАСХОМ гаргалтын талаар соён гэгээрүүлэх ажлыг 75 албан хаагч нарыг хамруулан зохион байгуулсан.</p>	70

Хэсгийн дундаж хувь: 97,8%

Дөрөв.Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн

4.1.	<p>Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;</p>	<p>ЭМДҮЗ-ын тогтоол, төлбөртэй тусламж үйлчилгээний журмын шинэчлэлт жагсаалтыг shilendans.gov.mn цахим хуудас болон www.orkhonboet.moh.gov.mn хуудас, самбарт байршуулсан.</p> <p>Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах, хаяг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, улсын тэмдэгтийн хураамж, төлбөр төлөх дансны мэдээллийг www.or.mohs.gov.mn сайтын Тусгай зөвшөөрөл цэсэд байршуулж ил тод байдлыг хангасан.</p> <p>Худалдаанд байгаа эмийн үнийг иргэдэд нээлттэй ил тод байдлыг хангахаар эмийн сангууд, Эрүүл мэндийн даатгалын үндэсний шинэчлэн батлагдсан тогтоолыг хэвлэмэл нэг төрлийн самбараар эмийн үнийг иргэдэд харагдахуйцаар байршуулан мэдээлэл өгч ажилласан.</p>	70
4.2.	<p>Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.</p>	<p>Тайлант хугацаанд Эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс 7 удаа хуралдан тусгай зөвшөөрлийг шинээр 11 байгууллагад олгож, 30 байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацааг сунган, 4 байгууллагад нэмэлт тусламж үйлчилгээ олгож, 10 байгууллагад хаягийн шилжилтийг зөвшөөрч, 20 байгууллагын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэн, үүнээс 4 байгууллагын эрхийг сэргээж, 16 байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцалсан байна. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссыг шинэчлэн байгуулж, хяналтын байцаагч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгээс төлөөлөл оруулан хөндлөнгийн хяналттай ажилласан. Цахим программын шинэчлэлтэй холбоотой эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж буй байгууллагуудын гэрчилгээний хуулбаруудыг ЭМЯ-нд хүргүүлсэн. Тусгай зөвшөөрөл олголтын ил тод байдлыг хангах хүрээнд аймгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж буй байгууллагуудын мэдээлэл, тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл олгох үйл ажиллагааны эрх зүй, бүрдүүлэх материалын жагсаалтыг иргэд олон нийтэд ойлгомжтой байдлаар тухай бүрт шинэчлэн байгууллагын www.or.mohs.gov.mn сайтад байршуулан ил тод байдлыг ханган ажилласан.</p>	100

Хэсгийн дундаж хувь: 85%

Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал

5.1.	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;	Эрүүл мэндийн ажиллагсдын Үйлдвэрчний эвлэлийн хорооны 2023-2024 оны “Хамтын гэрээ”-нд саналыг Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс цахим хэлбэрээр нийт ажиллагсдаас авч төслийг танилцуулан хэлэлцүүлэн саналыг тусган батлуулан хэрэгжүүлсэн.	70
5.2.	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	Эрүүл мэндийн салбарын хэмжээнд оюуны өмчийн эрхийг 2 чиглэлээр авсан бөгөөд цахим хуудаст байршуулан сурталчлан ажилласан. Үүнд: - БОЭТ-ийн Төгсөлтийн дараах сургалтын төслийн хүрээнд “Ерөнхий мэргэшил судлал” –аар “Сувилагч мэргэжлээр суралцагчдын шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэх нь” зэрэг номуудад патент авсан. - Эрдэнэт сувиллын бага эмч Г.Цоодол нь “Парафин эмчилгээг зэстэй хослуулан хэрэглэсэн үр дүн”-ээр оюуны өмчийн эрх авсан байна. - “Сувилагч мэргэжлээр суралцагчдын шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэх нь” зэрэг номд оюуны өмчийн эрхийг авсан бөгөөд цахим хуудаст байршуулан сурталчлан ажилласан. Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалтыг цахимд байршуулан ил тод байдлыг ханган сурталчлан ажилласан	100
5.3.	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Баян-Өндөр сумын Цагаанчулуут багт байрлах Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төвийн шинээр барих барилгын захирамж батлагдан гарсныг цахимд байршуулан ил тод байдлыг хангасан.	100
5.4.	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Эрүүл мэндийн харьяа байгууллагуудын газрын мэдээллүүдийг цахим системд оруулан шилэн дансанд байршуулан ажилласан. Эрүүл мэндийн газрын шилэн дансанд эрүүл мэндийн салбарын 11 барилгыг зураг, тооцооллын хамт байршуулан ил тод байдлыг хангасан.	100
5.5.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;	2023 оны эхний 12 сарын байдлаар Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Жаргалант сумын эрүүл мэндийн төв, 2023 оны төсөв 46,6 тэрбум төгрөг батлагдсанаас Эрүүл мэндийн газар 48,7 сая, БОЭТ нь 874,1 сая төгрөг, Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь 31,5 сая төгрөг, нийт 954,3 сая төгрөгийг татварын санд, Эрүүл мэндийн газар 143,5 сая, Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 3.239,8 сая төгрөг, Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь 118,7 сая төгрөг, нийт 3.502,0 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлэн төлж 12 сарын байдлаар татвар болон нийгмийн даатгалын санд өр төлбөр үүсгэлгүй ажилласан.	100
5.6.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд 1 эмч, 1 сувилагч, 1 тусгай мэргэжилтэн сонгогдон, ЭМС-ын 2020 оны А/563 дугаар тушаалын дагуу олон нийтийн төлөөллийн мэргэжлийн нийгэмлэг 1, төрийн бус	100

	<p>зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;</p>	<p>байгууллагын 1 төлөөллийг ЭМЯ-тай хамтран сонгон шалгаруулж, БОЭТ-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 8 хүний бүрэлдэхүүнтэй болсон. Иргэн даатгуулагчийн төлөөллийг шалгаруулах нээлттэй сонгон шалгаруулалтыг цахимд байршуулан дахин зарласан. ЭМГ-ын даргын 2023 оны 01 сарын 31-ний өдрийн “Удирдлагын зөвлөлийг шинэчлэн батлах тухай” А/11 дүгээр тушаалаар УЗ-ийг 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталсан. Тайлант хугацаанд 14 удаа хуралдаж 56 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Шийдвэрийн хэрэгжилт 85 хувь байна.</p> <p>Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны 2 гишүүн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөнтэй холбоотой ЭМС-ын 2017 оны “Дүрэм батлах тухай” А/256 дугаар тушаалын дагуу сонгон шалгаруулах зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан зарлаж, сонгон шалгаруулалтаар шалгарсан 2 гишүүнийг томилох хүсэлтийг хүргүүлснээр Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны 2023 оны 22 дугаар тогтоолоор 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай томилсон.</p>	
5.7.	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;</p>	<p>Эрүүл мэндийн газрын 2022 оны А/57 дугаар тушаалаар байгуулагдсан Өмч хамгаалах байнгын зөвлөл нь 2023 оны ажлын төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэн ажилласан. Тус зөвлөл 3 удаа хуралдаж ЭМГ-ын Удирдлагын зөвлөлийн хурлаар 1 асуудлыг хэлэлцүүлж, шийдвэрийг хэрэгжүүлсэн. Эрүүл мэндийн газрын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 9 төрлийн 24 ширхэг хөрөнгийг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шилжүүлэхээр аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүсэлт хүргүүлж, Орхон аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/212 дугаар захирамжаар шилжүүлсэн. Байгууллагын албан хаагчийн хөрөнгийн картыг шинэчилж баталгаажуулсан. Эрүүл мэндийн газраас 17 нэр төрлийн хөрөнгийг акталж Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгсөн. Орон нутгийн өмчийн газарт 3 өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга байгууламж 8, газар 4, нийтийн эзэмшлийн талбай 5 нийт 17 нэр төрлийн 549,2 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэхээр аймгийн Засаг даргын захирамжид тусгуулсан.</p>	70
5.8.	<p>Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;</p>	<p>Аймгийн хэмжээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хувийн хэвшлийн Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг, Талын булаг клиникт МХЕГ-ын цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газраас тусгай зөвшөөрлийн дагуу рентген оношилгооны тоног төхөөрөмжүүдийг ашиглаж стандартын дагуу оношилгоог хийж ажилласан бөгөөд БШУГ-ын цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газраас тусгай зөвшөөрлийн дагуу цөм болон цацрагийн хяналтын улсын байцаагч хяналт тавьж ажилласан. Үүнд:</p>	100

		<ul style="list-style-type: none"> - БОЭТ-д ангиографийн аппарат 1, компьютер томографийн аппарат 1, суурин дижитал рентген аппарат 3, зөөврийн рентген аппарат 3 - Талын булаг ор бүхий клиникт зөөврийн дижитал аппарат 1 - Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэгт суурин дижитал рентген аппарат 1 - Эрдэнэт медиал төрөлжсөн төв эмнэлэг суурин дижитал рентген аппарат 2, маммограм аппарат 1 - Эрдэнэт сувилал цогцолбор суурин дижитал рентген аппарат 1 - Эрүүл мэндийн дэмжих төв суурин дижитал рентген аппарат 1 тус тус оношилгоо хийж ажилласан. <p>Рентген цацрагтай холбоотой орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл бүртгэгдээгүй.</p> <p>Тайлант хугацаанд “Ногоон ариусгал” ХХК-тай 66 эрүүл мэндийн байгууллага гэрээтэй ажиллаж халдвартай хог хаягдал 119934,7кг, хурц үзүүртэй, ирмэгтэй хог хаягдал 76383,8 кг, эмгэг хог хаягдал 253,73 кг, эсийн хог хаягдал 229,2кг, химийн хог хаягдал 6,7 кг устгасан байна. А/505 тоот тушаалын хэрэгжилтийг үнэлэх, эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор ажилтнуудад “Ногоон ариусгал” ХХК-тай хамтран эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдал хариуцсан 42 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж эрүүл мэндийн байгууллагуудын дэмжлэгт хяналтыг 28 байгууллагад хийж зөвлөмж хүргүүлэн ажилласан. Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны санхүүжилтээр аймгийн хэмжээнд хог хаягдлын нэгдсэн цэгт аюултай хог хаягдал хадгалах зориулалтын байр барих ажил 75%-тай явагдаж байна. Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2, Жаргалант сумын эрүүл мэндийн төвд 1 эмнэлгийн аюултай хог хаягдлыг ариутгах автоклав төхөөрөмж хуваарилагдан ирснээр 35458 кг эмнэлгийн аюултай хог хаягдлыг ариутган "Ногоон ариусгал" ХХК-д хүлээлгэн өгсөн байна.</p>	
5.9.	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	Тайлант хугацаанд шинээр ашиглалтад орсон барилга байгууламж байхгүй байна.	-
5.10	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ байхгүй.	-
5.11	Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	Байгууллагын or.mohs.gov.mn цахим хуудсанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу ил тод нээлттэй байршуулах мэдээллүүд байгууллагын эрхэм	100

		зорилго, зорилт, алсын хараа, үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт, тэргүүлэх чиглэл, эрүүл мэндийн чиглэлээрх төрийн бодлого, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төрийн үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, хурал, сургалтын илтгэл, хичээлүүд, хууль, эрх зүй, цаг үеийн мэдээ мэдээлэл, эрүүл мэндийн статистик мэдээлэл, зөвлөгөө, шилэн данс, төсөв санхүү, хүний нөөцийн ил тод байдал зэрэг нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй нээлттэй өгөгдөл мэдээллүүдийг ил тодоор og.mohs.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байршуулж ажилласан.	
5.12.	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;	Тайлант хугацаанд байгууллагын зардлаар суралцсан суралцагч байхгүй.	-
5.13.	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.	Тайлант хугацаанд нийт 131 удаагийн сургалт, сурталчилгаа зохион байгуулж давхардсан тоогоор 28288 иргэнийг хамруулж, тухай бүр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажилласан. Цахим хуудаст 644 төрлийн гарын авлага, шторка, зөвлөмжийг байршуулан 1588230 хандалттай байна. Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар нийт 107 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизтэй хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн.	100
Хэсгийн дундаж хувь: 94,0			
Хэрэгжилтийн дундаж хувь: 93,8%			

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН
БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ БИЕЛЭЛТ

Орхон аймгийн Эрүүл мэндийн газар

2023 оны 12 дугаар сарын 12

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1	Засгийн газраас төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо	90	143	Тайлант хугацаанд нийт 143 сургалт, семинар, зөвлөгөөн зохион байгуулснаас 40,6%-ийг байран дахь сургалт, 21,7%-ийг мэргэшүүлэх сургалт, 4.2%-ийг туршлага солилцох арга хэмжээ байгаа бөгөөд давхардсан тоогоор 1354 албан хаагч хамрагдсанаас удирдах албан тушаалтан 1,2%, гүйцэтгэх, туслах, албан тушаалтан 98,8%-ийг эзэлж байна. Нийт төрийн албан хаагч 579 ажиллаж байгаагаас сургалтад хамрагдсан нийт албан хаагчдад эзлэх хувь 100% байна. Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо өмнх оноос 9,1%-аар, хамрагдсан нийт албан хаагчдын тоо 1,7 дахин нэмэгдсэн байна. Доорх материалыг хавсаргав. Үүнд: 1. Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 1-ий өдрийн 13/05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөр” – ийн хүрээнд ЭМГ-аас хийсэн ажлын тайлан /Хавсралт 1/ 2. Аймгийн Засаг даргын 2023 оны А/84 дүгээр захирамжаар “Эмч” хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт /Хавсралт 2/ 3. Хүний нөөцийн богино хугацааны төлөвлөлт /2023 он/-ийн хэрэгжилт /Хавсралт 3/ 4. Төрийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөөний тайлан /Хавсралт 4/
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	50	58	
			Мэргэшүүлэх сургалт	20	31	
			Туршлага солилцох арга хэмжээ	5	6	
			Бусад	-	48	
		1.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо	800 /Давхардсан тоогоор/	1354 /Давхардсан тоогоор/	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	650	1101	
			Эрэгтэй албан хаагч	150	253	
			Удирдах албан тушаалтан	10	16	
			Гүйцэтгэх, туслах, албан тушаалтан	790	1338	
1.3	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал, нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	100%			
2		2.1	Нийт гадаад сургалт, семинар зөвлөгөөний тоо	5	11	Тайлант хугацаанд нийт 11 удаагийн гадаад сургалт, семинар зөвлөгөөнд зохион байгуулагдаж, 60 албан хаагч оролцсоноос удирдах ажилтан 6,7%, гүйцэтгэх, туслах

	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо	20	60	албан тушаалтан 93,3%-ийг эзэлж байгаа бөгөөд гадаад сургалт, семинар зөвлөгөөний тоо өмнөх оноос 3,7 дахин, хамрагдсан нийт албан хаагчдын 12 дахин нэмэгдсэн байна. /Хавсралт 5/
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	18	56	
			Эрэгтэй албан хаагч	2	4	
			Удирдах тушаалтан	2	4	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	2	56	
2.3	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь %	20-оос дээш	6,4	Нийт гадаадын 12 өндөр хөгжилтэй оронд ангиографи, нүүр ам судлал, бөөр судлал, хавдрын мэс засал, сувилахуй зэрэг чиглэлээр нийт 60 мэргэжилтэн туршлага судалж мэдлэг чадвараа нэмэгдүүлсэн нь эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийт албан хаагчдын 6,4%-ийг эзэлж байгаа нь өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 6,2%-аар өссөн байна. /Хавсралт 5/		
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1	Албан хаагчдын сургалт хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ /сая төгрөг/	ОНТ 80.0	ОНТ 98.8 Байгууллагын төсөв 95.1	Албан хаагчдын сургалт хөгжлийн үйл ажиллагаанд 193,9 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оноос 113.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь 58.7 хувиар нэмэгдсэн байна. <ul style="list-style-type: none"> - Төрийн болон өөрийн зардлаар мэргэшүүлэх сургалтад хамрагдсан 21 эмч эмнэлгийн ажилтанд 43,4 сая төгрөгийн цалин хөлс - Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн эрдэм шинжилгээний судалгааны ажлын зардалд 6,8 сая - “Сувилахуй ба эрх зүй”, гэмтлийн чуулга уулзалт чуулга уулзалтад 15.2 сая - Дотоод хяналт эрсдэлийн менежментийн ажилтан бэлтгэх сургалтад 2.5 сая - Олон улсын чанарын менежментийн сургалтад 2.5 сая - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтныг мэргэшүүлэх сургалтад 9.0 сая - Уламжлалт анагаах ухааны эмч нарыг чадавхжуулах сургалтад 1.5 сая - “Анагаах увидас” эрдэм шинжилгээний сэтгүүл хэвлүүлэхэд 7.0 сая төгрөг - Гадаад сургалт - 54.3 сая төгрөг - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн гүйцэтгэлийн санхүүжилтээр сургалтын зардал 54,2 сая
		3.2	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөн хувь	15-аас доош	12,3%	Тайлант хугацаанд 579 төрийн албан хаагч ажилласан. Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь 12,3% /71/, өмнөх оноос 0,3%-аар нэмэгдсэн байна.Тус хугацаанд

						шинээр ажлын байраар хангагдсан албан хаагчийн тоо 76 буюу нийт албан хаагчдын 13,1 хувийг эзэлж байна. Шилжилт хөдөлгөөний тайланг хавсаргав. /Хавсралт 6/
4	Цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1	Цалин, шагнал урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	64,5%	55,7%	Тайлант хугацаанд нийт 267 эмч эмнэлгийн мэргэжилтэн шагнал урамшуулалд хамрагдаж, шагнал урамшуулалд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны эзлэх хувь 10.5 болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1%-иар өссөн байна Эрүүл мэндийн газар нийт төсвийн 34%, БОЭТ нь нийт төсвийн 59%, Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн нийт төсвийн 74% -ийг цалин, шагнал урамшуулалд зарцуулсан байна.
		4.2	Нэгж албан хаагчид олгох хоол унааны нэмэгдэл /мян.төг/	5000 төгрөг	Хоол, унааны нэмэгдэлд: - ЭМГ 16500 төг, - БОЭТ 3000 төг, - Жаргалант сумын эрүүл мэндийн төв 5000 төг	- ЭМГ нь 2023 онд байгууллагын дотоод журамд заасны дагуу хоолны унааны нэг өдрийн зардал 4500 төгрөг байсныг 08 сарын 01-ний өдрөөс эхлэн албан хаагчдын нэг өдрийн хоолны мөнгө 13500 төгрөг, унааны мөнгийг 3000 төгрөгөөр нийт 16500 төгрөг болгон нэмэгдүүлсэн. Тайлант хугацаанд хоол унааны нэмэгдэлд нийт 64.0 сая төгрөг олгосон. - Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын унаа, хоолны хөнгөлөлт, нэмэгдэл урамшуулал олгох тухай” А/548 тоот тушаалын дагуу ажилтнуудын унаа хоолны зардлыг өдрийн 3000 төгрөгөөр тооцож, тайлант хугацаанд 527 ажилтанд 279.3 сая төгрөгийг олгосон. - Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь ажилчдын хоол унааны зардалд өдөрт 5000 төгрөгөөр тооцож, тайлант хугацаанд нийт 26.4 сая төгрөгийг олгосон байна.
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн /Албан хаагчдын сэтгэл ханамж/	80%-аас дээш	81,9%	- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төрийн албан хаагчийн ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааг авахад сэтгэл ханамж 70%тай байна. Нийт 21 асуумжаар цахим хэлбэрээр судалгааг авсан. Сэтгэл ханамж өссөн үзүүлэлтийг дүгнэхэд, ажилчдын ажлын байрны ажил үүрэг тодорхой, сургалт хөгжлийн чиглэлээр дэмжлэг үзүүлж байгаа нь давуу талтай байна. Сэтгэл ханамжийн судалгааны үеэр дийлэнх санал нь хүний нөөцийн болон цалин хөлстэй холбоотой санал гарснаар саналын мөрөөр Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 34 орон тоог хангаж ажилласнаар ажлын ачаалал тэнцвэржсэн сайн үзүүлэлтэй байна.

						<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн газрыг албан хаагчдын сэтгэл ханамж 88,2%-тай байна. Албан хаагчдын сэтгэл ханамжид хамгийн их хамааралтай хүчин зүйлс нь байгууллагын дотоод орчин, ажлын байрны тав тух, ажлын ачаалал, хамт олны харилцаа хандлага зэрэг орчны нөлөө, шагнал урамшуулал, үнэлгээний шударга зарчим зэрэг байна. - Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн ажилтнуудын сэтгэл ханамж 87,5%*тай байна. Сэтгэл ханамжийн судалгааны үеэр дийлэнх санал нь хүний нөөцийн болон цалин хөлстэй холбоотой санал гарсан тул ажилтнуудад 13 дахь сарын олгож, Төрийн албан хаагчийн хөгжил хөтөлбөрт 9 ажилтныг хамруулж, 23.0 сая төгрөгийн урамшуулалд хамруулан, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх арга хэмжээ авсан.
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах урьдчилан сэргийлэх	6.1	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг /жилд/	1-ээс дээш	1 удаа	<ul style="list-style-type: none"> - Тайлант хугацаанд 579 төрийн албан хаагчийн 523 буюу 90,3%-ийг Эрүүл мэндийн сайдын А/340 дүгээр тушаалын дагуу урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. - Лабораторийн шинжилгээний дүгнэлтээр ажилчдын 12.3% нь, дурангийн шинжилгээний дүгнэлтээр ажилчдын 20,1% нь өөрчлөлттэй гарсан. Урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлтээр түр хугацаагаар эрүүл мэндийн хувьд тэнцээгүй 2, эрүүл мэндийн эрсдэлтэй ажилтны тоо 3, нэмэлт шинжилгээ хийлгэх ажилчид 14 байна Амбулаториор онош тодруулж, эмчлүүлэх шаардлагатай ажилчдын тоо 31, стационарт онош тодруулах хэвтэн эмчлүүлэх шаардлагатай ажилтнуудын тоо 18 байна. Хавдрын шинжилгээгээр өөрчлөлттэй гарсан 2 ажилтан Хавдар судлалын үндэсний төвд эмчлүүлж байна. Хэвтэн эмчлүүлэх шаардлагатай 22 ажилтан нарийн мэргэжлийн эмчийн хяналтад хэвтэн эмчлүүлсэн. 40-ээс дээш насны нийт 400 ажилтныг бамбай булчирхайн дааврын шинжилгээнд хамруулснаас 49 ажилтан өөрчлөлттэй гарсныг нарийн мэргэжлийн эмчийн хяналтад оруулж, эмчлэн эрүүлжүүлсэн байна. - Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь Цацраг идэвхт тоног төхөөрөмжтэй харьцаж ажилладаг дүрс оношилгооны тасгийн 13 ажилтныг Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл мэндийн төвд урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулахад дэмжлэг үзүүлж тус бүр 120.0

						мянга төгрөг, нийт 1.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. /Хавсралт 7/
		6.2	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	96.0%	Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудын ажилчдын 90.3%-ийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлтээр өөрчлөлттэй гарсан эрүүл мэндийн ажилтны 96%-ийг эмчлэн эрүүлжүүлсэн бөгөөд 4% нь үргэлжлүүлэн эмчийн хяналтад эмчлүүлж байна. “Эмч” хөтөлбөрөөс эмчлэн эрүүлжүүлэх шаардлагатай 15 ажилтанд 13.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ /сая төгрөг/	ОНТ 60.0 сая	ОНТ 37,1 Байгууллагын гүйцэтгэлийн санхүүжилт 44,5	Тайлант хугацаанд нийгмийн дэмжлэгт нийт эрүүл мэндийн ажилтны 24.4% нь хамрагдаж нийт 81.6 сая төгрөгийг эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг дэмжихэд зарцуулсан нь өмнөх оноос 1,3 дахин нэмэгдсэн байна. Үүнд: - “Эмч” хөтөлбөрөөс эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг дэмжин 37.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. - Байгууллагын өөрийн зардлаар орон байрны дэмжлэг болон шагналд 44.5 сая төгрөгийг зарцуулсан байна.